



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ
“ЭРДЭНЭ МОНГОЛ” ХХК-ИЙН “БАЯНХӨНДИЙ АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021444/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2718243/

Хянасан:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны
Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын
ахлах шинжээч/Ц.Жаргалнэмэх/

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал
жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн:...../Б.Наранбаатар/

Биелэлтийг тайлагнасан:

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал:...../А.Билгүүн/

Байгаль орчны ахлах ажилтан:...../Э.Өнөрзаяа/



2025 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн зорилго	5
1.2. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа	5
1.3. Ил уурхай	5
1.4. Хүдэр боловсруулах үйлдвэр	7
1.5. Хаягдлын нэгдсэн байгууламж	7
БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
2.1. Зорилго, зорилт	9
2.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	9
2.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10
2.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	32
2.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	40
2.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	44
2.7. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	44
2.8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	45
2.9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	53
2.10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	61
2.11. Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	75
2.12. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	77
2.13. БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	78
БҮЛЭГ 3. ДҮГНЭЛТ	82
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	84
<i>Хавсралтын жагсаалт</i>	<i>85</i>

ЗУРАГ

Зураг 1. Ил уурхай (2025.10.06).....	6	
Зураг 2. Хүдэр боловсруулах үйлдвэр (2025.10.09).....	7	
Зураг 3. Хаягдлын нэгдсэн байгууламж (2025.10.09)	8	
Зураг 4. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн жагсаалт	10	
Зураг 5. Замын тэмдэг.....	11	
Зураг 6. Шимт хөрсний овоолго	11	
Зураг 7. Хөрсийг бохирдлоос сэргийлэх хамгаалалт.....	12	
Зураг 8. Автомашины хурд хэмжилт	12	
Зураг 9. Санал асуулга	13	
Зураг 10. Зам, талбайн усалгаа	13	
Зураг 11. Замын сайжруулалт	14	
Зураг 12. Химийн бодисын агуулах	14	
Зураг 13. ВКW-21 худаг	15	
Зураг 14. Ургамлын бичиглэл хийж байгаа байдал	15	
Зураг 15. Өвсөн дөрвөлж.....	16	
Зураг 16. Нүүдлийн усны шувууд	16	
Зураг 17. “Эрдэнэ” сансрын дохиололтой хүзүүвчтэй мазаалай баавгай.....	17	
Зураг 18. Дуу шуугианаас хамгаалах арга хэмжээ	17	
Зураг 19. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн (Нөлөөллийн бүсийн иргэн Д.Б-ийн өвөлжөө, төслийн талбайгаас 1.9 км-т).....	18	
Зураг 20. Иргэдэд танилцуулга хийж буй байдал.....	18	
Зураг 21. “Амралтаараа ажиллая” хөтөлбөрт оролцогчид (2025.06.30).....	19	
Зураг 22. Шимт хөрсний хэлбэржүүлэлт (2025.10.19).....	32	
Зураг 23. Шимт хөрсний овоолгын арчилгаа.....	33	
Зураг 24. Бортгонд үрээр бэлтгэсэн суулгацын тоо, 2025 он	33	
Зураг 25. Мод тарьсан талбай.....	34	
Зураг 26. Усалгааг дэмжих хувин	35	
Зураг 27. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай.....	35	
Зураг 28. Биотехникийн арга хэмжээ	40	
Зураг 29. Нутгийн иргэдийн тарьсан мод	41	
Зураг 30. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан мод, хувиар (2025 он).....	41	
Зураг 31. Дадлага сургуулилалт.....	46	
Зураг 32. Синилийн хүчил мэдрэгч	Зураг 33. Синилийн хүчил хэмжигч	47
Зураг 34. Тэсэлгээний мэдэгдэл	47	
Зураг 35. Тэсэлгээний чичирхийлэл хэмжигч	48	
Зураг 36. Гуравдугаар зэрэглэлийн хогийн цэг	53	
Зураг 37. Хог шатаах зуух, пресслэгч машин	54	
Зураг 38. Аюултай хог хаягдал хадгалах талбай	54	
Зураг 39. Энгийн хог хаягдлын шилжүүлэлт	54	
Зураг 40. Аюултай хог хаягдлын шилжүүлэлт	55	
Зураг 41. Хог хаягдлын сургалт	56	
Зураг 42. Ням гарагийн цэвэрлэгээ	56	
Зураг 43. Мониторингийн цэгүүдийн байршил	61	

Зураг 44. Агаарын чанарын хэмжилт	62
Зураг 45. Хэмжилт хийж байгаа малчдын худгуудын байршил	62
Зураг 46. Нутгийн иргэдтэй хийсэн хэмжилт	63
Зураг 47. Хаягдлын нэгдсэн байгууламжийн хяналтын цооног	64
Зураг 48. Ургамлын бичиглэл	64
Зураг 49. Бүртгэгдсэн амьгад.....	65
Зураг 50. Жороо тоодог шувууны ажиглалт хийсэн талбай	65
Зураг 51. Уртын гол багийн ИНХ (2025.06.09)	79
Зураг 52. Нээлттэй хаалганы өдөрлөг (2025.10.18)	79

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Ашиглаж байгаа тоног төхөөрөмж.....	6
Хүснэгт 2. БОМТ-г хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, 2025 он	9
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	20
Хүснэгт 4. Түүсэн үрийн хэмжээ, 2025 он	33
Хүснэгт 5. Тарьсан мод, 2025 он	34
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт.....	36
Хүснэгт 7. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан мод, 2025 он	40
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	42
Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	44
Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	45
Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	49
Хүснэгт 12. Хог хаягдлын ангилал, тэдгээрийг устгах аргууд	55
Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	57
Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	66
Хүснэгт 15. Хяналт шалгалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт	76
Хүснэгт 16. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт.....	77
Хүснэгт 17. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнаж, хэлэлцүүлсэн байдал	80
Хүснэгт 18. БОМТ-ний хэрэгжилтэд зарцуулсан зардал, 2025 он.....	82

ОРШИЛ

“Эрдэнэ Монгол” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2-р багийн нутаг дэвсгэрт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хөндий нэртэй талбайд “Баянхөндий алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах” төслийг хэрэгжүүлэхээр олборлолт, үйлдвэрлэлийг цогцоор бүтээн байгуулах ажлыг гүйцэтгэж байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахын тулд байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд сайн туршлага, менежментийг нэвтрүүлж олон нийтэд нээлттэй, хариуцлагатай уул уурхайн жишиг төсөл болох зорилго тавин ажиллаж байна.

“Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Журам батлах тухай” А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д зааснаар боловсруулан мэдээллийн санд оруулж, төлөвлөгөө 2025 оны 03 дугаар сарын 27-нд батлагдсан.

Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Хууль хэрэгжүүлж ажиллах тухай” 169 тоот албан бичгийн дагуу шинэчлэн боловсруулж, 06 дугаар сарын 09-нд хянагдан, 07 дугаар сарын 08-нд батлагдсан.

Эко трейд ХХК-ний 2021 онд боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөлтэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2021-2025)-нд тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээний заалтуудаас 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан энэ оны БОМТ-г боловсруулав.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр хангах зэрэг олон хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж, төсөл хөгжүүлэлтийн үе шатанд өөрчлөлт орсноор барилга угсралтын ажил 2023 оны 07 сард эхэлсэн ба уурхайн олборлолтын үйл ажиллагаа 2025 оны 05 дугаар сарын 07-нд эхэлж, хүдэр боловсруулах үйлдвэр 09 дүгээр сарын 14-нд ашиглалтад орсон.

Ордын нөөц өссөн нь БОННУ гүйцэтгэж байх үеийн төлөвлөлтөд өөрчлөлт орох үндсэн нөхцөл болсон ба дээр дурьдсан шалтгаануудын улмаас 2021 – 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-д тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон тул БОННУ-ний тайланд тодотгол оруулах ажлыг Грийн ассессмент ХХК-аар гүйцэтгүүлж байна.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн зорилго

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хөндий эрдсийн дүүргийн алтны үндсэн ордуудыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан эрхзүйн актуудыг мөрдлөг болгож, үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэн, эдийн засгийн үр ашигтайгаар байгалийн баялгийг зохистой ашиглах дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн, технологийн горимыг нарийн чанд баримталж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, компанийн ажилтнууд болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талуудад хүртээхэд төслийн зорилго оршино.

1.2. Төслийн хүчин чадал, хэрэгжих хугацаа

Хөндий талбайд хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, ордын уулын техникийн нөхцөл, геологийн тогтоц, уурхайн ашиглалтын жилүүдэд уулын цул олборлолтын хэмжээг жигд байлгах зэргээс хамаарч ил ордыг ил аргаар ашиглах 7 жилийн хугацаанд 74.12 сая.тн уулын цул, үүнээс 14.90 сая.тн хүдэр олборлож, 59.22 сая.тн хөрс хуулна, хөрс хуулалтын дундаж коэффициент 3.97 тн/тн байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг ашиглах ил уурхайн төлөвлөлтийг төслийн бүтээн байгуулалтын ажлын нийт хэрэгцээ шаардлагад нийцүүлэх байдлаар гүйцэтгэсэн болно. Ил уурхайн ашиглалтын хугацаанд нийт 450.90 мян.м³ уулын цул, үүнээс 266.65 мян.м³ барилгын материал олборлож, 184.25 мян.м³ хөрс хуулна. Хөрс хуулалтын дундаж коэффициент 0.69 м³ байна.

Хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 650.0 мян.тн/жил ба төсөл хэрэгжих 10 жилийн хугацаанд 3.11 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 5,719.76 мян.тн хүдэр, үүнээс эхний жил 3.80 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.37 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 300.0 мян.тн хүдэр, 2-4 дэх жилд 4.00 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.51-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 5-7 дахь жилд 3.10 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.32-1.90 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,950.0 мян.тн хүдэр, 8-10 дахь жилд 1.84-1.85 гр/тн алтны дундаж агуулгатай, 1.08-1.10 гр/тн мөнгөний дундаж агуулгатай 1,519.76 мян.тн хүдрээр тэжээхээр төлөвлөсөн.

1.3. Ил уурхай

Уурхай жилд 350 хоног ажиллаж, 15 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байхаар ТЭЗҮ-д тусгагдсан. Уурхайн хөрс хуулалтын ажил 2025 оны 5 дугаар сарын 07-нд эхлэн, хоногт 2 (өдөр/шөнө) ээлжээр ажилладаг бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 11 цаг байхаар төлөвлөгдсөн.

Ил уурхай 2025 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар уулын цулаар 778,634 м³ уулын ажил, 736,176 м³ хөрс хуулалт, 132,948 тн хүдэр олборлолтын ажил хийгдсэн.



Зураг 1. Ил уурхай (2025.10.06)

Олборлолтын үйл ажиллагаанд дараах тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ашиглаж байгаа тоног төхөөрөмж

№	Тоног төхөөрөмж	Марк	Багтаамж	Нэгж	Хэмжих нэгж	Тоон утга	Зориулалт
2.	Экскаватор	Hyundai 520	3.2	м ³	ш	2	Хөрс хуулалт.
3.	Экскаватор	Hyundai R1250	6.7	м ³	ш	1	Хүдэр олборлолт
4.	Автосамосвал	Tonly TL875K	60	тн	ш	7	Материал тээвэрлэх буулгах, хаягдал тээвэрлэх
5.	Автосамосвал	Tonly TL875K	60	тн	ш	1	
6.	Утгуурт ачигч	Hyundai HL780-9s XTD	7	м ³	ш	1	Шимт хөрс ачих. Бутлуур тэжээлт
7.	Утгуурт ачигч	Hyundai HL780-9s XTD	5	м ³	ш	1	Бутлуур тэжээлт
8.	Автогрейдер	GR3005Tpro	3.5	м	ш	1	Зам талбай хусах, тэгшлэх
9.	Бульдозер	Shantui DH46	20	м ³	ш	1	Шимт хөрс хуулах, хүдрийн овоолгын суурийн талбай тэгшлэх
10.	Бульдозер	Shantui SD34-C3	10	м ³	ш	1	Ажлын доголд ул талбай түрэх, тэгшлэх
11.	Бульдозер	Komatsu 275A	13.7	м ³	ш	1	Технологийн зам түрэх, шимт хөрс хуулах
12.	Гэрэлт цамхаг	XFM968L			ш	6	Шөнийн ээлжинд ажлын талбай гэрэлтүүлэх
Нийт						22	

1.4. Хүдэр боловсруулах үйлдвэр

Хүдэр боловсруулах үйлдвэр нь бүрэн автомат ажиллагаатай, жилд 650.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай, анхдагч хүдрийг I шатны бутлалт, II шатны нунтаглалт, ангилалт, уусгалт, шингээлтийн СІР технологиор баяжуулж, десорбци электролизийн процессоор алтыг ялган авдаг. Үйлдвэрийн боловсруулалтаас гарсан хаягдлыг “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартын шаардлагад нийцүүлж, саармагжуулан, хоргүйжүүлж, филтер прессээр шүүж шахан, хаягдлын нэгдсэн байгууламжид нийлүүлдэг. Хаягдлын нэгдсэн байгууламжид нийлүүлсэн хатуу хаягдлын чийглэг нь 2025 оны 09 дүгээр сарын дунджаар 18.8%-тай байв.



Зураг 2. Хүдэр боловсруулах үйлдвэр (2025.10.09)

1.5. Хаягдлын нэгдсэн байгууламж

Хүдэр боловсруулах үйлдвэрийн 4,080,000 м³, ил уурхайн 36 сая.м³ буюу 72.6 сая.тн хөрс багтаах хүчин чадалтай 37.4 га талбайд хөрс боловсруулалт болон доторлогооны ажлыг зураг, төслийн дагуу 3 хувааж гүйцэтгэхээр Гложек консалтинг ХХК-аар гэрээлэн, хүдэр боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлыг тээвэрлэх ажлыг Өсөх урам ХХК-аар гэрээлэн гүйцэтгүүлж байна. Тайлант хугацаанд буюу 10 дугаар сарын 01-ний байдлаар хүдэр боловсруулах үйлдвэрийн 22,187 м³, 58,108.75 м³ уурхайн, нийт 80,295.75 м³ хаягдлыг байршуулаад байна (Зураг 3).



Зураг 3. Хаягдлын нэгдсэн байгууламж (2025.10.09)

БҮЛЭГ 2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. Зорилго, зорилт

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн “Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын 2025 оны 04 сарын 17-ны өдрийн “Хууль хэрэгжүүлж ажиллах тухай” 169 тоот албан бичгийн дагуу “Эко трейд” ХХК-ийн 2021 онд боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөлтэй алтны үндсэн ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2021-2025)-нд тусгагдсан байгаль хамгаалах арга хэмжээний заалтуудаас 2025 онд хэрэгжүүлэх Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хөндий ордын 2025 оны уулын ажлын, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах уулын ажлын, 7 дахь жилд гүйцэтгэх хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан шинэчлэн боловсруулсан бөгөөд энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг зорилго болгосон.

2.2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон тусгасан. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 300,00 сая төгрөг төлөвлөж 449,850 сая төгрөг, Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөнд 82,50 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 210,730 сая төгрөгийг зарцуулсан (Хүснэгт 2).

Хүснэгт 2. БОМТ-г хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, 2025 он

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, сая.төг
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	91,282.630
2.	Нөхөн сэргээлт	210,728.235
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	100,600
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6.	Осол, эрсдэлийн менежмент	Үйл ажиллагааны зардлаас
7.	Хог хаягдлын менежмент	181,762.496

8.	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	7,020.700
9.	Удирдлага, зохион байгуулалт	Үйл ажиллагааны зардал + 65,136.900
10.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах	Үйл ажиллагааны зардал + 4,047.0
Нийт		449,850
Тэрбум мод хөтөлбөр		210,730

2.3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Ашигт малтмалын олборлолт, үйлдвэрийн боловсруулалтын үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлж болох гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлж, нөлөөллийн үр дүнг хянах орчны шинжилгээг давтамжтай хийлгэж, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг оновчтойгоор төлөвлөн хэрэгжүүлж, хууль эрхзүйн нийцлийг ханган ажиллаж байна.

Хяналтгүйгээр хөрс, газрын хэвлий, ургамлын нөмрөгт нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх зорилгоор газар шорооны ажлыг зөвшөөрөл авч эхлүүлэх, хаах үйл явц нь “OHSE.EM.418.Ухалт, малталтын ажил гүйцэтгэх журам”-аар зохицуулагддаг ба тус ажлыг гүйцэтгэж дуусгааад, зөвшөөрлийг хааснаар ажил дуусгавар болно.

Тайлант оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд 18 удаа газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдсон.

Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл тус бүрд тухайн ажлын талаарх мэдээлэл, түүнийг гүйцэтгэхийг зөвшөөрсөн баталгаажуулалт, байршлыг харуулсан .dwg зураг, ажил эхлэхийн өмнөх, ажил гүйцэтгэсний дараах нөхцөл байдлыг фото зургаар баритмжуулан, хавтсыг үүсгэж Sharepoint-д байрлуулав.

Бид ArcGIS pro, AutoCAD зургийн программудыг худалдан авч, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Тухайлбал, ArcGIS pro программд газар шорооны ажил хийх бүртгэлийг хөтөлж, AutoCAD программд талбайг тэмдэглэж хэвшсэн (Зураг 4).

Газар шорооны ажлын зөвшөөрлийн дугаар	Талбайн нэр	Хариуцагч аж ахуйн нэгжийн нэр	Төлөв	Одгосон огноо	Хаасан огноо	Эвэрэлд өртөх талбайн хэмжээ, м2	Шингт хэрс (м ³)	Бүлэгмэдэ
EP-45	Задгай усан сангийн барилгын суурь	М-Сн-Эс Проперти	Хаагдсан	2025.02.20				
EM-LD-24	Шугам хоолойн урсгалт	Глобекс консалтинг ХХК	Нээлттэй	2025.03.17				
EM-LD-25	110/11 КВ дэд станцаас ХБ-7003 шингэн кабель татах, шуудуу урхах ухлагын ажил	М-Сн-Эс Интернэшнл	Хаагдсан	2025.04.26	2025.05.02	450	180	
EM-LD-26	Байнга ашиглагдах гадаргуун технологийн замын шингт хөрс хуудас (уулын бэлтгэл ажил)	Эрдэнэ Монгол ХХК	Хаагдсан	2025.04.26	2025.07.31	68500	20550	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-27	Ил уурхай	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.04		37.2 га	111892	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-28	ROM PAD /хүдрийн овоолго/	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.04		14.3 га	42902	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-29	SUB GRADE /тодорхой нөхцөлд эдийн засгийн үр өгөөжтэй хүдрийн овоолго	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.07		2.2 га	6800	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-30	Шингт хөрсний овоолго	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.07		6.2 га	18712	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-31	Үерийн усны хамгаалалтын далан, далан руу явах зам	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.13		2.6 га	7819	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-32	ШТС-ын урд туслах зам	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.05.25		1700	510	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-33	Товог төмөр замын зогсоолын талбай	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй			4.8 га	14000	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-34	Хайгуулын геологич кемп явах зам	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.06.13		3000	900	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-35	Тур худар буулгах талбай	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.07.11		4900	1491	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-36	Ядуу агуулгатай хүдэр буулгах талбай /Min waste/	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.07.28		19.8 га	59490	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-37	Шингт хөрсний овоолго-2	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.07.30		6.5 га	19693	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-38	Тур худар буулгах талбай-2	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.08.05		23590	7077	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-39	Үйлдвэрээс хяналтын нэгдсэн сан руу тээвэр хийх зам	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.08.04		2.9 га	3884	Шар хотир, зэвгэнэт
EM-LD-40	Хавдлын нэгдсэн сангийн хүрээ	Эрдэнэ Монгол ХХК	Нээлттэй	2025.09.16		78 га	152000	Шар хотир, зэвгэнэт


Зураг 4. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн жагсаалт

“Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын дагуу Хөндий талбайн үндсэн болон туслах замуудын уулвар, эргэх тойруу, салах хэсгүүдэд нийт 102 ширхэг заах, анхааруулах, хориглох тэмдэгүүдийг байршуулахын зэрэгцээ орон нутгийн автотээврийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. Мөн Баянхөндий уурхайгаас Шинэжинст сум хүртэлх замын эрсдэлтэй эргэлт, далантай хэсгүүдэд 280 ширхэг цацруулагчтай шон байрлуулсан (Зураг 5).



Зураг 5. Замын тэмдэг

Шимт хөрсний овоолгыг “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартад 5 хүртэлх метрийн өндөртэй үүсгэхийг зөвшөөрдөг. 2025 оны 10 сарын 06 өдрийн байдлаар Баянхөндий ил уурхайгаас 119,588.61м³, Мазаалай кэмпийн урд талаас 10,848м³ шимт хөрс, нийт 130,436.61м³ шимт хөрсний овоолгыг 6.8 га талбайд 4 метрийн өндөртэй үүсгээд байна (Зураг 6).



Зураг 6. Шимт хөрсний овоолго

Асгаралт үүссэн тохиолдолд компанийн гүйцэтгэх захирлын 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдөр EM 2023/0002.01 тоот тушаалаар батлагдсан “OHSE.EM.602 Асгаралтын хариу арга хэмжээний журам”-аар зохицуулалтыг хийж, ажилладаг.

Тайлант оны эхний 07 сарын хугацаанд ямар нэгэн асгаралт үүсээгүй, 08 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 25-ны хооронд түлшний машинаас 3 удаа үүссэн асгаралтууд техникийн бэлэн байдал бүрэн хангагдаагүй, операторын ажиллагаанаас шалтгаалсныг осолд дөхсөн тохиолдлын судалгаагаар тогтоосон тул уг машиныг ашиглалтаас гаргаж, операторт давтан зааварчилгаа олгосон. Хөрсийг шатах, тослох материалаар

бохирдуулахаас сэргийлэх зорилгоор түлшний сав, ашигласан тос хадгалах сав, тосоор бохирдсон хөрс саармагжуулах талбай зэргийг флэнк, бетоноор тусгаарласан (Зураг 7).



Зураг 7. Хөрсийг бохирдлоос сэргийлэх хамгаалалт

Замын хөдөлгөөнд оролцоходоо зөвхөн тогтоосон замаар зорчдог ба салаа зам үүсгэхийг хориглодог. Бараа материал, хүнс, хүн тээвэр Улаанбаатар хотоос Баянхонгор аймгийн төв хүртэл улсын чанартай автозамаар, Баянхонгор аймгийн төвөөс Баянхөндий уурхай хүртэл аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлийг баримтлан, зорчиж байна.


Тусгай зөвшөөрөлтэй талбай, тээврийн зам дагуу шаардлагатай цэгүүдэд зохих замын тэмдэг, тэмдэглэгээг байрлуулсан ба компанийн гүйцэтгэх захирлын баталсан “OHSE.EM.101 Замын хөдөлгөөний журам”-аар төслийн талбай дахь замын хөдөлгөөнийг зохицуулан, мөрдлөг болгодог.

Төслийн талбайд зорчих 168 тээврийн хэрэгсэлд стикер дугаар, замын хөдөлгөөнд оролцох жолоо барих эрхийг 233 ажилтанд олгожээ. “OHSE.EM.101. Уурхайн замын хөдөлгөөний журам”-ыг шинэчлэн, Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн А/14 тоот тушаалаар батлуулсан бөгөөд уурхайн бүсэд хурдны хязгаарыг 40км/ц хүртэл байхаар тогтоож өгсөн. Шинэ ажилтны сургалт, төслийн талбайд жолоо барих эрх олгох сургалтаар хурдны дээд хязгаарын мэдээллийг нарийвчлан заадаг. Хурд хэмжигчээр төслийн талбайд замын хөдөлгөөнд оролцож буй бүх техникт хуваарийн дагуу хурдны хэмжилт хийж, хурд хэтрүүлсэн ажилтнуудад зөрчлийн сануулах арга хэмжээ авах, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, хэвшсэн. Хурдны хязгаарыг журамлаж, хянах нь замын хөдөлгөөнөөс үүдэлтэй тоос, тоосжилтыг бууруулах, ослоос сэргийлэх давуу талтай юм (Зураг 8).



Зураг 8. Автомашины хурд хэмжилт

Баянхонгор – Баянхөндий, Баянхөндий – Баянхонгор ээлж солилцоог Залаагийн тээвэрчид ХХК-аар гэрээлэн гүйцэтгүүлдэг. Тээврийн хэрэгслээр зорчсон ажилтнуудаас “Зорчигч тээврийн үйл ажиллагаатай холбоотой асуулга”-ыг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс авч эхэлсэн, 10 дугаар сарын 25-ны байдлаар 84 ажилтан асуулгад оролцож, асуулгад оролцогчдын 91 хувь жолооч хурдаа тохируулж явсан, 60 хувь нь 80 км/цаг-аас бага хурдтай явсан, 75 хувь салаа зам гаргалгүй гэж хариулжээ (Зураг 8). Залаагийн тээвэрчид ХХК-д 11 дүгээр сарын 10-ны дотор дутагдлыг арилган, хариу ирүүлэх тухай 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 77/25 тоот албан шаардлагыг хүргүүсэн.



Зураг 9. Санал асуулга

Тоосжилтыг бууруулах зорилгоор Мазаалай кэмп, Нэгдсэн оффис хоорондох замыг “Монруд” ХХК өдөр бүр, Майхан хүрэн, Баянхөндий нисэх зурвас, Мазаалай кэмп, мод үржүүлэгийн талбайн замыг “Залаа таун” ХХК нислэгтэй өдөр буюу Даваа, Лхагва, Баасан гараг, уурхайн дотоод замын усалгааг Шинэжинст сумын иргэн Ш.Дэлгэрбат, Х.Дэмбэрэл нар өдөр бүр услах гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Замын усалгаанд урвуу осмосоос гарч байгаа хаягдал усыг ашиглаж, ус авсан тухай бүрд бүртгэл хөтөлж, бүртгэлийг диспатчерт нэгтгүүлдэг (Зураг 10).



Зураг 10. Зам, талбайн усалгаа

“Өсөх Урам” ХХК-тай гэрээ байгуулан Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг дэвсгэр, Цагаан хаалганаас Баянхөндий уурхай хүртэлх 70 км шороон замаас түйрэн үүсэх, эвдрэлд амархан өртөх магадлалтай 45 км замыг хусаж, услан, нягтаршуулах ажлыг 2024 онд эхлүүлж, тайлант онд 5 км замыг сайжруулах ажлыг 2025 оны 04 дүгээр сард гүйцэтгүүлсэн (Зураг 11). Нэмэлт сайжруулалт хийх шаардлагатай цэгүүдийн үзлэгийг 10 дугаар сарын 19-ний өдөр гүйцэтгэж, 8 байршилд 11 км урт замын дэржигнүүрийг хусах, салаа замыг хаах шаардлагатай байгааг тогтоосон. Замыг сайжруулах ажлыг 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөн, бэлтгэлийг хангаж байна.



Зураг 11. Замын сайжруулалт

Химийн бодисын агуулахын зураг төслийг боловсруулахдаа “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS6458:2014” стандартын шаардлагыг ханган, хаалганы босгыг шингэн урсахаас сэргийлсэн налуу өндөрлөгтэй, үерийн далан, сувагтай, ой хээрийн түймрээс хамгаалах зурвастай байхаар төлөвлөн, барьсан.

Асгаралт алдагдлын үед ашиглах асгаралтын иж бүрдэл, шингэн ИВС танк цоорч, гоожсон тохиолдолд хэрэглэх бүслүүр шаантгийг агуулахад байрлуулсан. Химийн бодисын агуулахыг хашаалж, хашааны дотор, гадна тал, агуулах тус бүрийн дотор талыг бүрэн камержуулсан, нийт 14 ширхэг хяналтын камертай (Зураг 12).



Зураг 12. Химийн бодисын агуулах

Баянхөндий уурхайн төслийн усны хэрэгцээг баталгаажсан цахилгаан соронзон тоолуур суурьлуулсан NWC-1, ВKW-21, ВKW-48, ВKW-54 худгаас хангадаг. Шинэжинст сумын ИТХ-ын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох тухай” 36 дугаар тогтоолоор дээрх худгуудын эрүүл ахуйн бүсийг тогтоосон. Худгуудад хуульд зааснаар 100 метрийн радиуст эрүүл ахуйн хамгаалалтын бүс байгуулж, хашаа татсан (Зураг 13).



Зураг 13. ВKW-21 худга

Ургамлын бичиглэл хийлгэх хүсэлтийг компанийн хэмжээнд цаас, цаг хугацаа хэмнэх зорилгоор Microsoft Form программ дээр QR код уншуулж өгдөг болсон.

Газар шорооны ажил эхлүүлэхээс өмнө тухайн талбайд ургамлын бичиглэл хийлгэх хүсэлтийг QR код уншуулан өгч, хүсэлтийн дагуу байгаль орчны хэсэг 10x10 м торлол татаж, тухайн талбай дахь ургамлын зүйлийн бүрдлийг гаргадаг. Тайлант хугацаанд газар шорооны ажил эхлүүлэх хүсэлт гаргасан 18 талбайд ургамлын бичиглэл хийхэд нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй (Зураг 14).



Зураг 14. Ургамлын бичиглэл хийж байгаа байдал

Байгаль орчны ажилтан 2024 онд элсний нүүдэл зогсоох “Өвсөн дөрвөлж”-ийн туршлагыг БНХАУ-д очиж судалсан. Баянхөндий уурхайгаас зүүн зүгт 24 км зайд 2025 оны 04, 05 дугаар сард нийт 0.0714 га талбайд 150 боодол сүрлээр “Өвсөн дөрвөлж”-ийн

туршилт хийж эхлүүлсэн. Ажиглалтаар тухайн орчмын элс дөрөлжид хуримтлагдан, нүүдэл нь зогссон байв (Зураг 15).



Зураг 15. Өвсөн дөрвөлж

Үерийн ус хуримтлуулах сан байгуулж, ус хуримтлуулснаар нүүдлийн шувууд дамжин өнгөрөх байдал ажиглагдлаа. Төслийн талбайд буугаад нисч чадахгүй байсан шунгуур шувууг Уртын голд шилжүүлэн тавих ажлыг 05 сарын 09-нд зохион байгуулсан (Зураг 16).



Зураг 16. Нүүдлийн усны шувууд

Эрдэнэ Монгол ХХК нь 2023 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Мазаалай хамгаалах хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мазаалай баавгайн амьдрах орчныг сайжруулах, идэш тэжээлээр хангах, мазаалай баавгай судлаачдад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, мазаалай баавгайг олон нийтэд сурталчилан таниулах, ажлуудыг тогтмол хийж, хэрэгжүүлж байна.

Мазаалай баавгай хүзүүвчлэх ажлын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 07-21-ны хооронд судалгааны баг ГИДЦГ-ын А хэсгийн буюу Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг Сэгс Цагаан Богд орчимд 14 хоног ажилласан. Судалгааны багийн мазаалай хүзүүвчлэх ажил энэхүү хугацаанд амжилттай болж чадаагүй. Харин ул мөр, үс, ялгадасны дээж цуглуулсан. Тус ажлыг гүйцэтгэхээр дахин 09 дүгээр сарын 02-оос 18-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллаж, Сэгс Цагаан Богд уулын нуруу орчмын “Хатуу булаг” гэх газарт 120 кг-аас дээш жинтэй, 10 орчим настай эр мазаалайд дохиоллыг зүүж “Эрдэнэ” гэж нэр өгсөн ба энэ нь мазаалай баавгайн байршлыг тогтоох үр дүнтэй ажил боллоо. Дохиололт хүзүүвч 2026 оны 11 сар хүртэл ажиллахаар байхаар тохиргоо хийгдсэн (Зураг 17).




Зураг 17. “Эрдэнэ” сансрын дохиололтой хүзүүвчтэй мазаалай баавгай

Ажлын байруудад хуваарийн дагуу сар бүр 1-2 удаа дуу, шуугианы хэмжилт хийж, Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны 06 сарын 12-ны ЕМ2023/0003.01 тоот тушаалаар батлагдсан “ОНСЕ.ЕМ. 417 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах тухай журам” “ОНСЕ.ЕМ.100, БОХАБЭА-н эрсдлийн удирдлага зохицуулалтын журам”-ын дагуу дуу, шуугиан ихтэй хэсэгт “НБХХ-ийг заавал хэрэглэх анхааруулгатай” тэмдэг, тэмдэглэгээг байрлуулж, дуулганд суурилдаг чихэвч, чихний бөглөөгөөр бүрэн хангадаг. Уурхайн оператор, хүдэр боловсруулах үйлдвэрийн ажлын байранд сард 2 удаа, уурхайн засварын төв, оффисын орчинд сард 1 удаа дуу, шуугианы хэмжилт хийдэг (Зураг 18).



Зураг 18. Дуу шуугианаас хамгаалах арга хэмжээ

Баянхөндий ил уурхайн талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 малчин өрх (Д.Баасандаш 1.9 км, Б.Ганбат 2.8 км, П.Нямсүрэн 3.2 км)-ийн өвөлжөөний зориулалттай эзэмшил газар байдаг ба тайлант хугацаанд дээрх айлууд өвөлжөөндөө буугаагүй. Гэсэн хэдий ч тус оны 01 дүгээр сараас сар тутамд орчны физик бохирдол (дуу, шуугиан)-ын хэмжилтийг хийж, “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ 60 дБА-тэй харьцуулж, үнэлэхэд стандартад заасан үзүүлэлтээс ихсээгүй, хэвийн хэмжээнд байлаа. Баянхөндий уурхайн үйл ажиллагаанаас үүсэж буй дуу, шуугианы тархалт нөлөөллийн бүсийн өвөлжөө, хаваржаанд хүрэхгүй байгаа нь хэмжилтийн үр дүнгээр тогтоогдов (Зураг 19).



Зураг 19. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн (Нөлөөллийн бүсийн иргэн Д.Б-ийн өвөлжөө, төслийн талбайгаас 1.9 км-т)

Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг шийдвэрлэх хүрээнд Шинэжинст сумын 4 багийн ИНХ-ын хуралдаанд 06 сарын 02-оос 09-ны хооронд оролцож, компанийн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт, нийгмийн хариуцлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлуудыг Уртын гол багийн 160, Зараа багийн 87, Эрдэнэшанд багийн 124, Эхэн хавцгай багийн 45 иргэнд танилцуулсан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 06-17-ны өдрүүдэд Уртын гол багийн 103 өрхөөр айлчилж, төслийн үйл ажиллагааны талаар мэдээллийг хүргэж ажиллалаа. Иргэдээс 2025 оны 09 дүгээр сарын 25-ны байдлаар хүсэлт, санал, өргөдөл нийт 50-ийг ирүүлсэн. Үүнээс хүсэлт 43, өргөдөл 3, гомдол 2, санал 2 байна. Шийдвэрлэлтийн явц 84% байна.

Баян-Өндөр сумын ИТХ-ын төлөөлөгчид, Идрэн 4-р багийн иргэдийн төлөөлөл 10 иргэн 05 дугаар сарын 06-нд төслийн талбайд зочилж, үйл явцтай танилцах үеэр санал солилцож, худгийн усны түвшний хэмжилт, онгоц хөөрөх, буух үеийн тоосны хэмжилтийн үр дүнг танилцуулсан (Зураг 20).



Зураг 20. Иргэдэд танилцуулга хийж буй байдал

“Эрдэнэ Монгол” ХХК орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхээр боловсролыг дэмжиж “Амралтаараа ажиллая” цалинтай оюутны зуны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт Шинэжинст сумаас Монгол Улсын их, дээд сургуульд суралцаж буй 23 оюутан хамрагдаж, оюутан, оюутны дадлгагажигч байгууллага, “Эрдэнэ Монгол

ХХК”-ийн хооронд гурвалсан гэрээг байгуулсан. Оюутнууд гэрээний дагуу Шинэжинст сумын төрийн, төрийн бус байгууллагад мэргэжлийнхээ чиглэлээр хоёр сарын хугацаанд дадлага хийж, мэдлэг, туршлага хуримтлуулж, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцжээ. Тухайлбал, Шинэжинст сумын бүх нийтийн цэвэрлэгээнд 2 удаа, Шинэжинст сумын баяр наадам, Уртын гол багийн өдөрлөг, Зараа, Эрдэнэшанд багийн өдөрлөг, наадам, Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Улсын баяр наадамд амжилт гаргасан Баянхонгор аймгийн алдартнуудад хүндэтгэл үзүүлэх наадам”-д тус тус зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэн оролцлоо. Түүнчлэн Баянхөндий уурхайн үйл ажиллагаа болон бүтээн байгуулалттай танилцах аяллыг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, уурхайн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны талаар танилцаж, бодит мэдээлэлтэй танилцсан нь оролцогчдын хувьд онцлог үйл явдал болсон (Зураг 21).



Зураг 21. “Амралтаараа ажиллая” хөтөлбөрт оролцогчид (2025.06.30)

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР					
Барилга байгууламжууд барих хөрс хуулалт хийх, уурхайн доторх технологийн зам зэргээс газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх		Хяналтгүйгээр газар шорооны ажил гүйцэтгэхээс сэргийлж, газар шорооны ажил эхлүүлэхийн өмнө Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ” -ийн бодлого журмын гарын авлага	Тайлант оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд 18 удаа газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл олгогдсон. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрөл тус бүрд тухайн ажлын талаарх мэдээлэл, түүнийг гүйцэтгэхийг зөвшөөрсөн баталгаажуулалт, байршлыг харуулсан .dwg зураг, ажил эхлэхийн өмнөх, ажил гүйцэтгэсний дараах нөхцөл байдлыг фото зургаар баримтжуулан, хавтсыг үүсгэж Sharepoint-д байрлуулав. Бид ArcGIS pro, AutoCAD зургийн программудыг худалдан авч, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. <i>Хавсралт 6. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн бүртгэл</i>	Үйл ажиллагааны зардлаас
		Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон карьеруудын мэдээллийг бүртгэлжүүлэх, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх		Уурхайн хэмжилтээр Лидар систем бүхий өндөр нарийвчлалтай дроноор хэмжилт хийж, тухай бүрд он сар өдрөөр дата үүсгэн хадгалж байна. <i>Хавсралт 7. Түгээмэл тархацтай ашигт малтмал нөөцийн хөдөлгөөний тайлан</i>	Үйл ажиллагааны зардлаас
		Шаардлагатай цэгүүдэд замын хөдөлгөөнийг зохицуулсан тэмдэг байрлуулах	Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйл, 17.3 дахь заалт, 23 дугаар зүйл 23.1 дэх заалт, MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм	“Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014 стандартын дагуу Хөндий талбайн үндсэн болон туслах замуудын уулвар, эргэх тойруу, салах хэсгүүдэд нийт 102 ширхэг заах, анхааруулах, хориглох тэмдэгүүдийг байршуулахын зэрэгцээ орон нутгийн автотээврийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. Мөн Баянхөндий уурхайгаас Шинэжинст сум хүртэлх замын эрсдэлтэй эргэлт, далантай хэсгүүдэд 280 ширхэг цацруулагчтай шон байрлуулсан. <i>Хавсралт 8. Замын тэмдэг суурьдуулсан ажлын тайлан</i>	Үйл ажиллагааны зардлаас

Гол болон нөлөөллийг болон сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Хуулсан шимт болон шимэрхэг хөрсний үржил шимт чанар алдагдах	Шимт болон шимэрхэг хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах зорилгоор овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих (5 метрээс өндөргүй овоолох)	MNS 5917:2008 "Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт, “Эрдэнэ” -ийн бодлого журмын гарын авлага	Шимт хөрсний овоолгыг “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартад 5 хүртэлх метрийн өндөртэй үүсгэхийг зөвшөөрдөг. 2025 оны 10 сарын 06 өдрийн байдлаар Баянхөндий ил уурхайгаас 119,588.61м ³ , Мазаалай кэмийн урд талд 10,848м ³ шимт хөрс, нийт 130,436.61м ³ шимт хөрсний овоолгыг 6.8 га талбайд 4 метрийн өндөртэй үүсгээд байна. <i>Хавсралт 9. Шимт хөрсний овоолгын зураг</i>	Үйл ажиллагааны зардлаас
ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧИНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс шатах тослох материал гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй.	“IMS.EM.12 Үл тохирол залруулах болон сэргийлэх арга хэмжээний журам”, “IMS.EM.11 Ослыг судлан бүртгэх болон тайлагнах журам”, “EM2023/0015.01 Автомашин, механизм ашиглах журам”-уудыг мөрдөж ажиллах	“IMS.EM.12 Үл тохирол залруулах болон сэргийлэх арга хэмжээний журам”, “IMS.EM.11 Ослыг судлан бүртгэх болон тайлагнах журам”, “EM2023/0015.01 Автомашин, механизм ашиглах журам”-уудыг мөрдөж ажиллах	Асгаралт үүссэн тохиолдолд компанийн гүйцэтгэх захирлын 2013 оны 06 сарын 12-ны өдөр EM 2023/0002.01 тоот тушаалаар батлагдсан “OHSE.EM.602 Асгаралтын хариу арга хэмжээний журам”-аар зохицуулалтыг хийж, ажилладаг. 2025 оны 04 сарын 30 хүртэлх хугацаанд ямар нэгэн асгаралт үүсээгүй. Харин 05-р сарын 01-нээс 09-р сарын 25-ны хооронд 3 удаагийн түлшний асгаралт үүсгэсэн бөгөөд 2013 оны 08 сарын 22-ны өдөр EM 2023/0008.01 тоот тушаалаар батлагдсан “IMS.EM.11 Ослыг судлан бүртгэх болон тайлагнах журам”-ыг мөрдлөг болгон хариу арга хэмжээг авч ажилласан. <i>Хавсралт 10. Асгаралтын бүртгэл, Аюултай тохиолдлын судалгааны тайлан</i>	Үйл ажиллагааны зардлаас
Засварын газраас гарсан ашигласан тос, тослох материалыг түр хадгалах саванд цуглуулах, түр хадгалах явцад дамжуулах шугам хоолойн гэмтэл, хүний болгоомжгүй	Засварын газраас гарах ашигласан тос, тосолгооны материалыг зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалах, бүртгэх	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал	Уурхайн завсарын газар 05 сарын 01 -ээс техникүүдийн бэлэн байдлыг хангах, завсар, үйлчилгээ хийх ажлыг эхлүүлж, үйлчилгээний явцад гарсан ашигласан тос, тосолгооны материалыг зориулалтын саванд хуульд заасан хугацаанд түр хадгалан “Хай Би Ойл” ХХК-д шилжүүлдэг. Завсарын газрын үйл ажиллагаа эхэлснээс хойш үүссэн 3.4 тн шингэн тосны хаягдлыг тус компанид 10 сарын 02-нд шилжүүлж, акт үйлдсэн. <i>Хавсралт 11. Аюултай хог хаягдлыг шилжүүлсэн акт, 2025</i>	13,217.720

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
үйлдлээс ШТМ асгарсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдуулж болзошгүй				
Тээврийн үйл ажиллагаанаас олон салаа зам гарган хөрсний элэгдэл үүсгэж болзошгүй	Шаардлагатай цэгүүдэд замыг сайжруулах ажлыг хэсэгчлэн зохион байгуулах	Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны “Замын чиглэл тогтоох тухай” А/396 захирамж	Цагаан хаалганаас Баянхөндий уурхай хүртэлх 70 км шороон замаас түйрэн үүсэх, эвдрэлд амархан өртөх магадлалтай 45 км замыг хусаж, услах, нягтаршуулах ажлыг 2024 оноос эхлүүлэн, тайлант онд 5 км замыг засварлах ажлыг “Өсөх Урам ХХК”-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Салаа зам, дэржигнүүр үүсэн 8 байршилд 11 км урт замыг засварлах ажлыг 10 сарын 25-нд эхлүүлэхээр бэлтгэлийг хангасан. <i>Хавсралт 12. Зам засварласан ажлын тайлан, 2025</i>	Үйл ажиллагааны зардлаас
Химийн бодисын буруу хадгалалт, байгалийн гэнэтийн аюултай үзэгдлээс химийн бодис асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй.	Химийн хортой болон аюултай бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу шаардлага хангасан агуулахад хадгалах	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал	Химийн бодисын агуулахын зураг төслийг боловсруулахдаа “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS6458:2014” стандартын шаардлагыг ханган, хаалганы босгыг шингэн урсахаас сэргийлсэн налуу өндөрлөгтэй, үерийн далан, сувагтай, ой хээрийн түймрээс хамгаалах зурвастай байхаар төлөвлөн, барьжээ. Асгаралт алдагдлын үед ашиглах асгаралтын иж бүрдэл, шингэн ИВС танк цоорч, гоожсон тохиолдолд хэрэглэх бүслүүр шаантгийг агуулахад байрлуулсан. <i>Зураг 12. Химийн бодисын агуулах</i>	Үйл ажиллагааны зардлаас
ГУРАВ. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Төслийн үйл ажиллагаанд ашиглах хөдөлгөөнт, суурин техник хэрэгслүүдээс нүүрхүчлийн хий ялгарч агаар мандал дахь хүлэмжийн хийн	Хэрэглэсэн нүүрс, шатахууны хэмжээнд үндэслэн ялгаруулсан нүүрсхүчлийн хийг тооцох	*MNS ISO 14064-1 - 2015 (Хүлэмжийн хий – Нэгдүгээр хэсэг - Байгууллагын түвшинд хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийг тооцоолох, тайлагнах тухай зааварчилсан удирдамж) *Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний	Баянхөндий уурхай нь 10 сарын 11-ний байдлаар нийт 20.519 тн АИ-92 шатахуун, 1,652.36776 тн дизель түлш хэрэглэсэн, хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг урьдчилан тооцоход 51,828.24 тCO ₂ ялгаруулсан тооцоо гарсан.	Зардал шаардагдаагүй

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
агууламжийг нэмэгдүүлнэ.			хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06)		
ДӨРӨВ. АГААРЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР					
Эвдрэл, элэгдэлд өртсөн, хөрсөн бүрхэвч талхлагдсан хэсгүүдээс тоос шороо агаарт дэгдэх	Нисэх зурвас кэмп хоорондох, кэмп уурхай хоорондох, технологийн замуудыг услах	Усны тухай хууль (2012) 32.8 дугаар зүйл		Тоосжилтыг бууруулах зорилгоор Мазаалай кэмп Нэгдсэн оффис хоорондох замыг Монруд ХХК өдөр бүр, нисэх буудал Мазаалай кэмп, мод үржүүлэгийн талбайн замыг Залаа таун ХХК нислэгтэй өдрүүд буюу Даваа, Лхагва, Баасан гарагуудад, уурхайн дотоод замын усалгааг Шинэжинст сумын иргэн Ш.Дэлгэрбат, Х.Дэмбэрэл нар өдөр бүр услах гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <i>Хавсралт 13. Усалгааны машины ажлын тооцооны хуудас жишээ</i>	57,684.0
	Тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд оролцох хурдны дээд хязгаарыг 40 км/цагаас хэтрүүлэхгүй байх	Агаарын тухай хууль MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага		“ОНСЕ.ЕМ.101. Уурхайн замын хөдөлгөөний журам”-ыг шинэчлэн, Компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн А/14 тоот тушаалаар батлуулсан бөгөөд уурхайн бүсэд хурдны хязгаарыг 40км/ц хүртэл байхаар тогтоож өгсөн. Шинэ ажилтны сургалт, төслийн талбайд жолоо барих эрх олгох сургалтаар хурдны дээд хязгаарын мэдээллийг нарийвчлан заадаг. Хурд хэмжигчээр төслийн талбайд замын хөдөлгөөнд оролцож буй бүх техникт хуваарийн дагуу хурдны хэмжилт хийж, хурд хэтрүүлсэн ажилтнуудад зөрчлийн сануулах арга хэмжээ авах, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, хэвшсэн. <i>Хавсралт 14. Хурдны хэмжилт хийсэн ажлын тайлан</i>	Зардал шаардагдаагүй
ТАВ. ГАЗРЫН ДООРХ УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР					
Газрын доорх усны нөөц багасгах	Ус авах худаг нэмэгдсэн тохиолдолд тухайн ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах	Усны тухай хууль 30.1.4; Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны "Журам батлах тухай" 156 тоот тушаал		Баянхөндий уурхайн төслийн усны хэрэгцээг NWC-1, ВКW-21, ВКW-48, ВКW-54-р гэсэн 4 худгаас хангаж байна. Худгуудад баталгаажсан цахилгаан соронзон тоолуур суурьлуулж лацдан акт үйлдсэн. <i>Хавсралт 15. Тоолуур суурьлуулсан акт</i>	Үйл ажиллагааны зардлаас

Гол болзошгүй нөлөөллүүд	болон сөрөг	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
		Мониторингийн цооногт логгер суурилуулах	Усны тухай хууль	Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2021 онд Гео инженеринг ХХК-ийн гаргасан 2 ш мониторингийн цооног хагас автомат логгерыг 06 сарын 27-нд, ВКW-47, цооногуудад хагас автомат логгер суурьлуулж, хэмжилтийн үр дүнг улирал тутам цуглуулж байна. <i>Хавсралт 16. Хагас автомат логгер суурьлуулсан акт</i>	Үйл ажиллагааны зардлаас
		Ус хангамжийн худгуудын тоолуурын заалтыг өдөр бүр бүртгэх, сумын БОХУБ эсвэл байгаль хамгаалагчаар баталгаажуулах	Усны тухай хууль	Ус ашиглалтыг зориулалт тус бүрээр өдөр тутам бүртгэл хөтөлж, улирал бүр Шинэжинст сумын БОХУБ-аар баталгаажуулалтыг хийлгэдэг. <i>Хавсралт 17. Ус ашиглалтын бүртгэл</i>	Зардал шаардагдаагүй
		Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах зааварчилгааг ерөнхий зааварчилгаагаар дамжуулан ажилтнуудад олгох	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.	Нийт ажилтнуудад “Ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан усны нөөцийг хэмнэх мэдлэг олгодог ба “Усыг хэмнэлттэй, зохистой ашиглах” сургалтыг 10 сарын 12-ны байдлаар давхардсан тоогоор 910 ажилтанд олгосон. <i>Хавсралт 18. Сургалтын материал</i>	Зардал шаардагдаагүй
		Ил уурхайд ус шүүрсэн тохиолдолд усыг зам усалгаанд ашиглах	Усны тухай хууль	Баянхөндий уурхайн хөрс хуулалт 05 сарын 07-нд эхэлж 10 сарын 11-ний байдлаар 15.3 га талбайтай дунджаар 11 м гүнтэй ил уурхай үүсээд байна. Тухайн хугацаанд ил уурхайд ус шүүрээгүй.	Үйл ажиллагааны зардлаас
ШТМ, аюултай болон хортой бодис асгарч, хаягдсан тохиолдолд газрын доорх усыг бохирдуулах		Усны сан бүхий газрын эрүүл ахуйн бүсийг тогтоолгох	БОНХАЖС, БХБС-ын хамтарсан 2025 оын А-230/127 “Журам батлах тухай” тушаал	Шинэжинст сумын ИТХ-ын 2025 оны 05 сарын 01-ний өдрийн “Усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоох тухай” 36 дугаар тогтоолоор NCW-1, ВКW-21, ВКW-488 ВКW-54 худгуудад эрүүл ахуйн бүсийг тогтоосон. Худгуудад хуульд заасан эрүүл ахуйн бүс буюу 100 м радиуст хамгаалалтын хашаа татсан. <i>Зураг 13. ВКW-21 худаг</i>	Үйл ажиллагааны зардлаас
Усны нөөцийн саванд гадны биет орох, амьтан унах		Ус нөөцлөх 50 м ³ багтаамжтай хос усан сангийн орчим хяналтын камер суурьлуулах	Усны тухай хууль	Хүдэр боловсруулах үйлдвэрийг усаар хангадаг 500 куб.м багтаамжтай хос усан сан, Мазаалай кэмийг усаар хангадаг 50 куб.м багтаамжтай хос усан сангуудын гадна хэсэгт 2 ш хяналтын камерыг суурьлуулсан ба 24 цагийн турш камераар хяналт тавьдаг.	Үйл ажиллагааны зардлаас

Гол болон болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас химийн бодис агуулсан ус алдагдаж газрын доорх усыг бохирдуулж болзошгүй	Боловсруулах үйлдвэрт химийн бодис гоожиж, асгарсан тохиолдолд хуримтлуулах сантай байх	Хүдэр боловсруулах үйлдвэрийн зураг PCDP ХХК, 2021 он	Хүдэр боловсруулах үйлдвэрийн уусгалт, шингээлт, урвалж, усны танк зэрэг их хэмжээний шингэн материал агуулсан бүх танкийг тухайн эзлэхүүнтэй дүйх тус тусын цуглуулах талбайд байрлуулсан. Нийт 7000 куб.м шингэн цуглуулах багтаамжтай, цуглуулах талбайг бетоноор цутгаж, химийн бодист тэсвэртэй будгаар будаж нэвчих, идэгдэхээс хамгаалсан.	Үйл ажиллагааны зардлаас
ЗУРГАА. УРГАМЛАН НӨМРӨГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Ил уурхайн хөрс хуулах, зам засах үед ургамлан нөмрөг өнгөн хөрстэй хамт хуулагдах	Газар шорооны ажил эхлэхээс өмнө тухайн талбайд ургамлын бичиглэл хийх	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);	Ургамлын бичиглэл хийлгэх хүсэлтийг компанийн хэмжээнд цаас, цаг хугацаа хэмнэх зорилгоор Microsoft Form программ дээр QR код уншуулж өгдөг болсон. Газар шорооны ажил эхлүүлэхээс өмнө тухайн талбайд ургамлын бичиглэл хийлгэх хүсэлтийг QR код уншуулан өгч, хүсэлтийн дагуу байгаль орчны хэсэг 10x10 м торлол татаж, тухайн талбай дахь ургамлын зүйлийн бүрдлийг гаргадаг. Тайлант хугацаанд газар шорооны ажил эхлүүлэх хүсэлт гаргасан 18 талбайд ургамлын бичиглэл хийсэн. <i>Зураг 4. Газар шорооны ажил эхлүүлэх зөвшөөрлийн жагсаалт</i>	Зардал шаардагдаагүй
Түр байгууламжууд, агуулах барих, зам засахад ховор ургамлууд нөлөөлөлд өртөх	Газар шорооны ажил эхлэхийн өмнө тухайн талбай дахь нэн ховор, ховор ургамлыг бүртгэх	Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019	Газар шорооны ажил эхлэхийн өмнө уг талбайд ховор болон нэн ургамал илэрсэн тохиолдолд шилжүүлэн суулгах зорилгоор үзлэг хийн ургамлыг бүртгэдэг. Зөвшөөрөл олгогдсон 18 талбайд хийсэн үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй. <i>Зураг 14. Ургамлын бичиглэл хийж байгаа байдал</i>	Зардал шаардагдаагүй
	Газар шорооны ажил эхлэхийн өмнө талбайн үзлэгээр нэн ховор, ховор ургамал бүртгэгдсэн тохиолдолд нөлөөлөлд өртөх ургамлыг шилжүүлэн тарих		Зөвшөөрөл олгогдсон 18 талбайд ажил эхлэхийн өмнөх үзлэгээр нэн ховор болон ховор ургамал бүртгэгдээгүй учраас шилжүүлэн тариалалт хийгдээгүй.	Зардал шаардагдаагүй

Гол болон нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Байгаль орчны чиглэлээр туршилт, судалгаа явуулах	БНХАУ-д судалсан өвсөн дөрвөлжийг турших	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 7.2.3);	Баянхөндий уурхайгаас зүүн зүгт 24 км зайд 2024 онд судалсан элсний нүүдэл зогоох туршилтын ажлыг 04, 05 саруудад нийтдээ 0.0714 га талбайд 150 боодол сүрлээр дөрвөлж хийж эхлүүлсэн. Ажиглалтаар тухайн орчмын элс дөрөлжид хуримтлагдан, нүүдэл нь зогссон. <i>Зураг 15. Өвсөн дөрвөлж</i>	13,698.630
Байгаль орчны мэдлэг дутуугаас ургамал тасдаж болзошгүй	Байгалийн ургамлыг тасдахгүй байх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу олгох	“Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр” Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.	Нийт ажилтнуудад “Ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан байгалийн ургамлыг тасдахгүй байх талаарх мэдлэг олгодог, шинэ ажилтны сургалтад 10 сарын 12-ны байдлаар давхардсан тоогоор 910 ажилтан хамрагдсан. <i>Хавсралт 19. Биологийн олон янз байдлын сургалтын материал</i>	Зардал шаардагдаагүй
ДОЛОО. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Хүн амын суурьшил, тээврийн хэрэгслийн дуу чимээ, гэрэл зэргээс амьтад байршиж буй газар нутгаасаа үргэж дайжихаас гадна, тээврийн хэрэгсэлд дайруулж болзошгүй	Батлагдсан замын маршрутаар зорчих	“Баянхөндий ордыг ил аргаар олборлох ТЭЗҮ” Гложекс консалтинг ХХК 2025	Замын хөдөлгөөнд оролцоходоо зөвхөн тогтоосон замаар зорчдог ба салаа зам үүсгэхийг хориглодог. Бараа материал, хүнс, хүн тээвэр Улаанбаатар хотоос Баянхонгор аймгийн төв хүртэл улсын чанартай автозамаар, Баянхонгор аймгийн төвөөс Баянхөндий уурхай хүртэл аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох тухай” А/396 дугаар захирамжаар батлагдсан чиглэлийг баримтлан, зорчиж байна. Дотоод замын маршрутыг батлан, зам завсарын ажлыг М-Си-Эс Проперти ХХК-аар гүйцэтгүүлэн, ашиглаж байна. <i>Хавсралт 20. Батлагдсан дотоод замын маршрут</i>	Зардал шаардагдаагүй
	Төслийн талбайд амьтан орж ирсэн тохиолдолд шилжүүлэх	Монгол орны хөхтөн, шувуу, мөлхөгчдийн улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл, 2012, 2019	Төслийн талбайд таарсан нисч чадахгүй байсан шунгуур шувууг Уртын голд шилжүүлэн тавих ажлыг 05 сарын 09-нд зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
Байгаль орчны мэдлэг дутуугаас	Байгалийн амьтныг үргээх, элдэж хөөхгүй	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн	Нийт ажилтнуудад “Ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан амьтныг үргэхгүй, элдэж хөөхгүй байх талаарх мэдлэг	Зардал шаардагдаагүй

Гол болон нөлөөллийг болзошгүй нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)	
амьтныг элдэж, болзошгүй	үргээж, алж	байх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу олгох	шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.	олгодог, шинэ ажилтны сургалтад 10 сарын 12-ны байдлаар давхардсан тоогоор 910 ажилтан хамрагдсан. <i>Хавсралт 19. Биологийн олон янз байдлын сургалтын материал</i>	
Шувууд болзошгүй	эрсдэж	Шувууд (элдэв идэшт) цуглах таатай орчин бүрдүүлэхээс зайлсхийж хоол хүнсний үлдэгдлийг ил задгай хаяхгүй байх, холбогдох хяналт тавих	“OHSE.EM.604 Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”	Хог хаягдлын тухай хуулийн 15, 16 дугаар зүйл, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.11.17-ны “Тавигдах ерөнхий шаардлага батлах тухай” А/443, 2018.11.19-ний “Аргачилсан заавар батлах тухай” А/445 тушаалын дагуу хог хаягдлыг түр хадгалах цэгийг битүү хогийн цэгийн хоолны үлдэгдэл, ахуйн хог хаягдлыг хадгалах савыг битүүмжлэн элдэв идэшт шувууд орох боломжгүй болгосон. Хогийн цэгт болон ойр орчимд нь элдэв идэшт буюу хэрээний төрлийн шувуу бүртгэгдээгүй.	Зардал шаардагдаагүй
НАЙМ. ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР					
Хүн амын суурьшил нэмэгдэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тухайн орчны дуу шуугиан нэмэгдэн улмаар тархан амьдрах амьтад үргэж дайжих	Мазаалай баавгайд байршил тогтоогч хүзүүвч суурьлуулах	БОАЖЯ/хуучнаар/-тай байгуулсан “Хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг” 2024.05.31	Мазаалай баавгай хүзүүвчлэх ажлын хүрээнд 06 сарын 07-21-ны хооронд судалгааны баг ГИДЦГ-ын А хэсгийн буюу Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг Сэгс Цагаан Богд орчимд 14 хоног ажилласан. Судалгааны багийн мазаалай хүзүүвчлэх ажил энэхүү хугацаанд амжилттай болж чадаагүй. Харин ул мөр болон үс, ялгадасны дээж цуглуулан ажилласан. Судалгааны баг мазаалай баавгайд сансрын дохиолт хүзүүвч зүүх ажлыг гүйцэтгэхээр дахин 09 сарын 02-оос 18-ыг дуустал ажиллаж, амжилттай гүйцэтгэсэн. Эрдэнэ Монгол ХХК-ий санхүүжилтээр авч өгсөн сансрын дохиолт хүзүүвчийг ГИДЦГ-ын А хэсгийн нутаг болох Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг Цагаан Богдын нуруу орчмын Хатуу булаг гэх газарт 120 кг-аас дээш жинтэй, 10 орчим настай эр мазаалай мазаалайд зүүсэн байна. Хүзүүвчилсэн мазаалайд “Эрдэнэ” гэж нэр өгсөн. Хүзүүвч нь дохиолол амжилттай өгч байгаа бөгөөд уг хүзүүвч 2026 оны 11 сар хүртэл ажиллах юм.	19,900.0	

Гол болон нөлөөллийг болон сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
			<p>Зураг 17. “Эрдэнэ” сансрын дохиололтой хүзүүвчтэй мазаалай баавгай</p> <p>Хавсралт 21. “Мазаалай хамгаалах хөтөлбөр”-ийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан</p>	
	<p>Байгалийн амьтныг үргээх, элдэж хөөхгүй байх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу олгох</p>	<p>Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.</p>	<p>Нийт ажилтнуудад “Ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан амьтныг үргэхгүй, элдэж хөөхгүй байх талаарх мэдлэг олгодог, шинэ ажилтны сургалтад 10 сарын 12-ны байдлаар давхардсан тоогоор 910 ажилтан хамрагдсан.</p> <p>Хавсралт 19. Биологийн олон янз байдлын сургалтын материал</p>	<p>Зардал шаардагдаагүй</p>
ЕС. ДУУ ШУУГИАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
<p>Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугианы нөлөөлөх үүсэх ба ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй</p>	<p>Хэт өндөр дуу шуугиантай (80дВА-аас дээш) орчинд ажилладаг ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл тогтмол ашиглуулах</p>	<p>ОНСЕ.ЕМ. 417, Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах тухай журам ОНСЕ.ЕМ.100, БОХАБЭА-н эрсдлийн удирдлага зохицуулалтын журам</p>	<p>Ажлын байруудад хуваарийн дагуу сар бүр 1-2 удаа дуу, шуугианы хэмжилт хийж, Компанийн гүйцэтгэх захирлын 2023 оны 06 сарын 12-ны ЕМ2023/0003.01 тоот тушаалаар батлагдсан “ОНСЕ.ЕМ. 417 Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах тухай журам” “ОНСЕ.ЕМ.100, БОХАБЭА-н эрсдлийн удирдлага зохицуулалтын журам”-ын дагуу дуу, шуугиан ихтэй хэсэгт “НБХХ-ийг заавал хэрэглэх анхааруулгатай” тэмдэг, тэмдэглэгээг байрлуулж, дуулганд суурилдаг чихэвч, чихний бөглөөгөөр бүрэн хангадаг. Уурхайн оператор, хүдэр боловсруулах үйлдвэрийн ажлын байранд сард 2 удаа, уурхайн засварын төв, оффисын орчинд сард 1 удаа дуу, шуугианы хэмжилт хийдэг. <i>Зураг 18. Дуу шуугианаас хамгаалах арга хэмжээ</i></p>	<p>Үйл ажиллагааны зардлаас</p>
<p>Төслийн талбайд ажиллах техник хэрэгслүүдээс нийлмэл дуу шуугиан үүсэж, ойролцоо орших нутгийн 1 малчин өрхийн тав тухад сөргөөр нөлөөлж болзошгүй.</p>	<p>Энэ айл өвөлжөөндөө өвөлжиж байгаа үед сард 1 удаа дуу шуугианы хэмжилт хийх, үр дүнгээс хамааран давтамжийг өөрчлөх</p>	<p>IMS.ЕМ.04 “Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх, оролцогч талуудын хэрэгцээ шаардлага тодорхойлох журам”</p>	<p>Баянхөндий ил уурхайн талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин (Д.Баасандаш 1.9 км, Б.Ганбат 2.8 км, П.Нямсүрэн 3.2 км) өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Тайлант хугацаанд дээрх айлууд тухай өвөлжөөндөө ирж буугаагүй. Гэсэн хэдий ч тус оны 1 дүгээр сараас эхлэн орчны физик бохирдлын (дуу чимээ, шуугианы хэмжилт) хэмжилтийг сар бүр хийж байна. <i>Зураг 19. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн (Нөлөөллийн бүсийн иргэн Д.Б-ийн өвөлжөө, төслийн талбайгаас 1.9 км-т)</i></p>	<p>ОХШТ-нд туссан</p>

Гол болон нөлөөллүүд	болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
АРАВ. НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайн ойр нутаглаж буй малчин өрхүүдийн мал үүсгэсэн карьерт унан эрсдэж болзошгүй	Нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагааны мэдээлэл өгч ажиллах	IMS.EM.04 “Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх, оролцогч талуудын хэрэгцээ шаардлага тодорхойлох журам”	Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг шийдвэрлэх хүрээнд Шинэжинст сумын 4 багийн ИНХ-ын хуралдаанд 06 сарын 02-оос 09-ны хооронд оролцож компанийн хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн, байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлсэн ажлуудын талаар Уртын гол багийн 160, Зараа багийн 87, Эрдэнэшанд багийн 124, Эхэн хавцгай багийн 45 иргэнд танилцуулсан. Мөн 09 сарын 6-17-ны өдрүүдэд Уртын гол багийн 103 өрхөөр айлчилж, төслийн үйл ажиллагааны талаар мэдээллийг хүргэж ажиллалаа. Баян-Өндөр сумын ИТХ-ын төлөөлөгч нар болон Идрэн 4-р багийн иргэдийн төлөөлөл 10 иргэн 05 дугаар сарын 06-нд төслийн талбайд ирж, төслийн үйл явцтай танилцаж, санал солилцох үед худгуудын усны түвшний хэмжилт, онгоц хөөрөх, буух үеийн тоосны хэмжилтийн үр дүнг танилцуулсан. <i>Зураг 20. Иргэдэд танилцуулга хийж буй байдал</i>	Үйл ажиллагааны зардлаас
Нутгийн иргэд Баянхөндий алтны үндсэн ордыг ашиглах үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй байх	Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх, санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх	IMS.EM.04 “Өргөдөл гомдол хүлээн авах, шийдвэрлэх, оролцогч талуудын хэрэгцээ шаардлага тодорхойлох журам”	Иргэдээс 2025 оны 09 сарын 25-ны байдлаар хүсэлт, санал, өргөдөл нийт 50-ийг ирүүлсэн. Үүнээс хүсэлт 43, өргөдөл 3, гомдол 2, санал 2 байна. Шийдвэрлэлтийн явц 84% байна.	Үйл ажиллагааны зардлаас
Баянхонгор аймгийн харъяат иргэдээс ажилд орох хүсэлтэй боловч боловсрол, ажлын туршлага хангалтгүйгээс орж чадахгүй байж болзошгүй	Төслийн үйл ажиллагаатай уялдуулан нарийн мэргэжил шаардахгүй ажлын байруудад нутгийн иргэдийг ажиллуулах	Хүний нөөцийн бодлого, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд	Төслийн үйл ажиллагаа эхлээгүй ч 2023.05 сараас хойш “Энержи Ресурс” ХХК-ийн сургалтын хэсэгтэй хамтран 8 удаагийн Хүнд машин механизмын операторын сургалтыг амжилттай зохион байгуулж, Баянхонгор аймгийн 17 сумын 164 иргэнийг сургалтанд хамруулж чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгосон. Тухайн иргэд нь Баянхөндий уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд Ухаа худаг уурхайд дадлагажин ажиллаж байгаад 2025.05 сараас эхлэн “Эрдэнэ Монгол” ХХК-д шилжин ажиллаж байна. “Эрдэнэ Монгол” ХХК нь нарийн мэргэжил	Үйл ажиллагааны зардлаас

Гол болон нөлөөллийг болон сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
			шаардахгүй ажлын байранд зөвхөн орон нутгийн иргэн сонгон шалгаруулж авах хүний нөөцийн бодлогыг баримтлан ажиллаж байгаа ба 2025 онд нийт 260 орчим иргэд шинээр ажилд орсоны 57% буюу 150 ажилтан Баянхонгор аймгаас ажилд орсон байна.	
	“Цалинтай оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орон нутгийг дэмжих хөтөлбөр	Эрдэнэ Монгол ХХК-ийн орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд боловсролыг дэмжих зорилгоор “Амралтаараа ажилла” цалинтай оюутны зуны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрт Шинэжинст сумаас Монгол Улсын их, дээд сургуульд суралцаж буй 23 оюутан хамрагдан, оролцогчид, дадлагажигч байгууллага болон Эрдэнэ Монгол ХХК-тай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулж, Шинэжинст сумын төрийн байгууллагуудад мэргэжлийн чиглэлээр хоёр сарын хугацаанд дадлага хийж, мэдлэг туршлага хуримтлууллаа. <i>Зураг 21. “Амралтаараа ажилла” хөтөлбөрт оролцогчид (2025.06.30)</i> <i>Хавсралт 22. “Амралтаараа ажилла” хөтөлбөрийн тайлан</i>	Үйл ажиллагааны зардлаас
	Нийт ажилтны 30-аас доошгүй хувьд нутгийн иргэд ажиллуулах	Хүний нөөцийн бодлого	Эрдэнэ Монгол ХХК нь 2025.10.01-ний байдлаар үндсэн 315 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. нийт ажилтнуудыг орон нутгийн харъяаллаар нь тооцвол 46 % нь буюу 156 иргэн Баянхонгор аймгийн, 39% нь Улаанбаатар хот, 15% нь бусад орон нутгийн иргэдээс бүрдэж байна. Баянхонгор аймгийн 17 сумаас 156 иргэн ажиллаж байгаа ба нийт орон нутгийн иргэдийн 25% буюу 38 иргэн нь Шинэжинст сумын харъяат иргэд байгаа юм.	Үйл ажиллагааны зардлаас
Орон нутагт уул уурхайтай холбоотой хүн амын хөдөлгөөн нэмэгдэхийн зэрэгцээгээр архидалт, гэмт хэргийн гаралт өсч болзошгүй	Төслийн талбайд архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах	“OHSE.EM.403.01 Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг илрүүлэх сорил хийх заавар”, “OHSE.EM.403 Ядаргааны удирдлага зохицуулалтын журам”	“OHSE.EM.403.01 Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг илрүүлэх сорил хийх заавар”-ын дагуу Эрдэнэ Монгол ХХК, түүний туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн бүх ажилтнууд өдөр бүр ажилдаа гарахдаа “Ээлж эхлэхийн өмнөх амьсгал дахь спиртийн агууламж тогтоох тестийг хийлгэдэг. Сард дунджаар 432 ажилтанд амьсгал дахь согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах тест хийгддэг.	Үйл ажиллагааны зардлаас

Гол болзошгүй нөлөөллүүд болон сөрөг	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
			<i>Хавсралт 23. “Согтууруулах ундааны үр дагавар, хор уршиг” сургалтын материал</i>	

2.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн олборлолтын явцад элэгдэл, эвдрэл, бохирдолд орсон талбайнуудыг цэвэрлэн, аль болох байгалийн унаган төрхөд нь дөхүүлэн хөдөө аж ахуйн чиглэлээр нөхөн сэргээхээр ТЭЗҮ-д тусгагдсан. Нөхөн сэргээлтийг БОНХАЖС-ын 2015 оны А-138 тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ.

Нөхөн сэргээлтийн техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн тодорхой зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах зорилгоор ухаж эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж, шимт хөрсөөр хучих зэрэг үндсэн ажлыг гүйцэтгэнэ. ТЭЗҮ-д техникийн нөхөн сэргээлтийг ашиглалтын 2 дахь жилээс эхлүүлэхээр тусгагдсан.

Ил уурхайн олборлолтод өртсөн 15.3 га талбайгаас 119,588.61м³ шимт болон шимэрхэг хөрсийг хуулж, “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008” стандартын шаардлагад нийцүүлэн 5 м-ээс илүүгүй өндөртэй овоолго үүсгэн, хадгалж эхэлсэн (Зураг 6).

БОМТ-ний биелэлтийг дүгнэх комисс 2025 оны 10 дугаар сарын 16-нд талбайд ажиллахдаа өгсөн зөвлөмжийн дагуу овоолгыг хэлбэржүүлэх ажлыг 10 дугаар сарын 19-нд гүйцэтгэсэн. Шимт хөрсний үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор ургамлын үрээр тариалалт хийх ажлыг 2026 онд илүү үр дүнтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 22. Шимт хөрсний хэлбэржүүлэлт (2025.10.19)

Мазаалай кэмп, зочдын амрах байр, цэвэрлэх байгууламж, кэмп орчмын замаас хуулсан 10,848 м³ шимт, шимэрхэг хөрсийг овоолго үүсгэн хадгалж, 750 кв.м талбайд 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр нутгийн ургамлын үрээр тарилт хийж, тогтмол усалгаатай байлгасан (Зураг 23).




Зураг 23. Шимт хөрсний овоолгын арчилгаа

Нутгийн ургамлын үрээр биологийн нөхөн сэргээлт хийх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Шинэжинет сумын Уртын гол багийн нутаг дэсвгэрээс шар модот хотирын 4 кг, хайлаасны 3 кг, лидэрийн 2 кг, чихэр өвсний 3 кг, тоорой модны 2 кг, жигд модны 2 кг, заг модны 10 кг нийт 26 кг үрийг түүсэн (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Түүсэн үрийн хэмжээ, 2025 он

№	Үр мөчрийн нэр	Үр мөчир бэлтгэсэн хугацаа	Хэмжээ, кг-аар	Түүсэн газрын нэр
1.	Шар модон хотир	07, 08 сар	4	Хүрэн цав, Майхан хүрэн
2.	Тоорой	07 сар	2	Эхийн гол
3.	Лидэр	09 сар	2	Эхийн гол
4.	Чихэр өвс	08 сар	3	Эхийн гол
5.	Жигд	10 сар	2	Эхийн гол
6.	Заг	01 сар	10	Босго
7.	Хайлаас	05 сар	3	Гурван бамбуу
Нийт			26	-

Жилийн хугацаанд бэлтгэх тарьц, суулгацын тоог нэмэгдүүлэхээр мод үржүүлгийн талбайг 2.5 га болгон томсгож, 2024 онд бэлтгэсэн нутгийн ургамлын үрээр 2025 оны 04 дүгээр сарын 15-аас 05 сарын 15-ны хооронд 64,462 ш бортогонд тарилт хийсэн Зураг 24).



Зураг 24. Бортогонд үрээр бэлтгэсэн суулгацын тоо, 2025 он

Газрын тухай хуулийн 56 дугаар бүлгийн 56.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн 10 хувь буюу 230.8 га талбайд мод тарих төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж 3 байршилд 4 га талбайд өөрсдийн бэлтгэсэн тарьц суулгацаар мод тарих ажлыг гүйцэтгэсэн. Уурхайн кэмп болон оффисийн ногоон байгууламжийн тохижилтонд 4,663 ш хайлаас, тусгай зөвшөөрлийн талбай дотор буюу мод үржүүлгийн газрын хойд тал, замын дагуу 8,170 ш нийт 13,373 ш модыг тарьсан.

Мод тарих ажилд дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, газрын доорх усны нөөцийг хэмнэлттэй хэрэглэх зорилгоор Шинэжинст сумын Уртын гол багийн Эхийн гол гэх газарт 2024 онд мод тарихад хэрэглэсэн Тайвань улсад үйлдвэрлэдэг “мод усалгааг дэмжих хувин” туршихаар 800 ширхэгийг худалдан авсан. Уг хувин нь цаасыг дахин боловсруулж хийсэн, байгальд шингэдэг, сарын турш 8 л усаар модыг чийгтэй байлгах давуу талтай юм. Мод үржүүлгийн талбайн хойд талд 600 ш заг модыг, Шинэжинст сумын Уртын гол багийн иргэн Ш.Ганбаттай хамтран Гүн заг хэмээх газарт 200 ш модыг хувинд тус тус тарьж, ургуулсан (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Тарьсан мод, 2025 он

№	Модны нэр	Тоо ширхэг	Тарьсан талбайн нэр
1	Заг	5033	Мод үржүүлгийн талбайн хойд тал
2	Шар модон хотир	170	Мод үржүүлгийн талбайн хойд тал
3	Тайваны шумбагч завьтай заг	600	Мод үржүүлгийн талбайн хойд тал
4	Заг	2367	Мазаалай кемпийн баруун тал
Нийт			8170
1	Хайлаас	4512	Кемп, оффис
2	Сухай	75	Оффис
3	Заг	35	Кемпийн гадаа
4	Заг	35	Зочдын байрны гадна тал
5	Сухай	6	Зочдын байрны гадна тал
Нийт			4663



Зураг 25. Мод тарьсан талбай



Зураг 26. Усалгааг дэмжих хувин

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Барилгын суурийн буцаан дүүргэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг сунгах тухай” А/727 дугаар захирамжаар олгогдож, 2024 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг нутгийн ургамлын үрээр тарилт хийж, 06 дугаар сарын 10-наас 08 дугаар сарын 20-ний хооронд 15 куб.м багтаамжтай усны машинаар усалгааг өдөр бүр хийсэн (Зураг 27).



Зураг 27. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай

Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Шимт хөрсийг овоолгод тогтвортой байршуулж, нөхөн сэргээлтэд ашиглахад бэлтгэх	Ил уурхайн 2025 онд олборлолтод өртөх 19.9 га талбайгаас зохистой хэмжээний зузаантай хуулсан шимт болон шимэрхэг хөрсний овоолгыг үүсгэх	м ³	59,700	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хөндий ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө	Ил уурхайн олборлолтод өртсөн 15.3 га талбайгаас 0.3 м зузаантайгаар 119,588.61м ³ шимт болон шимэрхэг хөрсийг хуулж, ТЭЗҮ-д тусгагдсан 3 байршилд “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008” стандартын шаардлагад нийцүүлэн 5 м-ээс илүүгүй өндөр овоолго үүсгэн хадгалж эхэлсэн. <i>Зураг 6. Шимт хөрсний овоолго</i>	Үйл ажиллагааны зардлаас
	Мазаалай кэмпийн урд талын шимт хөрсний овоолгын хөрсний үржил, шимт чанарыг алдагдуулахгүй байх зорилгоор хэсэгчилсэн байдлаар үрээр тарилт хийж эхлэх	га	0.5	MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт	Мазаалай кэмп, зочдын амрах байр, цэвэрлэх байгууламж, кэмп орчмын зам зэргээс хуулсан 10,848 м ³ шимт болон шимэрхэг хөрсийг стандартын шаардлага хангасан овоолгыг үүсгэж, 750 кв.м талбайд 05 дугаар сарын 10-ны өдөр нутгийн ургамлын үрээр тарилт хийн, усалгааг тогтмол хийсэн. <i>Зураг 23. Шимт хөрсний овоолгын арчилгаа</i>	6,187.500
Нөхөн сэргээлтэд хэрэглэх тарьц суулгац бэлтгэх	Нутгийн ургамлын үр түүх	кг	26	Байгалийн ургамлын тухай хууль 13.3	Нутгийн ургамлын үрээр биологийн нөхөн сэргээлт хийх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг дэсвгэрээс шар модон хотирын 4 кг, хайлаасны 3 кг, лидэрийн 2 кг, чихэр өвсний 3 кг, тоорой модны 2 кг, жигд модны 2 кг, заг модны 10 кг нийт 26 кг үрийг түүсэн. Аймгийн Байгаль орчны газрын 2025.07.25-ны өдрийн 302 тоот албан бичгээр ирүүлсэн албан бичгийн дагуу үр түүх талбайн үрийн нөөцийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр Геоэкологийн хүрээлэн, ХААИС-аас саналыг	Үйл ажиллагааны зардлаас

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
					авахад ургамлын ургалтын хугацаанд буюу 07 сард хээрийн ажлыг гүйцэтгэх боломжтой гэсэн хариуг өгсөн. Иймд үр түүх талбай, үрийн нөөцийн судалгааг 2026 онд ургамлын ургалтын хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөн 2026 оны төсөвт тусгасан.	
	Үрсэлгээ бэлтгэх	ш	10,000		Жилд бэлтгэх тарьц, суулгацын тоог нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрыг 2.5 га болгон нэмэгдүүлж, урьд онд бэлтгэсэн нутгийн ургамлын үрээр 64462 ш бортогонд тарилт хийсэн. <i>Хүснэгт 5. Тарьсан мод, 2025 он</i>	93,560.500
	Салхины нөмөрлөгчийн зориулалтаар ургамал үржүүлгийн талбайд мод тарих	ш	4,500	“Эрдэнэ Монгол” ХХК-ны “Баян Хөндий” төслийн “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг дэмжин 1 сая мод тарьж ургуулах техник, эдийн засгийн үндэслэл Монголын ойн салбарын мэргэжлийн холбоодын нэгдэл НҮТББ 2024 он	Өмнөх жилүүдэд бэлтгэсэн суулгацыг тусгай зөвшөөрлийн талбай дотор мод үржүүлгийн зориулалтаар эзэмшиж байгаа талбайд шилжүүлэн суулгах ажлыг 2024 онд эхлүүлсэн бөгөөд энэ онд үргэлжлүүлэн, уурхайн кэмп болон оффисын ногоон байгууламжийн тохижилтод 4662 хайлаасны /Ulmus pumila/ суулгацыг шилжүүлэн суулгасан.	43,636.235
	Төслийн эзэмшлийн талбайд суулгац шилжүүлэн тарих	ш	3,000		Газрын тухай хуулийн 56 дугаар бүлгийн 56.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн 10 хувь буюу 230.8 га талбайд мод тарих төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж 4 га талбайд 8170 ш модыг тарьсан. <i>Зураг 25. Мод тарьсан талбай</i> <i>Хавсралт 24. Мод тарьсан талбайн байрилын зураг</i>	
	Модны усалгааг дэмжих хувинг туршилтаар хэрэглэх	ширхэг	500		Мод тарих ажилд дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, газрын доорх усны нөөцийг ариг гамтай хэрэглэх зорилгоор Шинэжинст сумын Уртын гол багийн Эхийн гол гэх газарт 2024 онд мод тарихад хэрэглэсэн Тайвань улсад үйлдвэрлэдэг “мод усалгааг дэмжих хувин”-ийн шумбагч завь загвараас	67,344.0

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
					800 ш -ийг худалдан авсан. Уг хувин нь 8 л усаар нэг сарын турш модыг чийгтэй байлгадаг, байгальд шингэдэг, цаасыг дахин боловсруулан хийсэн. Туршилтын байдлаар 2025 онд 800 ш хувин худалдан авч, тусгай зөвшөөрлийн талбайд 600 ш заг мод, Шинэжинст сумын Уртын гол багийн иргэн Ш.Ганбаттай хамтран Гүн заг хэмээх газарт 200 ш модыг хувинд тарьсан. <i>Зураг 26. Усалгааг дэмжих хувин</i> <i>Хавсралт 25. Услагааг дэмжих хувин хэрэглэх заавар</i>	
Газрын гадарга, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах	Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан анхны төрхөд ойртуулах	га	1	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008” Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны “Аргачлал батлах тухай” А/138 тушаал	Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Барилгын суурийн буцаан дүүргэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг сунгах тухай” А/727 дугаар захирамжаар олгогдож, 2024 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг нутгийн ургамлын үрээр тарилт хийж, 06 дугаар сарын 10-наас 08 дугаар сарын 20-ний хооронд 15 куб.м багтаамжтай усны машинаар усалгааг өдөр бүр хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас
	Хайгуулын ажлын үйл ажиллагаагаар эвдрэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлтийн стандартыг	м ³	7,200		Тайлант хугацаанд геологи хайгуулын үйл ажиллагаа явуулаагүй.	-

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
	баримтлан анхны төрхөд ойртуулах					

2.5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэ Монгол” ХХК нь төслийн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг ахиу нөлөө үзүүлэх зорилготой ажиллаж байгаа билээ. Уулын туруутан амьтдад биотехникийн арга хэмжээг Шинэжинст сумын Засаг Даргын Тамгын Газартай хамтран 01 – 02 дугаар саруудад, #SaveMazaalai хөтөлбөрийг хэрэгжүүлж, ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргаатай хамтран мазаалай баавгайд хорголжин тэжээл тавьж өгөх ажлуудыг 2 дахь жилээ дараалан амжилттай зохион байгуулсан (Зураг 28).



Зураг 28. Биотехникийн арга хэмжээ


Нутгийн иргэдтэй хамтран мод тарих хөтөлбөрийг 2024 онд 4 иргэн 1 байгууллагатай гэрээ байгуулснаар хэрэгжүүлж эхлэн 5520 ш модыг тарьсан. Тайлант онд уг хөтөлбөрийг өргөжүүлэн шинээр 5 иргэнтэй байгуулж, 4974 ш модыг тарьсан. Тус хөтөлбөрийн онцлог нь өөрийн эзэмшлийн газартаа мод тарих сонирхолтой, тодорхой шалгууруудыг хангасан иргэдэд Эрдэнэ Монгол ХХК-аас мод тарихад шаардагдах бүх бараа материал, өөрсдийн үржүүлсэн тарьц суулгацаар бүрэн хангахын зэрэгцээ тарилтын хугацаанд сард 1-ээс доошгүй удаа талбайн хяналт хийж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөхөөс гадна намрын тооллогын үр дүнг үндэслэн ургаж байгаа модны тоогоор 1 ш мод тутамд 5,000 төгрөгний урамшуулал олгодог (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан мод, 2025 он

Иргэдийн нэр	Талбайн нэр	Талбайн хэмжээ/га	Тарьсан модны тоо
Д.Түвшинбат	Өлзий овоо (Эрдэнэшанд баг)	1	1082
Б.Алтангэрэл	Зараа 1-р баг (Дөхөм)	1	1000
М.Болдцэрэн	Уртын гол 2-р баг (Сухайт)	1	785
Э.Өнөр-Амгалан	Эрдэнэшанд баг	0.3	500
ИББЦГ-ын ХЗ	Баянлиг сум	1	1000
Ч.Уранбилэг	Улаан худаг	1	700
Ш.Ганбат	Гүн заг	1	200
Б.Баттулга	Хүрэнгийн үзүүр	1	70
С.Цэцэгням	Шинэжинст сумын төв	0.7	10
Н.Отгонбат	Шинэ хашаа төсөл	0.7	45
Нийт		8.7	5,392



Зураг 29. Нутгийн иргэдийн тарьсан мод



Зураг 30. Нутгийн иргэдтэй хамтран тарьсан мод, хувиар (2025 он)

Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Шинэжинст суманд хөв байгуулах байршлын талаар аймгийн БОГ-аас санал авахаар албан бичиг хүргүүлэхэд сумтай зөвшилцөн шийдвэрлэ гэж зөвлөсний дагуу сумын Засаг Даргад албан хүсэлт гаргаж, улсын тусгай хамгаалалттай газар нутаг болох Уртын гол багийн нутаг дэвсгэр Цагаан дэрс гэх газарт хөв байгуулахаар тогтсон. Баян-Өндөр сумын Идрэн 4-р багийн Ламын тооройд нарын өргүүр суурьлуулах, 15 куб.м багтаамжтай ус хуримтлуулах хөв байгуулах ажлыг 2024 онд хийсэн Баялаг говь ХХК-тай дахин гэрээ байгуулж, 10 дугаар сард багтаан өмнөхтэй яг адил нарны өргүүр суурьлуулан, хөв байгуулахаар ажиллаж байна.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Дүйцүүлэн хамгаалалт зорилт	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт, сайн туршлага	Тоо хэмжээ, ширхэг	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Бүс нутгийн биологийн төрөл зүйлийн судалгаа	Баянхонгор аймгийн говийн бүсийн сумдын биологийн төрөл зүйлийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх	Баянхонгор аймгийн БОГ-ын 2025.02.05-ны өдрийн Санал хүргүүлэх тухай 56 тоот албан бичиг	1	Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Хэрэглээний Шинжлэх ухааны сургуультай “Баянхонгор аймгийн говийн бүсийн сумдын биологийн төрөл зүйл, амьтан ургамлын ерөнхий судалгааг хийх” тухай гэрээг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Судлаачид 2 үе шаттай судалгааны ажил гүйцэтгэж, Баянхонгор аймгийн 12 сумын нутагт 228 зүйл ургамал, 170 зүйл шавж, 2 зүйл загас, 1 зүйл хоёр нутагтан, 8 зүйл мөлхөгч, 26 зүйл хөхтөн, 115 зүйл шувууг бүртгэжээ. Тайлангийн нэг хувийг аймгийн Байгаль орчны газарт хүргүүлсэн.	50,000.0
Байгалийн амьдрах орчныг нөхөн сэргээх	Тарьц, суулгац бэлдэх	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод тарих" үндэсний хөдөлгөөн	2,000	Жилд бэлтгэх тарьц, суулгацын тоог нэмэгдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрыг 2.5 га болгон нэмэгдүүлсэн, 64462 ш бортогонд тарилт хийсэн. суулгац бэлтгэсэн. <i>Хүснэгт 5. Тарьсан мод, 2025 он</i>	Үйл ажиллагааны зардлаас
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	Нутгийн иргэдтэй хамтран мод тарих		4,500	Нутгийн иргэдтэй хамтран мод тарих хөтөлбөрийг 2024 онд 4 иргэн 1 байгууллагатай гэрээ байгуулснаар хэрэгжүүлж эхлэн 5520 ш модыг тарьсан. Тайлант онд уг хөтөлбөрийг өргөжүүлэн шинээр 5 иргэнтэй байгуулж, 4974 ш модыг тарьсан.	22,500.0
	Шинэжинст сумд хөв байгуулах	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 9.6 дугаар заалт	1	Зэрлэг амьтны усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг дэвсгэр Цагаан дэрс гэх газарт нарын өргүүр суурьлуулах, 15 куб.м багтаамжтай ус хуримтлуулах хөв байгуулах ажлыг гүйцэтгэх гэрээг “Баялаг говь” ХХК-тай 10 дугаар сарын 06-ны өдрөөс ажлыг эхлүүлэхээр байгуулсан. Ажлыг гүйцэтгэх ажил 10 сарын 17-оос эхэлсэн. <i>Хавсралт 26. Ажил гүйцэтгэх гэрээ</i>	19,000.0

	Бэлчээрийн ус хангамжийг сайжруулах (худаг засварлах)		2	<p>Шинэжинст сумын Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 21 тоот албан хүсэлтийн дагуу Уртын гол багийн Гүн загийн худаг, Баруун усны шанд, Баруун ус, Майхан хүрэн хэмээх бэлчээрийн 4-н худгуудад худгийн байр, мал услах онгоц байршуулж тохижуулсан. БОМТ-ний биелэлт дүгнэх комиссын өгсөн зөвлөмжийн дагуу замын нөлөөлөлд өртөж байгаа Үзүүр худагийг хамгаалах байр барихаар ажлын даалгавар батлагдсан. Худгийн байр барих ажил 11 сард багтаан хийгдэж дуусна.</p> <p><i>Хавсралт 27. Ажлын тайлан</i></p>	Үйл ажиллагааны зардлаас
	Шинэжинст сумын нутаг дэвсгэрт зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх		1	<p>Шинэжинст сумын байгаль хамгаалагч нартай хамтран 02 дугаар сарын 19-өөс 22-ны хооронд Тахилгат, Харын энгэр, Толь булаг, Эрдэнэшанд баг, Цармын уул, Агьт, Цагаан хаалга хэмээх газруудад 100 боодол өвсийг тараан байршуулсан ба 100 боодол өвсийг Засаг Даргын Тамгын Газарт хүлээлгэн өгсөн.</p> <p>Мазаалай баавгайд тэжээл тавих ажлын хүрээнд нийт 1000 кг хорголжин тэжээлийг Сэгс Цагаан Богд уулын Цагаан дэрс, Хармагтай, Хөх тэжээлийн савнуудад тараан байршуулсан.</p>	9,100.0

2.6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Д.Баасандаш (1.9 км), Б.Ганбат (2.8 км), П.Нямсүрэн (3.2 км) нарын өвөлжөөний газар хамгийн ойр байршдаг. Дээрх малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд тайлант хугацаанд нутаглаагүй хэдий ч төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс барилга угсралтын үе шатанд тухайн газруудад дуу, шуугиан болон салхины хурдыг сар бүр хэмжиж байна.

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, тоосжилтоос ойролцоо нутаглаж буй малчин өрхүүдэд тавгүй байдал үүсгэж болзошгүй	Уурхайн үйл ажиллагаанаас үүсч буй дуу чимээ, тоосжилт нь ойролцоо өвөлжөөнүүдийн орчимд агаарын чанарын стандарт хэмжээнд байгаа эсхийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тодорхойлох, нөлөөллийн бүсийн өвөлжөөнд дуу чимээ, тоосжилтын хэмжээ стандартаас давсан тохиолдолд бууруулах арга хэмжээг тухай бүрт төлөвлөх	Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2021 он	Баянхөндий төслийн ил уурхай, барилга байгууламжууд барих талбайгаас баруун урагш 1.9-3.2 км зайд 3 өрх малчин өрхийн өвөлжөө зориулалттай эзэмшил газар байдаг. Малчин өрхүүд нь тухайн бууцыг улирлын чанартайгаар ашигладаг бөгөөд энэ онд эзэмшлийн газартаа болон төслийн талбайн ойролцоо айлууд нутаглаагүй. <i>Хавсралт 28. Хэмжилтийн тайлан</i>	Үйл ажиллагааны зардлаас

2.7.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёлын өв олдох магадлалтай. Хэрэв барилгын болон олборлолтын үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд газар шорооны ажлыг зогсоож дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өмнө нь судалж тогтоож чадаагүй палеонтологи болон археологийн үнэт олдвор илэрвэл илэрсэн даруйд ажлаа зогсоож, олдворын талаар сум/аймгийн Засаг даргад мэдэгдэнэ.
- Бүртгэсэн соёлын өв, түүхийн үнэт олдворын эргэн тойронд эрх бүхий байгууллагын зөвлөмжийн дагуу хамгаалалтын бүс байгуулах ба хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий байгууллага бүртгэгдсэн тэдгээр зүйлсийг нүүлгэн шилжүүлэх ажилд дэмжлэг үзүүлнэ.

- Чухал ач холбогдол бүхий түүх соёлын олдвор, үнэт зүйлс олдсон тохиолдолд зөөвөрлөнө. Ингэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журам”-ыг баримтална.
- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.

Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Нөлөөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Баримталх стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Газар шорооны ажлын үед том оврын техник хэрэгслээр хөрс хуулах, суваг шуудуу ухах зэрэг ажил хийгдэх явцад өмнөх судалгааны явцад илрээгүй, хөрсөнд хадгалагдан үлдсэн байж болзошгүй археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар тохиолдож, нөлөөлд өртөх	Археологи, палентлогийн олдвор олдсон үед хэрэгжүүлэх зааварчилгааг уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөрийн дагуу ажилтнуудад олгох	“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.	Баянхөндий төслийн талбайд ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор судалгаагаар илрээгүй. Гэвч төслийн газар шорооны ажлын явцад соёл өв олдох магадлалтай учраас үйл ажиллагааны явцад олдвор илэрсэн олдсон тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтыг нийт ажилтнуудад “Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр”-өөр дамжуулан олгодог. <i>Хавсралт 29. Сургалтын материал</i>	-
	Олдвор илэрсэн тохиолдолд орон нутгийн захиргаа, мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, туслалцаа үзүүлэн хамтарч ажиллах	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, 27.8	Барилга угсралтын үе шатанд болон ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны үед ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор олдоогүй.	-


2.8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Эрдэнэ монгол” ХХК нь үндсэн болон гэрээт аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудын хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, олон улсын стандарт, конвенц, ил уурхайн аюулгүй байдлын дүрэмд зааснаар хангаж ажилладаг.

Бид зөвхөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-шаардлага, хэрэглэх заавар ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлээд зогсохгүй чанарын

менежментийн тогтолцоо-шаардлага ISO 9001:2015, байгаль орчны менежментийн тогтолцоо. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар ISO 14001:2015 стандартыг цогцоор нь 2027 оноос хэрэгжүүлж, Монгол улсын уул уурхайн компаниудын дунд үлгэр жишээ менежментийн тогтолцоог системтэйгээр бий болгож ажиллах зорилготой.

Гамгаас хамгаалах төлөвлөгөө, гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн ажилтнуудыг гамшиг, ослын үед хэрэгжүүлэх дадлага, сургуулалтиудыг улирал тутам зохион байгуулдаг. Онцгой байдлын ерөнхий газар, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар, Эрдэнэ Монгол ХХК-ийн хамтран баталсан удирдамжийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 14-ний өдөр “Химийн бодистой ажиллах” Штабын дадлага сургуулилтыг зохион байгуулав. Дадлага, сургуулилтын үйл ажиллагааг Төслийн удирдлага хариуцсан захирлын баталсан “Химийн бодистой ажиллах” дадлага, сургалтын удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан ба 41 ажилтан хамрагдав. Сургалтад хамрагдсан нийт ажилтнуудыг ажил, мэргэжлийн ижил төстэй байдлаар нь 4 баг болгож, Газар хөдлөлтөөс бий болсон гал, Цианид, давсны хүчлийн асгаралтын гамшгийн үед авах арга хэмжээ, зохион байгуулж, төлөвлөж ажилласан (Цагийн байдал-3).



Зураг 31. Дадлага сургуулилалт

Химийн бодисын агуулах “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS6458:2014” Стандартын шаардлага хангасан буюу 1.8 өндөр хамгаалалтын хашаатай, хашааны хаалга цоожтой, шөнийн цагаар гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй, хаалганы босго нь шингэн урсахаас сэргийлсэн налуу өндөрлөгөөтэй, үерийн далан, сувагтай, ой хээрийн түймрээс хамгаалах зурвастай ба А зэрэглэлийн хорт болон аюултай бодис хадгалах агуулахууд дотроо болон хүдэр боловсруулах үйлдвэрийн орчим бүхэлдээ хяналтын камертай. Асгаралт алдагдлын үед хэрэглэх асгаралтын иж бүрдэл, шингэн ИВС танк цоорч гоожсон тохиолдолд хэрэглэх бүслүүр шаантгийг зохих агуулахад байрлуулсан. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу хамт хадгалахад хориотой бодисуудыг тус тусад нь өөр өөр агуулахад тараан байрлуулсан. Химийн бодисын агуулахыг барихдаа хадгалах бодисуудыг урьдчилан тооцоолж, агуулахыг байрыг 13 тусдаа тасалгаатай байхаар барьсан.

“Химийн бодис захиалгаар худалдах, худалдан авах тухай” EMC/25110/000 дугаартай гэрээг Цэцүүх трейд ХХК-тай 2025 оны 04 сарын 29-нд байгуулсан. Гэрээгээр химийн хорт болон

аюултай бодис худалдаж авах, тэдгээрийг болон сав баглаа боодлыг тээвэрлэх, устгах харилцааг зохицуулсан.

Хүдэр боловсруулах үйлдвэрт синилийн хүчлийн Draeger Polytron 7000 загварын суурин хэмжигч багажийг 3 цэгт байрлуулсан ба үйлдвэрийн 1 жилийн баталгаатай. Цаашид албан ёсны дистрибьютер компаниар дамжуулж жил бүр баталгаажуулалт хийлгэнэ.

Уусмалын орчин хэмжих буюу суурин рН метрийг 3 цэгт байрлуулсан ба тогтмол хугацаанд буфер уусмал ашиглаж тохируулга хийдэг. Draeger брендийн синилийн хүчил мэдрэгч 8000 загварын 4 ш зөөврийн багажийг үйлдвэрийн операторуудад тогтмол ашиглуулдаг.




Зураг 32. Синилийн хүчил мэдрэгч



Зураг 33. Синилийн хүчил хэмжигч

Тэсэлгээ хийгдэхээс 24 цагийн өмнө компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “MINE.EM.00.02 Тэсэлгээний үеийн аюулгүй ажиллагааны заавар”-ын дагуу албан мейл болон уурхайн нийт орц гарцын хэсэгт байрлах самбаруудад тэсэлгээний огноо, цаг, минут, блокын тухай мэдээллийг байрлуулдаг. Тэсэлгээ болохоос өмнө харуулын хурлыг хийж, орц гарцуудыг хаан, тэсэлгээний харуулыг байрлуулдаг ба тэсэлгээний блокоос 300 м радиус доторх техник тоног төхөөрөмж, хүн хүчийг гаргаж, тэсэлгээний бүсийг бүрэн чөлөөлдөг.



Зураг 34. Тэсэлгээний мэдэгдэл

Ил уурхайд хамгийн ойр байрлах байгууламж буюу Засварын газрын дэргэд **SYSCOM MR3003BLA** чичирхийлэл хэмжих төхөөрөмжийг байрлуулан 10 сарын 03-аас эхлэн тэсэлгээ тус бүрийн чичирхийллийн долгионы хурд болон, агаарын цохилтын долгионы даралтыг хэмжин, бүртгэж, өгөгдлийн сан үүсгэж байна. Хэмжилт эхэлснээс хойш болсон тэсэлгээний дундаж үзүүлэлтээр, PPV (Peak Particle Velocity) =4.2mm/s, Airblast буюу агаарын цохилтын долгион 128,5 dB (decibel) байна.



Зураг 35. Тэсэлгээний чичирхийлэл хэмжигч

Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
Гал түймэр гарах	Галын идэвхитний бүлэг байгуулж, бүлгийн ажилтнуудыг сургалт дадлагад хамруулах	2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4.	Салбарын захирлын 2025 оны 01 сарын 21-ний өдрийн “Галын аюулаас урьдчилан сэргийлэх орон тооны бус байнгын бүлгэм байгуулах тухай” А/02 тоот тушаалаар байгуулагдаж, 2025 оны 6 сарын 14, 7 сарын 10-ны өдрүүдэд гамшгаас хамгаалах дадлага сургуулилалтыг зохион байгуулж нийт 50 ажилтан хамрагдсан. <i>Зураг 31. Дадлага сургуулилалт</i>	Үйл ажиллагааны зардлаас
	Гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж дагаж мөрдөж ажиллах	1		Гал унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулан, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газраар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Уурхайн гал унтраах дадлага сургуулилалтыг 07 сарын 10-нд зохион байгуулж, 23 албан хаагч оролцсон.	Зардал шаардагдаагүй
	Бүх ажлын талбайд аюулын гарцын байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах хоолойд зөвшөөрөгдсөн тэмдэг тавих	Бүх ажлын байранд		Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Бүх барилга байгууламж, ажлын талбарт 50 ш аюулын гарцын байрлалыг заасан самбар, 61 ш 4 кг, 4 ш 5 кг, 14 ш 6 кг, 7 ш 35 кг гал унтгаагуур, 46 ш тунгус, 5 ш галын сарай, 8 ш аврах гарцын схем, 603 ш галын дохиолол, 30 ш гал унтраах хоолой суурьлуулсан ба гал унтраах машин байнгын бэлэн байдалд байдаг. Онцгой байдлын 1 ажилтан, 5 аврагч, гал сөнөөгч, жолооч ажиллаж байна.
Байгалийн гамшигт үзэгдэл	Төслийн хэмжээнд гамшигаас хамгаалах төлөвлөгөө батлуулж бэлэн байдлыг хангах	1	Гамшигаас хамгаалах тухай хууль	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Баянхонгор аймгийн Онцгой байдлын газраар 02 сарын 20-нд батлуулсан. Тайлант хугацаанд байгалийн гамшигт үзэгдэл тохиолдоогүй. Гамшгаас хамгаалах дадлага сургуулалтыг Онцгой байдлын ерөнхий газартай хамтран 06 сарын 14-ний өдөр зохион байгуулж, 41 ажилтан оролцсон.	-
Химийн хортой болон аюултай бодисын хадгалалт	Химийн хортой болон аюултай бодисуудыг хор аюулын лавлах мэдээлэлд тусгасны дагуу хадгалах	Тухай бүр	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу хамт хадгалахад хориотой бодисуудыг тус тусад нь өөр өөр агуулахад тараан байрлуулсан. Химийн бодисын агуулахыг барихдаа хадгалах бодисуудыг урьдчилан тооцоолж, агуулахыг байрыг 13 тусдаа тасалгаатай байхаар барьсан.	Үйл ажиллагааны зардлаас

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
			мэндийн сайдын 2017 оны 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал		
	Химийн бодисын агуулахыг хашаажуулах, бүх өрөөг камержуулах	Хашааны нийт урт 164 м, хяналтын камер 11 ш	“MNS 6458 :2014 Ерөнхий шаардлага. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах”	Стандартын шаардлага хангасан буюу 1.8 өндөр хамгаалалтын хашаатай, хашааны хаалга цоожтой, шөнийн цагаар гэрэлтүүлэх гэрэлтүүлэгтэй, А зэрэглэлийн хорт болон аюултай бодис хадгалах агуулахууд дотроо болон хүдэр боловсруулах үйлдвэрийн орчим бүхэлдээ хяналтын камертай.	Үйл ажиллагааны зардлаас
Химийн хортой болон аюултай бодисын ашиглалтаас сөрөг нөлөөлөл үзүүлэх	Хүдэр боловсруулах үйлдвэрт ашиглах зөөврийн болон суурийн хэмжигч багажуудыг баталгаажуулалтад бүрэн хамруулсан байх	Хэмжигч багажны тоогоор	Хэмжил зүйн тухай хууль, 2019 он	Синилийн хүчлийн Draeger Polytron 7000 загварын суурин хэмжигч багажийг 3 цэгт байрлуулсан ба үйлдвэрийн 1 жилийн баталгаатай. Цаашид албан ёсны дистрибьютер компаниар дамжуулж жил бүр баталгаажуулалт хийлгэнэ. Уусмалын орчин хэмжих буюу суурин рН метрийг 3 цэгт байрлуулсан ба тогтмол хугацаанд буфер уусмал ашиглаж тохируулга хийдэг. Draeger брэндийн синилийн хүчил мэдрэгч 8000 загварын 4 ш зөөврийн багажийг үйлдвэрийн операторуудад тогтмол ашиглуулдаг. <i>Зураг 32. Синилийн хүчил мэдрэгч</i> <i>Зураг 33. Синилийн хүчил хэмжигч</i>	Үйл ажиллагааны зардлаас
	Хаягдал дахь химийн бодисын агуулгыг тогтмол хянах	Өдөрт 1 удаа	“MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”	“АЛС Глобал” лабораторитой гэрээлэн хаягдалд нийт цианидын шинжилгээг хийлгэдэг. Үйлдвэрийн өдөр тутмын технологийн шинжилгээний хүрээнд цаг тутамд хаягдлыг шүүж, шүүсэн усанд чөлөөт цианидын шинжилгээ хийдэг. <i>Хавсралт 30. Цианидын шинжилгээний хариу</i>	Үйл ажиллагааны зардлаас
Тэсэлгээний үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, чичирхийлэл	Тэсэлгээний ажлын аюултай бүсийг чөлөөлөх /хүн, техникийн аюултай бүсээс гаргах/	Тэсэлгээний ажил хийгдэх бүрт	Засгийн газрын 2019 оны “Дүрэм батлах тухай” 313 тогтоол “Тэсэлгээний Ажлын Аюулгүй Ажиллагааны Нэгдсэн дүрэм”	Тэсэлгээ хийгдэхээс 24 цагийн өмнө компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан “MINE.EM.00.02 Тэсэлгээний үеийн аюулгүй ажиллагааны заавар”-ын дагуу албан мейл болон уурхайн нийт орц гарцын хэсэгт байрлах самбаруудад тэсэлгээний огноо, цаг, минут, блокын тухай мэдээллийг байрлуулдаг. Тэсэлгээ болохоос өмнө харуулын хурлыг	Зардал шаардагдаагүй

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
				хийж, орц гарцуудыг хаан, тэсэлгээний харуулыг байрлуулдаг ба тэсэлгээний блокоос 300 м радиус доторх техник тоног төхөөрөмж, хүн хүчийг гаргаж, тэсэлгээний бүсийг бүрэн чөлөөлдөг. Тэсэлгээний ажлын дараа тэсэрсэн талбайг шалгаж, тэсэлгээний удирдагчийн зөвшөөрлөөр уурхайг нээдэг.	
	Тэсэлгээнээс үүсэх чичирхийлэлтийг хэмжих	Тухай бүр		Уурхайн бүсэд хамгийн ойр байрлах байгууламж буюу Засварын төвийн дэргэд SYSCOM MR3003BLA чичирхийлэл хэмжих төхөөрөмжийг байрлуулан 10 сарын 03-аас эхлэн тэсэлгээ тус бүрийн чичирхийллийн долгионы хурд болон, агаарын цохилтын долгионы даралтыг хэмжин, бүртгэж, өгөгдлийн сан үүсгэж байна. Хэмжилт эхэлснээс хойш болсон тэсэлгээний дундаж үзүүлэлтээр, PPV (Peak Particle Velocity) =4.2mm/s, Airblast буюу агаарын цохилтын долгион 128,5 dB (decibel) байна.	Үйл ажиллагааны зардлаас
Тэсрэх бодисыг буруу хадгалалтаас үүдэн гал гарах	Тэсрэх бодисыг зориулалтын агуулахад хадгалж, бодисын нөөц, хэрэглээг бүртгэх	8 удаа		Тэсрэх бодисын агуулах нь 15,000 кв.м талбайтай, 5 ш агуулахад 2 төрлийн 100,000 кг бодис, 12,000 кг тэсэлгээний хэрэгсэл агуулах хүчин чадалтай. Тайлант оны 10 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 65 удаагийн тэсэлгээ хийхэд 433,555.2 кг бодис зарцуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
Хүний эрүүл мэнд муудах	Үндсэн болон гэрээт гүйцэтгэгчдийн ажилтнуудыг “Анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-нд хамруулах шинэ ажилтны сургалтаар Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа	Сургалт авсан ажилчдын тоо	Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхөндий алтны уурхайн шинэ ажилтны аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр Салбарын захиргааны албаны дарга 2024.04.28-нд баталсан.	Нийт ажилтнуудад “Ерөнхий зааварчилгаа”-аар дамжуулан эргүүлэх байрлалд оруулах, CPR буюу зүрх уушгины сэхээн амьдруулалт хийх, цус алдалдын үеийн анхны тусламж зэрэг агуулгуудаар анхны тусламжийг хэрхэн олгох талаар мэдлэг олгодог, шинэ ажилтны сургалтад 10 сарын 12-ны байдлаар давхардсан тоогоор 910 ажилтан хамрагдсан. <i>Хавсралт 31. ХАБЭА сургалтын төлөвлөгөө, 2025 он</i>	Үйл ажиллагааны зардлаас
	Ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Үзлэгт хамрагдсан ажилчдын тоо	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг	Эрдэнэ Монголд ХХК-д Энержи ресурс ХХК-аас шилжиж ирсэн 56 нь хүнд машин механизмын операторууд өмнөх компанид ажиллаж байхдаа эрүүл	

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө (мян. төгрөг)
				мэдний үзлэгт орсон. Энэ онд шинээр орсон 165 ажилтнуудын 56 нь Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлсэн, бусад нь мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын төвд үзүүлсэн. Хугацаат үзлэгт орох ажилчдыг ростерийн хуваарьтай нь уялдуулан 10-р сарын 08, 17, 24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод “Гранд Мед” эмнэлэг дээр үзлэгт оруулах ажил эхлэн, үргэлжилж байна.	Үйл ажиллагааны зардлаас
	Хүний эрүүл мэнд муудахад анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бол хамгийн ойрын дараагийн шатны эмнэлэг рүү нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Анхан шатны үзлэгээр дараагийн шатны эмнэлэгт үзүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг	Яаралтай тусламжийн нэгж өдөр шөнийн ээлжээр 24 цагийн турш 4 хүний их эмч ээлжээр ажилладаг. Хамгийн ойрын дараагийн шатны эмнэлэг рүү нүүлгэн шилжүүлэлтийг зориулалтын тоноглогдсон тээврийн хэрэгслээр хүний их эмчийн хяналтан дор гүйцэтгэдэг. Тайлант хугацаанд 12 өвчтнийг дараагийн шатны эмнэлэгт шилжүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас
	Химийн бодисын хордолгын үед яаралтай тусламж үзүүлэх сургалт зохион байгуулах	Шаардлагатай тохиолдолд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг	Монголын химич, химийн инженер технологичдын холбооны сургалтад химийн бодистой харьцан ажилладаг 38 ажилтныг танхимаар, 60 ажилтан онлайнаар нийт 98 ажилтныг хамруулсан. Монгол Улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын Ерөнхий газар, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газартай хамтран химийн ослын үед ажиллах дадлага сургуулалтыг 06 сарын 14-нд зохион байгуулж 41 ажилтан хамрагдсан.	Үйл ажиллагааны зардлаас
9.2	ГТН-д өөрөөр заагаагүй бол Гэрээний үнийг Төгрөгөөр илэрхийлнэ. Хэрэв гадаад валютаар нэрхийлсэн бол ГТН-д заасны дагуу хөрвүүлэгт нэхэмжлэх дээр өгсөны тухай өдрийн Монгол банкны албан ёсны ханшийг баримтална.
9.3	ГТН-д өөрөөр заагаагүй бол Гэрээний үнэд бүхий л холбогдох татвар, хураамж, шимтгэл ХАБЭА-тай холбоотой төсөв, зардал багтсан байна.
9.4	ГТН-д өөрөөр заагаагүй бол Гэрээний үнэд өөрчлөлт оруулахгүй. Инфляц, төлбөр гүйцэтгэх валютын ханшийн өөрчлөлт, ажилчдын цалин, хөлс, түлшний үнийн өөрчлөлт Гүйцэтгэгчийн бодит болон магадланшгүй ажлын зардлын өсөлт зэрэг бусад материалын зардлын өөрчлөлт зэрэг нь Гэрээний үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

9.5	Захиалагч нь Гүйцэтгэгчээс авах аливаа нөхөн төлбөр, алданги, зардлыг түүнд төлөх Гэрээний үнэлс суутгах эрхтэй.
10.	Төлбөрийн нөхцөл
10.1	Гүйцэтгэгч нь ГТН эсхүл Хавсралт II-г заасан нэхэмжлэх ирүүлэх хуваарийг дагуу дараах шаардлагыг хангасан хүчин төгөлдөр төлбөрийн нэхэмжлэхийг Захиалагчид ирүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> a) Ажил, үйлчилгээний тоо ширхэг, хамрах хугацааг тодорхой тусгасан, b) Төлбөрийн хуваарийн дагуу төлөх төлбөрийн дүнг зөв илэрхийлсэн, c) Гэрээний нөхцөлийн дагуу татвар, шимтгэлийг зөв тооцсон. d) Санхүүгийн тамга тэмдгээр баталгважсан, e) Төлбөрийн нэхэмжлэлд Гэрээний дугаарыг заавал бичнэ, f) Төлбөрийн нэхэмжлэлд тусгагдсан ажил үйлчилгээ, бараа материалыг гэрээнд тусгагдсан нэршлийн дагуу бичиж тэмдэглэх бөгөөд мөн анхан шатны албан ёсны дагалдах баримтуудыг (Ажлын дэлгэрэнгүй тайлан, Зарлагын надаан, бараа хүлээлцсэн акт, НӨАТ-ын надаан, гэрээ дүгнэсэн акт, ажил хүлээлцсэн акт, барьцаа суллах акт бусад нэмэлт баримтууд зэрэг Талуудын тохирсон шаардлагатай нэмэлт баримтууд) хавсаргах, g) Гэрээнд тусгагдсаны дагуу банкны дансны бүрэн мэдээлэл - олон улсын банкны дансны дугаар IBAN, SWIFT, ABA код, банкны хаяг, хүлээн авагчийн хаяг, юанийн төлбөр бол ханзаар давхар дээрх мэдээллийг тусгасан байх.
10.2	ГТН-д өөрөөр заагаагүй бол Захиалагч нь хүчин төгөлдөр, алдаагүй нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор үнийн дүн дээр маргаагүй төлбөрийг нэхэмжлэхэд заасан Гүйцэтгэгчийн банкны дансанд бүрэн шилжүүлнэ.
10.3	Хэрэв Гүйцэтгэгч алдаатай нэхэмжлэх ирүүлсэн бол залруулж, зөв болгосон нэхэмжлэх дахин ирүүлэх хүртэл Захиалагч зохих төлбөрийг шилжүүлэхгүй байх эрхтэй. Төлбөр хийх хугацаа алдаагүй, зөв нэхэмжлэх ирүүлсэн өдрөөс тоологдоно. Ийнхүү шилжүүлэхгүй байх нь уу Гэрээний дагуу төлбөр хоцроосон үүргийн зөрчилд тооцогдохгүй.
10.4	Гүйцэтгэгч нь Захиалагчаас төлбөр төлсөн даруй Монгол Улсын Цахим төлбөрийн баримтын Ebarimt системээр татварын баримтыг Захиалагчийн регистрийн дугаараар шинэж, энэ талаар Захиалагчид мэдэгдэнэ.
10.5	Төлбөрийн нэхэмжлэх, төлбөр төлөлтэй холбоотой Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг ГЕН-ийн 22.2 дахь заалтын дагуу шийдвэрлэнэ.
11.	Ажил хүлээлцэх
11.1	Ажил, үйлчилгээг үзүүлж дуусмагц, эсхүл Гэрээний хугацаа дууссан бөгөөд цааш суугагдахгүй болсон, эсхүл Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан бол энэ Гэрээнд заасан Талуудын төлөөлөгчид уг Гэрээний Хавсралт VI-д заасан загварын дагуу "Ажил хүлээлцэх акт"-ыг үйлдэж, гарын үсгээр баталгаажуулна.
11.2	Ажил, үйлчилгээг үзүүлж дууссан гэж Гүйцэтгэгч үзсэн бол ажил хүлээлцэх тухай мэдэгдлийг Захиалагчид бичгээр хүргүүлнэ.
11.3	ГТН-д өөрөөр заагаагүй бол Захиалагч мэдэгдлийг хүлээн авснаас хойш Ажлын арав (10) хоногийн дотор Ажил, үйлчилгээний үр дүнг шалгаж, шаардлагад нийцсэн бол хүлээн авч "Ажил хүлээлцэх акт"-аар баталгаажуулна.
11.4	Ажил, үйлчилгээний үр дүн нь Доголдолтой буюу Гэрээнд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл Захиалагч тухайн Ажил, үйлчилгээг хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд тухайн Ажил, үйлчилгээг засан сайжруулах эсхүл дахин гүйцэтгэх замаар доголдлыг арилган Захиалагчийн шаардлагад, нийцүүлэхийг Захиалагч нь Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй бөгөөд Гүйцэтгэгч нь Захиалагчаас ямар нэг зардал гэрэхгүйгээр энэхүү шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

11.5	ГЭН-ийн 11.4-д заасан Доголдлыг арилгах нэмэлт хугацааг Захиалагч тогтоох ба уг хугацаа дуусахад Захиалагч нь Ажил, үйлчилгээний үр дүнг шалгаж, шаардлага хангасан бол ГЭН-ийн 11.3-д заасан хүлээлцэх ажиллагааг явуулна.
11.6	Гүйцэтгэгч нь Ажил, үйлчилгээний үр дүнг Захиалагчийн шаардлагыг хангасан байдлаар Гэрээнд заасан хугацаанд, эсхүл Захиалагчаас тогтоосон нэмэлт хугацаанд хүлээлгэж өгөөгүй тохиолдолд Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацаа сунгах эсэхийг Захиалагч өөрийн үзэмжээр, дангаар шийдвэрлэх бөгөөд ийнхүү хугацаа сунгасан нь Гүйцэтгэгчийг хугацаа хэтрүүлсэнтэй холбоотой Гэрээнд заасан алданги төлөх болон хууль тогтоомжид заасан бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
11.7	Захиалагч нь энэ Гэрээнд заасан Ажил, үйлчилгээг галхүү Гүйцэтгэгчээс авах үүрэг хүлээгээгүй бөгөөд ижил төрөл, хэмжээ, чанартай Ажил, үйлчилгээ, бараа болон эд зүйлсийг өөр бусад эх үүсвэртээс хэдийд ч худалдан авах, гүйцэтгүүлэх эрхтэй болно.
12.	Баталгаат хугацаа
12.1	ГТН-д өөрөөр заагаагүй бол Ажил, үйлчилгээний үр дүнд Гүйцэтгэгч нь гурван (3) жилийн чанарын баталгаа өгнө.
12.2	Баталгаат хугацаа нь Ажил хүлээлцэх акт үйлдэж баталгаажуулсан өдрөөс эхлэн тоологдоно.
12.3	Баталгаат хугацаанд Ажил, үйлчилгээний гүйцэтгэлд аливаа Доголдол илэрсэн нөхцөлд Захиалагч нь ямар нэг нэмэлт зардал, төлбөргүйгээр Гүйцэтгэгчээр засуулах эрхтэй байх ба Гүйцэтгэгч нь Захиалагчийн зүгээс хүлээн зөвшөөрөх хэмжээнд түүний тогтоосон хугацаанд, өөрийн зардлаар шаардлагатай өөрчлөлт, засвар, сайжруулалтыг хийх эсхүл Ажил, үйлчилгээг шинээр гүйцэтгэж Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
12.4	Баталгаат хугацаанд Гүйцэтгэгчийн үүргийг баталгаажуулах зорилгоор Захиалагч нь Гэрээний үнийн тодорхой хувийг төлөхгүй хадгалж, баталгаат хугацааны төгсгөлд төлж болно. Энэ нөхцөлд Талууд ГТН-д хадгалах хувийг тохирно.
12.5	Хэрэв Гүйцэтгэгч Баталгаат хугацаанд Доголдлыг арилгах үүргээ Захиалагчаас тогтоосон хугацаанд зохих ёсоор биелүүлэхгүй бол Захиалагч дээрх үлдэгдэл төлбөрөөс Доголдлыг арилгахад шаардлагатай зардлыг гаргах эрхтэй байна.
13.	Даатгал
13.1	Ажил, үйлчилгээний төрөл, шинж чанараас хамааран Гүйцэтгэгчийг ГТН-д заасан даатгалд хамрагдсан байхыг Захиалагч шаардаж болно.
13.2	Даатгалд хамрагдахаар тохирсон бол Гүйцэтгэгчийн хүтээх эрсдэлд хамаарах дор дурдсан тохиолдлын даатгалыг Гүйцэтгэгч нь ажил эхлэх өдрөөс Баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд Гүйцэтгэгч, Захиалагчийн хамтарсан нэрээр, ГТН-д заасан дүнгээр хийлгэнэ: <ul style="list-style-type: none"> a) ажил, байгууламж болон материал алдагдах, эвдэрч гэмтэх; b) тоног төхөөрөмж алдагдах, эвдэрч гэмтэх; c) Гэрээний хэрэгжилттэй холбогдож эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжөөс бусад) алдагдах, эвдэрч гэмтэх; d) хүн бэртэх, эсхүл нас барах.
13.3	ГТН-д өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбарыг уг Гэрээг байгуулснаас хойш Ажлын арав (10) хоногийн дотор Захиалагчид хүргүүлэх ба даатгалын нөхцөлийг Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчилж болохгүй.
13.4	Хэрэв Гүйцэтгэгч шаардлагатай даатгалын гэрээ, гэрчилгээг ирүүлээгүй бол Захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын төлбөр болон аливаа торгуулийг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авах эрхтэй. Энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь шаардлагатай мэдээллийг Захиалагчид гаргаж өгөх үүрэгтэй.

14.	Туслан гүйцэтгэгч авах
14.1	ГТН эсвэл Гүйцэтгэгчийн үнийн санал эсвэл үйлчилгээний саналд заасан болон тохиролцсоноос бусад тохиолдолд Гэрээний үүргийн гүйцэтгэлийн зарим хэсгийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх шаардлагатай бол Гүйцэтгэгч энэ талаар Захиалагчид урьдчилан мэдэгдэж улмаар бичгээр зөвшөөрөл авсан байна. Энэ тохиолдолд Гүйцэтгэгч нь Захиалагчийн хувьд ерөнхий ажлаа гүйцэтгэгч, Туслан гүйцэтгэгчийн хувьд Захиалагч болно.
14.2	Гүйцэтгэгч нь өөрийн Туслан гүйцэтгэгчийн бүхий л ажил, үйлчилгээ болон үүргийн гүйцэтгэлийн хариуцлагыг дангаараа хүлээнэ.
14.3	Захиалагч нь санал болгосон Туслан гүйцэтгэгчийн ур чадвар, ажил мэргэжлийн туршлага зэргийг оцалгах, тэдгээрээс татгалзах онцгой эрхтэй болно.
14.4	Захиалагч нь ГТН-ийн 14.3-д заасан татгалзах онцгой эрхээ ямар нэгэн үндэслэл, шаардлагад нийцүүлэхгүйгээр эдлэх бөгөөд өөрийн шаардлага хангаагүй гэж үзсэн Туслан гүйцэтгэгчийг Ажил, үйлчилгээ гүйцэтгэх газраас явуулахыг шаардах эрхтэй. Ийнхүү Туслан гүйцэтгэгчээс татгалзах эсхүл Төслийн талбайгаас явуулах нь Гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хойшлуулах, хожимдуулах эсхүл гүйцэтгэхгүй байх, түүнчлэн Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангаагүй бол холбогдох хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
15.	Төлөөлөгч өөрчлөгдөх
15.1	Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
15.2	Мэдэгдэлд шинээр томилогдох төлөөлөгчийн хууль ёсны бүтэн нэр, албан тушаал, холбоо барих утга (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
15.3	Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө Талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
16.	Гэрээний хариуцлага ба хариуцлагаас чөлөөлөх
16.1	Хэрэв Гүйцэтгэгч нь Гэрээгээр тохирсон хугацаа эсвэл Гэрээний Хаявралт III-г тодорхойлсон хуваарийн дагуу Ажил, үйлчилгээг гүйцэтгээгүй бол хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс тооцож ГТН-д заасан алдангийг төлнө.
16.2	Гэрээ байгуулсны дараа Гүйцэтгэгчийн зүгээс аливаа шалтгаанаар, өөрийн санаачилгаар Гэрээг цуцлах бол Захиалагчид Гэрээ цуцалсны нэг удаагийн торгуулийг ГТН-д заасан хэмжээгээр төлнө.
16.3	Гүйцэтгэгчийн үзүүлсэн Ажил, үйлчилгээнд илэрсэн Доголдлын улмаас Захиалагчийн үйл ажиллагаанд хохирол, алдагдал учирвал Гүйцэтгэгч хохирлыг барагдуулах үүрэгтэй.
16.4	Гүйцэтгэгч гэрээний үүрээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагчид аливаа алдагдал, хохирол учирвал Гүйцэтгэгч бүрэн хариуцаж, хохирлыг барагдуулна.
16.5	Гүйцэтгэгч, түүний ажилтнууд, төлөөлөгчид, агент, Туслан гүйцэтгэгч гэрээлэгчдийн буруутай, санаатай эсвэл болгоомжгүй үйлдлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, гэмтсэн эсвэл Захиалагчийн буюу бусад этгээдийн эд хөрөнгөд хохирол учирсан бол Гүйцэтгэгч нь энэхүү алдагдал, хохирлыг дангаар бүрэн хариуцах бөгөөд тэргүүн ээлжид Захиалагчийг хохиролгүй болгоно.
16.6	Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний дагуу ажил үүргээ гүйцэтгэх үед аливаа гуравдагч этгээд, өөрийн ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан аливаа хохирол, зардал эсвэл мөнгөн тэтгэмжийн нөхөн төлбөрийг дангаар бүрэн хариуцна.
17.	Гэрээг цуцлах

17.1	Аль нэг Тал энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас нөгөө Тал нь эсхүл Гэрээний аль нэг Тал сайн дурыг үндсэн дээр Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр Гэрээг цуцална.
17.2	Гэрээний нэг Тал Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол нөгөө Тал нь үүргийн зөрчлийг арилгах, хохирлыг барагдуулах, Гэрээний үүргээ биелүүлэхийг шаардсан мэдэгдлийг үүрэг зөрчсөн Талд хүргүүлнэ.
17.3	ГТН-д өөрөөр заагаагүй бол хэрэв үүрэг зөрчсөн Тал мэдэгдлийг хүлээн авснаас хойш Ажлын тав (5) хоногийн дотор зөрчлийг арилгаж, хохирлыг барагдуулаагүй бол мэдэгдэл өгсөн Тал нь Гэрээг цуцлах мэдэгдлийг хүргүүлснээр Гэрээг цуцлах эрхтэй байна.
17.4	<p>Дараах тохиолдолд Захиалагч нь Гүйцэтгэгчид нэмэлт хугацаа тогтоохгүйгээр Гэрээг цуцлах эрхтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> a) Гэрээний үүргээ хоёр (2) ба түүнээс дээш удаа зөрчсөн, b) Гүйцэтгэгч Ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг ГТН-д заасан хугацаагаар хоцроосон, c) Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээнд заасны дагуу ажил гүйцэтгэх чадваргүй буюу ГТН-д заасан мэдэгдэл, баталгааг хангахгүй болох нь тогтоогдсон, дамнуурсан, таган буугдсан. d) Гүйцэтгэгч нь Захиалагчийн нэр хүндэд халдсан, эсхүл Захиалагчийн эсвэл Ажил, үйлчилгээний талаар худал мэдээлэл тараасан, e) Гүйцэтгэгч, түүний төлөөлөгч, ажлын тав нь аливаа хэлбэрээр авлига, залуулаг мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх зэрэг Гэрээний хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үйлдэлд холбогдсон, f) Захиалагч Гэрээний гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт буюу KPI-аар тооцож үнэлэхээр ГТН-д заасан бол Гүйцэтгэгчийн Ажил, үйлчилгээний үнэлгээ үзүүлэлт нь Гэрээний хугацаанд аливаа саяхүүгийн жилд хоёр удаа 80%-аас доош үнэлэгдсэн тохиолдолд, g) Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээнд заасан Ажил, үйлчилгээг үзүүлэхдээ Захиалагчийн удирдлагын баг болон ажилтанд холбогдох албан тушаалтад мэдэгдэхгүйгээр хувьд нь хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгсөн. h) Гүйцэтгэгч эсвэл эрх бүхий албан тушаалтан нь Захиалагчийн ажилтантай сонирхлын зөрчил бүхий буюу нэгдмэл сонирхолтой болох нь тогтоогдсон.
17.5	Давагдаагүй хүчин зүйлийн үйлчилэл гурван (3) сар болон түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн бол Талуудын аль нь ч Гэрээг цуцлах санал гаргах эрхтэй байна.
17.6	Захиалагч нь ямар нэг шалтгаан, үндэслэл заалгүйгээр энэ Гэрээг цуцлах талаар нөгөө талдаа ГТН-д заасан хугацаанаас бараагүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлснээр энэхүү Гэрээг дуусгавар болгож болно.
18.	Гэрээ цуцлагдсаны үр дагавар
18.1	Гүйцэтгэгчийн зөрчлийн улмаас Гэрээг цуцалсан бол Гэрээ цуцлагдах хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн Доголдолгүй ажлын үр дүнд ногдох төлбөрөөс өөр төлбөр, хохирол, зардал төлөх үүрэг хүлээхгүй.
18.2	Захиалагч хүлээн авахаас татгалзсанаас бусад тохиолдолд Гэрээ цуцлах эсвэл хугацаа дуусгавар болох өдрийг хүртэл Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн Ажил, үйлчилгээний үр дүн (зохиолчийн эрх хамаарна) Захиалагчийн өмчлөл, эзэмшилд шилжинэ.
18.3	Гүйцэтгэгч нь Ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бараа материал худалдан авсан бөгөөд тухайн худалдан авалтыг Гэрээ цуцлагдах өдрөөс өмнө хийснийг баримтаар нотолсныг Захиалагч зөвшөөрч, хүлээн авахаар шийдвэрлэсэн бол тухайн бараа, материалын төлбөрийг толго.
18.4	Аливаа шалтгаанаар Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан бол, эсвэл Гэрээний хугацаа дуусгавар болсны дараа Захиалагчаас Ажил, үйлчилгээний хүрээнд Гүйцэтгэгчид шилжүүлсэн тоног, төхөөрөмж, баримт сэлт, хэрэгсэлийг Гүйцэтгэгч нь нэг даруй Захиалагчид өөрийн зардлаар буцаан хүргүүлнэ.

19.	Аюулгүй ажиллагаа, хүрээлэн буй орчин, олон нийттэй харилцах харилцаа
19.1	Бүх Ажил, үйлчилгээг хийж гүйцэтгэхэд холбогдох салбарын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмуудыг чанд сахин биелүүлнэ.
19.2	<p>а) Гүйцэтгэгч нь Гэрээний дагуу үүргээ гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА), хүрээлэн буй орчин болон олон нийттэй харилцах харилцааны талаар Захиалагчийн дотоод баримт бичиг, журам болон бодлого, түүнчлэн ажил эхлэхээс өмнө, гүйцэтгэх явцад болон ажлыг дуусгах хүртэл хугацаанд ХАБЭА-тай холбоотой заавар, чиглэл, мөн ЕСБХБ-ы Гүйцэтгэлийн Шаардлагууд 1-8 болон 10-г сахин биелүүлнэ.</p> <p>б) Ажил, үйлчилгээ явуулж буй нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хүндэтгэлтэй харилцах ба Захиалагчийн өмнөөс мэдээлэл өгөх, Захиалагчийн үйл ажиллагаа, ажил хэргийн нэр хүндэд соргоор нөлөөлөх аливаа үйлдэл гаргахгүй байна.</p> <p>в) Гүйцэтгэгч нь ХАБЭА, хүрээлэн буй орчин эсвэл олон нийттэй харилцах харилцаатай холбоотой дүрэм журам, стандартыг сахин биелүүлэхгүй буюу үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахгүй байна гэж Захиалагч үзвэл Гэрээ болон гүйцэтгэж байгаа Ажил, үйлчилгээг нэн даруй зогсоох буюу Гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.</p>
19.3	ГЕИ-ийн 19.1 эсвэл 19.2-г дурдсан нөхцөл байдлаас шалтгаалан Гэрээ болон түүний үүргийн гүйцэтгэл түр зогссон хугацаанд ямар ч төлбөр хийгдэхгүй бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны шаардлагуудыг хангасан тохиолдолд төлбөр тооцоо хийгдэнэ.
20.	Нууцлал
20.1	Талууд нь нууцлал хадгалах үүрэгтэй бөгөөд аль нэг Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр нөгөө Талаас шууд ба шууд бусаар гаргаж өгсөн Гэрээтэй холбоотой аливаа баримт бичиг, өгөгдөл болон бусад мэдээллийг гуравдагч этгээдэд Гэрээ байгуулагдахаас өмнө, Гэрээ хэрэгжих явцад болон Гэрээ цуцлагдах буюу дуусгавар болсноос хойших аль ч хугацаанд залруулж болохгүй. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай байхаас бусад тохиолдолд Талууд Гэрээний агуулгыг нууцална. Энэ заалт нь Гэрээ цуцлагдсан буюу дуусгавар болсон эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ.
20.2	Дээрхээс гадна шаардлагатай гэж үзвэл ГТН-д Нууцлал тооцогдох мэдээ, мэдээллийн жагсаалтыг заана. Гэрээний энэхүү заалтыг баримтлан мөрдүүлэхэд гарсан аливаа зардлыг Гүйцэтгэгч хариуцах бөгөөд энэ Гэрээний дагуу эсхүл Ажил Захиалах маягтын дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган тооцно. Гэрээний дагуу хийгдэх мөнгөн дүн суутган тооцоход хүрэлцэхгүй нөхцөлд Гүйцэтгэгч ийнхүү зөрүү төлбөрийг Захиалагчид нэн даруй төлж барагдуулна.
20.3	Талууд олон нийтийн хэвтэл мэдээллийн хэрэгсэл, радио, телевиз, сонин сэтгүүд болон цахим орчныг ашиглан Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа мэдэгдэл, мэдээ, ярилцлага, нэвтрүүлэг цацахыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд уг үйлдлийг Талуудын бизнесийн нэр хүндэд халдсан гэж үзэх бөгөөд буруутай талаас Гэрээний нийт үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг үл маргах журмаар шаардан төлүүлнэ.
	Энэхүү заалт нь Захиалагч өөрсдийн Хувьцаа эзэмшигч, Хөрөнгө оруулагч, Зээлдүүлэгч, Түвш байгууллагуудад төслийн явц, гүйцэтгэлийг танилцуулах зорилгоор хийгдэх үйл ажиллагаанд хамаарахгүй.
21.	Давагдашгүй хүчин зүйлс
21.1	Давагдашгүй хүчин зүйлсээс үүдэн Гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаанаасаа хожимдох эсхүл гүйцэтгэгчгүй бол аль нэг Тал хариуцлага хүлээхгүй.
21.2	Давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлдэх боломжгүй болсон тал нь нөгөө талдаа ажлын 5 (тав) өдрийн дотор тухайн нөхцөл байдал үүссэн, үргэлжилсэн, дууссан талаар бичгээр мэдэгдэнэ.

21.3	Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн, үргэлжилсэн, дууссан болохыг тухайн талын улсын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхим эсхүл бусад эрх бүхий байгууллагаас гаргасан гэрчилгээгээр нотолно. Тухайн тал гэрчилгээг боломжит богино хугацаанд авч нөгөө талд өгнө. Захиалагч нь давагдашгүй хүчин зүйлийн үйл явдлын нотлох баримтыг хүлээн авах эсвэл татгалзах эрхтэй.
21.4	Давагдашгүй хүчин зүйл үүсэн үргэлжилж байгаа, эсхүл дуусгавар болсон ч үр дагаврынх нь улмаас аливаа төлбөрийн төлөлт, ажлын гүйцэтгэл хойшлох тохиолдолд ийнхүү хойшилсонтой холбоотой Талуудад ямар нэг хариуцлага хүлээлгэхгүй, үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэмжээ болох алданги, хүү, торгууль ногдуулахгүй, Талууд эсхүл хэн нэг гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй.
22.	Үйлчлэх хууль ба маргаан шийдвэрлэх
22.1	ГТН-д өөрөөр заагаагүй бол энэ Гэрээг Монгол Улсын хуулийн дагуу удирдан зохицуулж, тайлбарлана.
22.2	Энэ Гэрээгэй холбогдуулан эсхүл түүний хэрэгжилтийн явцад гарсан аливаа маргааныг Талууд ийнхүү нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш гуч (30) хоногийн дотор Талуудын удирдлагын түвшинд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
22.3	Маргааныг ГЕН-ийн 22.2-т заасан хугацаанд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэж чалаагүй тохиолдолд ГТН-д өөрөөр тохироогүй бол Талууд Монгол Улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.
22.4	Захиалагчийг Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хасалт хийх эсхүл Гэрээг цуцлахад хүргэсэн Гэрээний зүйл заалт, нөхцөлийг зөрчсөн аливаа зөрчил нь Гүйцэтгэгчийн хамтран оролцсон Захиалагчийн үйл ажиллагаанд чирэгдэл учруулах, тасалдуулах шалтгаан болохгүй.
23.	Эрх шилжүүлэх
23.1	Захиалагчаас бичгээр, урьдчилан зөвшөөрөл аваагүй тохиолдолд энэ Гэрээгээр хүлээсэн үүрэг болон шаардах эрх, нэхэмжлэл авах мөнгөн төлбөр зэргийг өөр бусад этгээдэд шилжүүлэх, барьцаалах, баталгаа гаргах, шаардах эрх болон алагаа шилжүүлэхийг хориглоно. Гэрээний энэ заалт зөрчигдсөн нөхцөлд Захиалагч гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй.
24.	Гэрээний нэмэлт, өөрчлөлт
24.1	Аль ч тал Гэрээг дагаараа өөрчлөх, түүнд нэмэлт оруулахгүй. Аливаа нэмэлт, өөрчлөлтийг Талууд галтхүү бичгээр үйлдэж, эрх бүхий этгээд харилцан гарын үсэг зурж баталгаажуулах замаар хийгдэх бөгөөд эдгээр нь гэрээний салшгүй хэсэг байна.
25.	Хугацаа сунгах
25.1	Энэ Гэрээ нь Ажил, үйлчилгээгэй холбоотой Талуудын хоорондын эцсийн хэлэлцээр бөгөөд Талуудын хооронд энд дурдсан асуудлаар өмнө байгуулсан бүхий л аман болон бичгэн Гэрээ, яриа хэлэлцэлг ордоно.
26.	Оюуны өмч
26.1	Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан аливаа мэдээлэл, баримт материал, нүү-хау, оюуны өмч, барааны тэмдэгт хамааралтай мэдээлэл, баримтууд нь тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ. Ажил, үйлчилгээний үр дүнд бий болсон аливаа мэдээлэл, эд зүйл, зураг, тайлан, дүгнэлт, оюуны өмч, барааны тэмдэгт хамааралтай мэдээлэл, баримтууд нь Захиалагчийн өмч болно.
26.2	Гүйцэтгэгч нь Ажил, үйлчилгээний зохиогчийн эрхтэй холбоотой гарч болох гуравдагч этгээдийн аливаа маргаанаас Захиалагчийг ангид байлгах ба Ажил, үйлчилгээг гүйцэтгэхдээ зохиогчийн эрхийн маргаангүйгээр шийдлийг олж Ажил, үйлчилгээг гүйцэтгэнэ.
26.3	Ажил, үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай Тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
27.	Бусад зүйл

EM - Service (Work) Agreement (Mon)

27.1	Энэ Гэрээнд дурдагдсан аливаа мэдэгдэл нь бичгээр байх бөгөөд түүнийг биечлэн хүргэх, эсвэл мэдэгдлийг Гэрээ баталгаажуулах маягтад бичигдсэн Талуудын албан ёсны хаягаар шуудангаар, эсвэл цахим шуудангийн хаяг руу илгээж, Аливаа мэдэгдлийг биечлэн хүргэсэн бол хүргэсэн хугацаагаар, шуудангаар бол шуудангийн хүргэлтийн тэмдэглэл хийгдсэн өдрөөр, цахим шуудан явуулсан бол явуулсан цагаар хүлээн авсанд тооцогдоно.
27.2	Энэ Гэрээний аль нэг заалт ямар нэг шалтгаанаар хүчингүй, хууль бус буюу хэрэгжүүлэх боломжгүй болох тохиолдолд уг заалтын хүчин төгөлдөр бус, хууль бус эсвэл хэрэгжүүлэх боломжгүй гэж тооцогдсон тэр хэсгийг Гэрээгээс хасах бөгөөд Гэрээний бусад заалтууд хүчин төгөлдөр, биелэгдэх хүчинтэй хэвээр үлдэнэ.
27.3	Гэрээний зүйл заалтын гарчиг, индекс болон бусад тэмдэглэл нь зөвхөн мэдээллийн шинжтэй ба энэхүү Гэрээний нэг хэсэг болохгүй бөгөөд энэхүү Гэрээний заалтыг тайлбарлах, түүнд нөлөөлөх, түүнийг хязгаарлахгүй болно.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ (ГТН)		
<p>Гэрээний тусгай нөхцөл нь Гэрээ баталгаажуулах маягт, ГЕН-ийн холбогдох заалтуудад нэмэлт болон өөрчлөлт хийх, тэдгээрийг нарийвчлан дэлгэрүүлэх зорилготой бөгөөд ГТН-ийг Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох ГЕН болон бусад баримт бичгүүдийн хамтаар хэрэглэнэ. ГЕН болон ГТН хооронд зөрүүтэй, харилцан зөрчилдсөн заалтууд байх нөхцөлд ГТН болон түүний заалтууд давуу эрхтэй байна.</p>		
ГТН	ГЕН	
1	3.	Дараах нөхцөлүүд биелснээр гэрээ хүчин төгөлдөр болно. Үүнд: 1. Талууд гэрээнд гарын үсэг зуран, тамга, тэмдэг дарагдсанаар хүчин төгөлдөр болно.
2	3.1	Уг Гэрээг Талуудын гэрээний үүрэг бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаагаар байгуулав.
3	4.2	Ажил, үйлчилгээ нь дараах тусгайлсан шаардлагад нийцсэн байна. Үүнд: 1. Уул уурхай болон дэд бүтцийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий хуулийн этгээд байх 2. Багийн бүрэлдэхүүн холбогдох эрх зүйн шаардлага хангасан эрх бүхий аудитор болон байгаль орчны хяналтын чиглэлээр төрийн захиргааны байгууллагад ажиллаж байсан гишүүдээс бүрдсэн байх 3. Багт нэг (1)-ээс доошгүй доктор, төрийн байгууллагад сүүлийн арван (10) жилийн хугацаанд тав (5)-аас дээш жил ажилласан албан хаагч байх 4. Сүүлийн гурван (3) жилийн хугацаанд дөрөв (4)-өөс доошгүй БОННУ гүйцэтгэсэн байх
4	4.3	Ажил, үйлчилгээний ажлын үр дүн, бүтээл нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд: 1. Гэрээний Хавсралт I “Ажил, үйлчилгээний тодорхойлолт, хүрээ”-нд дэлгэрэнгүй тусгагдсан. 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/168 тушаалыг удирдлага болгох ба тайлан, зөвлөмжид Баянхонгор аймгийн Байгаль орчны газар, Шинэжинет сумын засаг даргын саналыг тусгасан байна 3. Баянхөндий төслийн ТЭЗҮ-д үндэслэн гүйцэтгэнэ.
5	7.1	Гүйцэтгэгч нь дараах тайланг дурдсан хугацаанд гаргаж Захиалагчид хүргүүлнэ. Үүнд: - Ажлын явцын тайланг 7 хоног тутамд тайлагнана. - Хавсралт III-д заасан Ажлын төлөвлөгөө, хуваарийн үе шат бүрээр - Захиалагчаас шаардсан тухай бүр
6	7.3	Тайлан нь дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд: 1. Тайлан нь Захиалагчийн шаардлагад нийцсэн байдлаар болон шаардлагатай тохиолдолд Захиалагч тайлангийн загварыг I гүйцэтгэгч талд өгөх ба тайлангийн загварыг бүрэн бөглөн, ашиглах үүргийг Гүйцэтгэгч хүлээнэ.

7	9.1	Энэхүү Гэрээний дагуу гүйцэтгэх бүхий л Ажил, үйлчилгээний нийт хөлс нь [REDACTED] төгрөг байх бөгөөд уг үнэд НӨАТ, ажилчдын байр хоол, НБХХ-н зардал, туслах материал, тээврийн зардал, гүдшний зардал тус тус багтсан байна.
8	10.1	Талууд Гэрээг бүрэн баталгаажуулснаас хойш Захиалагч нь Ажил, үйлчилгээний зардлын [REDACTED] болох [REDACTED] төгрөгийг Гүйцэтгэгчийн алдаагүй нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Ажил, үйлчилгээний нийт зардлын [REDACTED] болох [REDACTED] төгрөгийг Захиалагчийн баталгаажуулсан Ажил хүлээлцэх акт болон Гүйцэтгэгчийн алдаагүй нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш хуангийн 14 хоногт Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ. Ажил, үйлчилгээний нийт зардлын [REDACTED] болох [REDACTED] төгрөгийг Захиалагчийн тайланг холбогдох төрийн байгууллага, Байгаль орчны газрын саналыг тусгаад эцсийн тайлан хүлээлгэн өгч, Гүйцэтгэгчийн алдаагүй нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш хуангийн 60 хоногт Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.
9	11.3	Гүйцэтгэгч нь ГТН 8 (10.1)-г заасан урьдчилгаа төлбөрийг хүлээн авснаас хойш 7 хоногт багтаан Захиалагчийн шавардлага хангасан Хавсралт 1 Ажлын даалгаварт заасан ажил үйлчилгээг Төслийн талбайд хүргэнэ. Гүйцэтгэгч нь Ажил, үйлчилгээг Хавсралт III-г заасан Ажлын төлөвлөгөө, хуваарийн дагуу хийж гүйцэтгэнэ. Захиалагч нь Ажил, үйлчилгээний явцтай хэвийн ч танилцах эрхтэй ба Захиалагчийн хүсэлтийн дагуу Гүйцэтгэгч нь Ажил үйлчилгээний үс шаттай хэдийд ч танилцах эрхтэй ба Гүйцэтгэгч нь ажлын хэцүүн татаар тухай бүр үнэн зөв мэдээллийг өгөх үүрэгтэй.
10	16.1	Алданги нь: 1. Гүйцэтгэгч гэрээний үүргээ гэрээнд заасан төлөвлөгөөт хугацаанд биелүүлдэггүй тохиолдолд хугацаа хожимдуулсан хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувьтай тэнцэх алданги төлнө. 2. Захиалагч нь Гэрээний дагуу төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол үнийн дүн дээр маргаагүй гүйцэтгээгээгүй төлбөрийн 0.05 хувьтай тэнцэх алданги төлнө.
11	16.2	Гүйцэтгэгчийн гэрээ цуцалсны торгууль Гэрээний үнийн дүнгийн 20 хувь байна.
12	17.4.b)	Гүйцэтгэгч Ажил, үйлчилгээний гүйцэтгэлийг аливаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эвэл Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр Ажил, үйлчилгээний эцсийн үр дүнг хүлээлгэн өгөх хугацааг 10 хоногоор хоцроосон бол Захиалагчийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй ба өөрт учирсан хохиролд Гэрээний нийт үнийн дүнгийн 20%-тай тэнцэх үнийн дүнг үлдэгдэл төлбөрөөс суутган явах эрхтэй.
13	17.6	Захиалагч нь ямар нэг шалтгаан, үндэслэл заалгүйгээр энэ Гэрээг дуусгавар болгох талаар нөгөө талдаа 5-с багагүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлснээр энэхүү Гэрээг цуцалж болно.
14	19.2	Гүйцэтгэгч Ажил, үйлчилгээг гүйцэтгэхдээ баримтлах Захиалагчийн холбогдох бүхий л аюулгүйн ажиллагааны дүрэм, журам, Төслийн талбайд мөрдөгдөх аливаа бусад дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана. Энэ үүргээ биелүүлдэггүйгээс Захиалагч, Гүйцэтгэгч, гуравлагч этгээдэд учирсан аливаа хохирол, үр дагавар, хариуцлагыг дангаар хариуцна.

АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ, ХҮРЭЭ**БАТЛАВ:****ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц. БААСАНДОРЖ**

2025 оны .. сарын .. өдөр

**"ЭРДЭНЭ МОНГОЛ" ХХК-НИЙН "БАЙГАЛЬ ОРЧИНЫГ ХАМГААЛАХ АРГА
ХЭМЖЭЭНД" ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2025 оны 04 дүтээр сарын 11

Урмын гол

1. ЗОРИЛГО	
Ашигт малтмал олборлох, дайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох, тэдгээртэй тэмцэхийг, урьдчилан сэргийлэх, бууруулах ба нөхөн сэргээх арга хэмжээгүүдийг оновчтой, үр дүнтэй төлөвлөх.	
2. ХАМРАХ ХҮРЭЭ	
"Эрдэнэ Монгол" ХХК-ийн Баянхонгор салбар	Баянхонгор аймгийн Шинэжинет сумын жууцгал дэвсгэрт байрлах МV-021444 тоот Хөндий, МV-021547 тоот Алтан нар, XV-016057 тоот Улаан тусгай нивхээрнэ.
3. ТАВИГДАХ ШААРДЛАГА	
Гүйцэтгэгч гэд	<ul style="list-style-type: none"> Уул зурхай болон дая бүтцийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэмлэх гүйцэтгэх тусгай нөхцөрөөртэй, эрх бүхий хуулийн этгээд байх. Байгаль бүрэлдэхүүн хэлбэрээр эрх түйм шаардлага хийгэсэн эрх бүхий зурхай болон байгаль орчны хяналтын чиглэлээр төрийн захиргааны байгууллагад ажлаар байсан гүйцэтгэгч бүрдсэн байх. Бөгт нэгтгэж дохиогүй доктор, төрийн захиргаанд байгууллагад сүүлийн 10 жилийн хугацаанд тасалж дээш жил ажилласан албан хаагч байх. Сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн захиргаанд БОХНУ гүйцэтгэсэн байх.
Ажил гүйцэтгэх аргачлал	<ul style="list-style-type: none"> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэмлэхийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 58 дугаар тогтоол, Байгаль орчин, явдал жууцлалтын сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/618 тушаалыг удирдлага болгох ба танил, төвлөмжид ажлаар Байгаль орчны газар, Шинэжинет сумын Засаг даргын саналыг тусгана. Баянхонгор төслийн ТЭЗҮ-д үндэслэн гүйцэтгэнэ.
Гол ба бэлэншгүй сөрөг нөлөөллийг гэдэрхөөлөх	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрд үзүүлэх гол ба бэлэншгүй сөрөг нөлөөллийг нарийвчлан тодорхойлсон байх.

<p>Эрдэмтчийн үнэлгээ</p>	<ul style="list-style-type: none"> • Хэргийн судалгаа, шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр явуулж, нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг гүйцэтгэхээр тодорхойлсон байх. • Нөлөөллийн орон зайн тархалтыг загварчилж тодорхойлсон байх. • Тодорхойлсон нөлөөллүүдийг нэгдсэн шалгуур, арга зүйгээр үнэлсэн байх. • Төслийн хяналт гарах бодомжгүй нөлөөллүүдийг урьдчилан тодорхойлж, гэдгээрхэй эрсдэл болон нөлөөллийн хэмжээ, үр дагаврыг үнэлэх. • Нийгмийн болон эдийн засгийн салбарт үзүүлэх нөлөөллийг нарийвчлан тодорхойлсон байх. • Байгаль орчныг хамгаалж, дүйцүүлэн хамгаалах талаар хэрэгжүүлсэн ажлуудын дугаарыг илрүүлэх. • Тээвэр, тээвэр бодисын агуулах, • Боловсруулах үйлдвэр, химийн бодисын агуулах, лаборатори, аюултай болон хортой химийн бодис, аюултай хорт хавдгаж, • Ус шингэгчүүдэд болон цэвэрлэх байгууламж, • Бусад эрсдэл үүсгэгч хүчин зүйлүүдийг тодорхойлох
<p>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, бууруулах, аригваад чиглэгдсэн, хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээ байх. • Зөвлөмжэнд тусгагдсан арга хэмжээ бүрийн ам холбогдол, хэрэгжүүлэх талаар дэлгэрэнгүй тусгасан байх. • Сөрөг нөлөөллийг бууруулах үндэсний ба олон улсын хэмжээнд ашиглаж агаар сайн туршигуудыг тусгасан байх.
<p>Нөхөн сэргээлтийн зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Техникийн болон биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэхэд анхаарах асуудлуудыг тусгасан байх. • Орчны тохижилт, ногоон байгууламжийг байгуулахад анхаарах асуудлууд, тархал, аригваа аргуудыг тусгасан байх. • Шимт хөрсний үржил шимт чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, аригваа хамгийн үр дүнгүй аргуудыг сакал болгох. • Хамгийн нөхөн сэргээлтийн төслийг тусгасан байх
<p>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Гэрбум мол хөтөлбөрийн ТЭЗҮ-гэй уялдуулан байгуулж байгаа тархалт ойг дүйцүүлэн хамгаалсан газар нутагт тооцуулах арга зүйн орчмыг тусгах • Дүйцүүлэн хамгааллын хүртэл хамгаалах шаардлагатай газар нутаг эсвэл биотопийн төрөл зүйлийн гоо хэмжээг тодорхой болгох.
<p>Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний зөвлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг шовхтгой хэрэгжүүлэх нөхөн олговор олгох аргуудыг орчинг тусгасан байх • Нөлөөллийн бүсийг тооцох үндэслэлийг тодорхойлох.
<p>Гүүр, соёлын өвийг хамгаалах арга</p>	<ul style="list-style-type: none"> • Археологи, нэлентлогийн олдвор олцсон үед хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байх

<p>Орчны хандалт, шинжилгээ хийх зөвлөмж</p> <p>Хөгжлийн замыг бууруулах, менежментийг сайжруулах арга хэмжээнээ төлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлж буй нөлөөллүүдийг хянаж чихлэх шинжилгээгүүд, гэдгэрийг гүйцэтгэх хугацаа, давтамж, харьцуулах олон улсын болон үндэсний стандартыг тусгасан байх • Шинжилгээний үр дүнд үндэслэн боловсруулах зөвлөмжүүдийн ажлаарыг боловсруулах • Үйл ажиллагаанд үүсэх хөгжлийн хэмжээг төрөл тус бүрээр бодитой тооцожсон байх. • Хөгжлийн замыг аж үүсвэр дээр нь бууруулах арга хэмжээнүүдийг оновчтой төлөвлөсөн байх. • Үүссэн хөгжлийг хууль эрх зүйн хүрээнд уелгах аргачлалыг тодорхой тусгасан байх • Хөдөлмөр үндэслэлийг ашиглан хөрс боловсруулах туршилтаарыг тусгаж, оновчтой хувиарыг сайжир болгох
<p>Удирдлага, хөдөлмөр байгуулалтын төлөмж</p>	<ul style="list-style-type: none"> • Байгаль орчны дэргэний оновчтой бүтцийг санал болгох • Компанийн хэмжээнд мөрдөх журмуудын дагуу ажил хэрэгтэй хууль, эрх зүйн актуудад үндэслэн боловсруулах. • Цуглуулсан өмчлэлийн үр дүнтэй боловсруулах програмыг хянаж ажиллагааг санал болгох. • Тухайн ажилтны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад анхаарах, төлөвлөгөөг хэрхэн оновчтой төлөвлөх талаарх зөвлөмж өгөх.
<p>Тайлан</p> <p>Хугацаа</p>	<ul style="list-style-type: none"> • Ажлын үр дүнд гэрээ байгууллагаас хойш 60 хоногт багтаан захирагчид тайлбар өгөх, санал авах. • Ажлын тайлан, зөвлөмжийг Баянхонгор аймгийн Идгэвч, орчны газарт танилцуулж, батлуулах • Баянхонгор аймгийн БОГ-ын Байгууламжаас тайлан (1), зөвлөмж (2)-ийг хэргээр болон (pdf) өргөтгөлтэй файлаар (CD/DVD), Мөхтөл хэлээр хүтэлтэн өгөх. • Тайлангийн төлөх үр дүнд, зөвлөмжийг тусгасан хуримтлалд үндсэн тайлангаас гадна тусгай нь бэлтгэж хүтэлтэн өгөх. • 1 дүгээр хэргээр цахуу дүнгээ ажлын хэргийн олгоно. • 1 дүгээр хэргээр хойш хугацаанд 90 хоног

ХЯНАСАН:

ТӨСЛИЙН УДИРДАГА ХАРИУЦСАН ЗАХИР, ХАБЗА, БО-НЫ МЕНЕЖЕР:  БАТНО, Д. Б. ҮҮВИЙН ГҮЯА

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ АЖИЛТАН  БАТНО, Д. Б.

Хавсралт II

ГҮЙЦЭТГЭГЧЭЭС ИРҮҮЛСЭН ҮНИЙН САНАЛ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Request for Quotation for Supplier

OU ERRO 210	524	1	0	10-Apr-25	Илтгэл/Бат/Хатан
-------------	-----	---	---	-----------	------------------

Supplier Name: Гэрээтэй чэрэм ХХК

Supplier Code :

Item Number	Item Description	Qty	UOM	Alt Desc	Price	Гэрээтэй чэрэм ХХК		
						Unit Price	Total Price	Currency
771024000000	С.А.Бюджеттенгэл үйлдвэрлэл (Service) (Байгаль орчныг хамгаалах зэрэг хэмжээний зэрэг үйлчилгээ)	1	MNI	1	493	50,000,000.00	50,000,000.00	MNT
Total Amount:							50,000,000.00	
VAT							3,000,000.00	
Total Amount (include VAT)							53,000,000.00	MNT

Үнийн санал хүргүүлэгч:



	Төлбөрийн хугацаа	Хувь	Үнийн дүг, төг
1	Талууд Гэрээг бүрэн баталгаажуулснаас хойш Ажил, үйлчилгээний зардлын 50% болох 27,500,000 (хорин долоон сая таван зуун мянган) төгрөгийг нэхэмжилнэ.	50%	27,500,000.0
2	Тайланг хүлээлгэн өгсний дараа ажил, үйлчилгээний нийт зардлын 30% болох 16,500,000 (арван тургаан сая таван зуун мянга) төгрөгийг нэхэмжилнэ.	30%	16,500,000.0
3	Захиалагчийн тайланд холбогдох төрийн байгууллага, Байгаль орчны газрын саналыг тусгаад эцсийн тайлан хүлээлгэн өгснөөс хойш 45 хоногийн дараа Ажил, үйлчилгээний нийт зардлын 20% болох 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгийг нэхэмжилнэ.	20%	11,000,000.0
Захиалагч нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн алдаагүй нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш Гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд холбогдох төлбөрийг шилжүүлнэ.			


АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

Д/н	Үндсэн үе шат	Гүйцэтгэх ажлуул	Хугацаа / хоног /	Хүрэх үр дүн
1	Суурь судалгаа	Холбогдох хууль, стандартын дүн шинжилгээ хийх - Хууль, журам, стандартын дүн шинжилгээ хийх; - Өмнөх байгаль орчны мэдээ тайлан, орон нутгийн албан тоол, тэрээний мэдээлэлтэй танилцах; - Баримт бичгийн үнэлгээ хийх;	14	Байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн Байгаль орчны салбарын хуулийн болон МУ-мөрдлөгөж буй стандартад нийцсэн байдал дүн шинжилгээ хийнэ. Байгаль орчны таларх өмнөх баримт бичгийн мэдээлэл нэгтгэгдэж, үнэлгээ хийгдсэн байна.
2	Тайлбай тэрх үзэл, хээрийн судалгаа	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн байдлыг газар дээр нь үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах - Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрт үзлэг хийх; - Хөг хаягдал, хийгийн бодис, ус, хөрс, агаарын чанарын мэдээлэл цуглуулах;	5	Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн одоогийн төлөн байдлыг талаарх бодит мэдээлэл цугларч, анхан шатны үнэлгээ хийгдсэн байна.
3	Мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ	Мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ - Эрдэл, сөрөг нөлөөллийг үзлэг; - Нөлөөллийн орон зайн тархалтыг загварчлах;	20	Эрдэл, сөрөг нөлөөллийг тооцсон, орон зайн нөлөөллийг загварчлал хийсэн дүн шинжилгээний үр дүн гарсан байна.
4	Байгаль орчныг хамгаалах, дийцүүлэн хамгаалах зөвлөмж боловсруулах сургалт зохион байгуулах	Компанийн ажиллуудад сургалт зохион байгуулах, сайжруулалтын зөвлөмж өгөх. - Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг төлөвшөлөх; - Техник, биологийн цөхөн сүртээлтийн санал боловсруулах; - Байгаль орчны сургалт зохион байгуулах; - Зохион байгуулалтын бүтэл, тогтон журмыг нийцсэн зөвлөмж өгөх;	15	Сургалтанд оролцсон ажиллуудын мэдлэг нэмэгдсэн. Байгаль орчныг хамгаалах сайжруулалтын арга хэмжээний санал боловсруулагдсан байна.
5	Хөг хаягдлын менежмент ба хяналт шинжилгээний зөвлөмж	- Хөг хаягдлын ангилал, бууруулах, дахин ашиглах шийдэл гаргах; - Шинжилгээ хийх давтамж, аргын санал боловсруулах;	7	Хөг хаягдлын ангилал, менежментийн шийдлүүд, шинжилгээний хяналтын төлөвлөгөөний санал болгөгдсөн байна.
6	Тайлан боловсруулах ба орон нутгийн байгууллагад танилцуулах	Ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох талуудад танилцуулах - Эцсийн тайлан боловсруулах; - Баянхонгор аймгийн байгаль орчны газар, Шинэжинст сумын ЭДТГ-т танилцуулж санал авах; - Санал, зөвлөмжийг нэгтгэн тайланд тусгах;	15	Эцсийн тайлан боловсруулагдаж, орон нутгийн холбогдох байгууллагад танилцуулсан бөгөөд санал зөвлөмжүүд нэгтгэгдсэн байна.
7	Тайлангийн эцсийн хувилбар, хүсээлгэн өгөх	- Байгаль орчны газрын баялагжуулсан тайланг хэвлэмэл, дахин хэлбэрээр өгөх;	14	Баталгаажсан тайлан хэвлэмэл болон дахин хэлбэрээр боловсруулагдаж, тайлангийн

EM - Service (Work) Agreement (Mon)

		<ul style="list-style-type: none"> - Тайлангийн товч хураангуйг хавсаргаж хүргүүлэх; - Ажлын даалгаварт дурдсан тайланг тусгай зөвшөөрөл тус бүрээр гарган Захиалагчид хүлээлгэн өгөх 		<p>товч хураангуй хавсаргасан байдлаар хүлээлгэн өгсөн байна.</p>
Нийт хугацаа			90	

ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖ АХУЙН НЭГЖИЙН БОЛОН НӨАТ ТӨЛӨГЧИЙН
ГЭРЧИЛГЭЭ, ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАР



МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

9011 33141
Хүний нөөцийн үйлчилгээний газар

2429 А4
Мэргэжлийн гэрчилгээ

Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга /Хүний нөөцийн үйлчилгээний газар/

Гурвал
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга

Шийдвэр
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга

1
дугаар

2004.04.28
эх сар өдөр

Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга /Хүний нөөцийн үйлчилгээний газар/

1
дугаар

Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга /Хүний нөөцийн үйлчилгээний газар/


Хүн Угт нь 10000 жилийн өмнөхөөр 28, 1987.05.28, улсд, 8040
Хүний нөөцийн үйлчилгээний газрын дарга

ТАТВАРЫН ЭМГЭГ

УЛСЫН
БҮРТГЭЛИЙН
АЖАА

УЛСЫН
БҮРТГЭЛИЙН
АЖАА

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
сайдын 2024 оны 11 дугаар сарын 04 өдрийн
тоот тушаалын 21 дугаар хэсэгт




МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2024 оны 11 дугаар сарын 22 ны өдөр Улаанбаатар хот

Дугаар : _____

УЛААНБААТАР (сум, дүүрг)-ийн	(аймаг, нийслэл)-ийн 2028189	ХАН-УУЛ тоот регистрийн дугаартай
ГЭРЭЛТЭХ НАРАН ХХК (Хуулийн этгээдийн нэр)		

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 20 24 оны 11 сарын 04 өдрийн А/765 тоот тушаалыг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг **ГУРВАН** жилийн хугацаагаар олгов.



С.ОДОНТУЯА

2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр



ZS 1 003 00389 f1 084a40c1-a1d3-5c 62680e0e0f

Сандық

Эм-сөз, Шығыс Қазақстан университетінің қорғаныс
және құқық қорғау қызметіне қосылған құжаттың құпиясына
қатысты

Құжаттың нөмірі: 2025.05.04.18.16.26

Хавсралт V

АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

202_ оны __ дугаар сарын __-ны өдөр

Захиалагч “Эрдэнэ Монгол” ХХК, болон Гүйцэтгэгч “Гэрэлтэх наран” ХХК нарын хооронд 2025 оны 5 дугаар сарын __-ны өдөр байгуулсан _____ дугаартай Гэрээний гүйцэтгэлийг хянан үзэж Гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн болохыг баталгаажуулж төлбөр тооцоог Гэрээний дагуу төлөхөөр тохиролцов.

Холбогдох бичиг баримтыг хавсаргав. Үүнд:

- Ажил үйлчилгээний тайлан
-

БАТАЛГААЖУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“Эрдэнэ Монгол” ХХК

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“_____” ХХК

Standard Purchase Order



Central Tower, 16th floor, Peace avenue 2nd khoroо
Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia | Tel: 976 77118534 |

Supplier:

Gereltakh Naran
Ulaanbaatar
Ship To: Erdene Mongol LLC
16th Floor, Central Tower
Sukhbaatar District, Ulaanbaatar 14200
Mongolia
Bill To: Erdene Mongol LLC
16th Floor, Central Tower
Sukhbaatar District, Ulaanbaatar 14200
Mongolia

Order / PO number	608
Revision	0
Order Date	27-MAY-25
Incoterms	
Current Buyer	Хатагтуул Чулуунбат
Payment Terms	Payment 45 days after invoice date
Payment Currency	(MNT)

	Item Number	Item Description	Delivery Date	QTY	UOM	Unit Price	Amount
11	771000000001	GA Environmental management services		1	MNT	55000000	55,000,000.00
						VAT (10%)	5,500,000.00
						TOTAL	60,500,000.00

Notes:

Payment shall be made to following account

Bank Name:

Account Number:

Penalty:

Warranty:

Company's requirement for documentation, packing and labeling for goods supplied:

1. Supplier shall enclose the following documents to each shipment delivered to the Company
 - a. Copy of PO
 - b. Packing list (indicates package number, type, gross weight and dimension)
 - c. MSDS (material safety datasheet) for chemicals and dangerous goods
 - d. Technical certificate and datasheets- if available
 - e. Invoice (not required for domestic supplies)
 - f. Certificate of origin (not required for domestic supplies)
 - g. Certificate of quality (not required for domestic supplies)
2. The goods should be packaged properly for easy and safe loading, unloading and transportation
3. Each package containing the goods should have label or shipping mark (total packages, package number, gross weight, supplier's name, contact detail, buyer's name contact detail, PO number)
4. Company may refuse to receive goods delivered without documents, labeling and packing as specified above

Please indicate PO # on all Documentation and Packing.

Erdene Mongol LLC standard terms and conditions are part of this PO

This PO is part of BPA# or CPA#.

Please send all information and documentation regarding this order to Хатагтуул Чулуунбат e-mail phone

Erdene Mongol LLC State Registration #.

On behalf of Erdene Mongol LLC

On behalf of Gereltakh Naran

Approved By

(.....)

Approved By

(.....)



• “САЙЖРУУЛАЛТЫН САР”

“ЭХ ДЭЛХИЙН ӨДӨР”-ИЙГ УГТАЖ 2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ДАРААХ УРАЛДААНУУДЫГ ЗАРЛАЖ БАЙНА.



УРАЛДААНЫ ТӨРӨЛ:

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ШИНЭЛЭГ САНААНУУДЫГ ДЭВШҮҮЛЭХ

ХАМГИЙН ОЛОН ҮЛ ТОХИРОЛ ИЛРҮҮЛЭХ

ЯЛАГЧ:


АЖИЛТАН БҮРИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ
ЧАДАХ ШИНЭЛЭГ САНАА - 3 АЖИЛТАН

ХАМГИЙН ОЛОН ҮЛ ТОХИРОЛ
ИЛРҮҮЛСЭН – 3 АЖИЛТАН



ОРОЛЦОГЧИД САЙЖРУУЛАЛТЫН САНАЛ, АЮУЛЫГ МЭДЭЭЛЛЭХ ХУУДСЫГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭСЭГТ ИРҮҮЛНЭ ҮҮ.

MOTHER EARTH DAY



PROTECT OUR PLANET,
PRESERVE OUR FUTURE


APRIL 22, 2025



"УСАА ХЭМНЭЭ" АЯН



Усны нөөцийг хэмнэлттэй хэрэглэдэг, зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх, шилдэг шийдлүүдийг таниулан сурталчлах зорилготой.



"Ус хэмнэгч"
нэгж - 1



₮ 1,000,000



"Зөвийг дэмжье,
буруугаас татгалзъя"
reels - 3



₮ 100,000



"Зөвийг дэмжье,
буруугаас татгалзъя"
постер - 1



₮ 200,000



"Ус хэмнэх зөвлөгч"
ажилтан - 1



"Аюулыг илрүүлэгч"
ажилтан - 1



Уралдаанд оролцох материал, аюулыг мэдээллэх хуудсыг Байгаль орчны хэсэг хүлээн авна.



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баг, Ургын гол
Хүрэн цэв, Баянхөндий кэмп - 1
Утас : +976 7711 8532
Цахим хуудас : www.erdene.mn
Цахим шуудан : info@erdene.mn

2025.04.17 № 28/25

таныг _____-ны № _____-т

Г Тайлан хүргүүлэх тухай Г

Эрдэнэ Монгол ХХК нь Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэрэг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт хэрэгжүүлж буй Баянхөндий төслийн 2025 онд хэрэгжих Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г хуулийн хугацаанд боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэсэн төрийн захиргааны төв байгууллагаар багдуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Баянхөндий төслийн 2025 оны БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах ажил, арга хэмжээний 2025 оны 1 дүгээр улирлын биелэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна. Хүлээн авч тавилгана уу.

Хувийг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Засаг даргад.
Хавсралт: 02 хуудастай.

Хүндэтгэсэн.

ЗАХИРАЛ



Ц.БААСАНДОРЖ



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баг, Уртын гол
Хүрэн цэв, Баянхондий кэмп - 1
Утас : +976 7711 8532
Цахим хуудас : www.erdene.mn
Цахим шуудан : info@erdene.mn

2025.10.14 № 41/25

танай _____-ны № _____-т

Гайлан хүргүүлэх тухай

Г

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Эрдэнэ Монгол ХХК-ийн MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баянхондийн алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2024 онд байгаль орчны аудит, байгаль орчны менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Ногоон гэрэл ирээдүй ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Байгаль орчны аудитын зөвлөмжид тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажигладаг, 2025 оны III улирлын гайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хавсралт: 3 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



ЦБААСАНДОРЖ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

/2025 оны III улирал/

2025 оны 10 дугаар сарын 10

Уртын гол

Аудитын зөвлөмж	Хэрэгжилт
Гамшгийн эрсдлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, түүнд үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө эрсдлийн үнэлгээ хийлгэнэ хэмээн заасны дагуу Гамшгийн эрсдлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулан хэрэгжүүлэх	Гамшгийн эрсдлийн үнэлгээг 2024 оны 12 сард Гамшиг гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэгээр хийж гүйцэтгүүлэн, гамшгийн эрсдлийн үнэлгээнд суурилан Эрдэнэ Монгол ХХК-ний 2025 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газраар хянуулж баглуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, холбогдох төрийн захиргааны байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг Хануйн цав ХХК-аар гүйцэтгүүлэн Газар зохион байгуулалт, геодээн, зураг зүйн ерөнхий газраар батлуулан, цаашид хэрэгжүүлэх ажил, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
Ус бохирдуулсны төлбөрийн гэрээг АӨГСГЗ-тай байгуулан гэрээнд заасны дагуу харьяалах Татварын албанд төлбөрийг барагдуулан ажиллах	Хаягдал усны дүгнэлтийг АӨГСГЗ-аар гаргуулан 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Э-2504-000116 тоот, Шинэжинст сумын Засаг даргын 2025 оны 04 дугаар сарын 08-ний өдрийн "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгох тухай" А/14 захирамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 24-нд Засаг даргатай 02 тоот гэрээг байгуулсан ба ус бохирдуулсны төлбөр 248,175 төгрөгийг төлсөн.
Уурхайн тосгон болон бусад дэд бүтцийн барилга байгууламжийн ойролцоох элэгдсэн хөрстэй талбайг тухай бүр нөхөн сэргээх, ургамалжуулах	Үйл ажиллагааны явцад, газар шорооны ажил эхлүүлэх, эвдэрсэн газар зэргийг зураглал гарган хэмжээ, чанар байдлыг тогтоож баримтжуулан бүртгэж архивлан хадгалах ажлыг дотоод журмын дагуу гүйцэтгэж байна. Таримал ой байгуулах, агротехник, фитомелиорацийн ажлыг үе шаттай эхлүүлэх ажлыг 2025-2034 зөвхөн нутгийн ургамлыг үр, мөчрөөр үржүүлнэ.
Тухайн аж ахуйн эзэмшил газрынхаа өнгө үзэмж, зрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу байгалийн ургамал, мод үржүүлгийн талбай, мод бүхий зурвас байгуулах ажлыг жил бүрийн төлөвлөгөөгөөр нэмэгдүүлж Монгол улсын газрын тухай хуулийн 56.6-д заасны дагуу эзэмшилд авсан газрын 10%-аас доошгүй талбайг ногоон байгууламжтай болгох шаардлагатай.	MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 2308.62 га талбайн 10 хувь буюу 230.8 га талбайд 2025-2030 он хүртэл ногоон байгууламж, таримал ой байгуулах, техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэхэд хэрэглэх тарьц суулгац бэлтгэх, шимт хөрсний үржил шимт чанарыг алдагдуулахгүйгээр хадгалах, ургамалжуулах төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж эхэлсэн. 2025 онд кемпийн тохижилт салхинаас хамгаалах нөмөрлөгчөөр 4663 хайлаас, тусгай



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баяг, Уртын гол
Хүрэн цав, Баянхөндий кэмп - 1
Утас : +976 7711 8532
Цахим хуудас : www.erdene.mn
Цахим шуудан : info@erdene.mn

2025.10.14 № 78/25

төвний _____ -ны № _____ -т

Г Тайлан хүргүүлэх тухай Г

Баянхөндий штыг үндсэн ордыг ашиглах төслийн 2025 онд хэрэгжүүлж Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн Техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны боловдлийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2025 оны уулын ажлын болон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах төлөвлөгөөтэй уялдуудан дахин боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 20-нд цахим санд байршуулж, 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан.

Шинээр батлагдсан БОМТ-нд 112 арга хэмжээний биелэлтийн тайланг 2025 оны III улирлын байдлаар нэгтгэн, хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авна уу.

Хавсралт: 8/ хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ц.БААСАНДОРЖ



Орон нутгийн харилцааны хэсэгээс

БОМТ-д тусгагдсан ажлын гүйтэтгэл

Төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэх санал гомдолыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх хүрээнд ОНХ хэсэгээс Шинэжинет сумын ИТХ, багийн ИНХ-ын хуралдаанд оролцох, сум багийн удирдлагуудтай тогтмол уулзалт зохион байгуулах, багийн өрхүүдээр айлчилж мэдээлэл хүргэх ажлуудыг гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд сумын ИТХ-ын хуралдаанд 3 удаа оролцож, компанийн ХАГ-ний хэрэгжилт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлын тайлан, БОМТ-ийн хэрэгжилтийн тайлан мэдээг танилцуулсан. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ажлын хүрээнд 2025.09.25-ны байдлаар 50 хүсэлт, санал, өргөдөл ирүүлсэн байна.

Нутгийн иргэдэд уурхайн үйл ажиллагааны мэдээлэл өгч ажиллах ажлын хүрээнд Шинэжинет сумын 4 багийн ИНХ-ын хуралдаанд 2025.06.02-09-ны өдрүүдэд оролцож, Уртын гол багийн 160, Зараа багийн 87, Эрдэнэшанд багийн 124, Эхэн хавцгай багийн 45 иргэнд тайлан мэдээллийг танилцуулсан. Мөн 9 сарын 6-17-ны өдрүүдэд Уртын гол багийн 103 өрхөөр айлчилж, төслийн үйл ажиллагааны талаар мэдээллийг хүргэж ажиллалаа.



2025 оны ОНХ-ны хэсгийн айл өрхөөр зочилсон тэмдэглэл

№	Огноо	Бичиргээ	Огноо нэр	Утасны дугаар	Сонин хувиар бичигдсэн ажил үзэл	Зочилсон хүн	Тайлбар үгс
1	2025/07/10	Алтан	Бичигч	986160
2	2025/07/10	Алтан	Бичигч
3	2025/07/10
4	2025/07/11
5	2025/07/10
6	2025/07/11
7	2025/07/10
8	2025/07/11
9	2025/07/10
10	2025/07/10
11	2025/07/11
12	2025/07/10
13							



2025 оны ОНХ-ны хэсгийн айл өрхөөр зочилсон тэмдэглэл

№	Огноо	Бичиргээ	Огноо нэр	Утасны дугаар	Сонин хувиар бичигдсэн ажил үзэл	Зочилсон хүн	Тайлбар үгс
1	2025/07/11
2	2025/07/11
3	2025/07/11
4	2025/07/11
5	2025/07/11
6	2025/07/11
7	2025/07/11
8	2025/07/11
9	2025/07/11
10	2025/07/11
11	2025/07/11
12	2025/07/11
13	2025/07/11
14	2025/07/11

№	Огноо	Бичиргээ	Огноо нэр	Утасны дугаар	Сонин хувиар бичигдсэн ажил үзэл	Зочилсон хүн	Тайлбар үгс
1	2025/07/11
2	2025/07/11
3	2025/07/11
4	2025/07/11
5	2025/07/11
6	2025/07/11
7	2025/07/11

Айл өрхүүдээр уулзалт хийх үеийн зурагууд.















**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

232 дугаар байр, Гурван бүлэглэл өргөн ажлааг
Төвдөг, 1 дугаар байр, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 34101
Утас: 6757-1142927, 79447964
Эхлэм шуудан: Bayankhongor@biodiversity.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

2025. 02. 05 № 58

Талаа _____ № _____ -1

Санал хүргүүлэх тухай

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт "Эрдэнэ Монгол" ХХК -ний ХХК -ны MV - 021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий "Баян хөндий" алтны үндсэн ордны төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дараах саналыг тусгах шаардлагатай байна. Үүнд:

1. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орсон ажлуудыг 2025 оны төлөвлөгөөнд заалт бүрээр нь бүрэн оруулж батлах.

2. Шатахуун түгээх станц болон шатах тослох материалын агуулахтай холбоотой байгаль орчны асуудлыг тодорхой болгож тусгах.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл, нөхөн сэргээлтийн асуудлыг тодорхой болгож бүрэн тусгах.

4. Хаягдлын сангийн 7 цооногын мэдээллийг тодорхой болгох. /БОНБНУ заасны дагуу/

5. Шимт хөрсний арчлалт хамгаалалтын ажлыг хийж хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаж бүрэн хийж хэрэгжүүлэх.

6. Зөвхөн орон нутгийн захиргаанаас зөвшөөрөгдсөн талбайгаас ургамлын үрийг түүж бэлтгэх, нөхөн сэргээлтэнд ашиглах.

7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд химийн бодис, дэсэрч дэлбэрэх бодисын ашиглалт хамгаалалт талаар тодорхой тусгаж өгөх.


8. Бүс нутгийн хэмжээний биологийн төрөл зүйл амьтан, ургамалын судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтарч хийх.

9. Энгийн болон аюултай хог хаягдлын гэрээг тусгай зөвшөөрөлтэй ААН -тэй гэрээ байгуулан ажиллах.

642407083

10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон, нөхөн сэргээх шаардлагатай газарт нөхөн сэргээлтийг хийж бэлчээрийн зориулалттай ашиглах нөхцөлийг бүрдүүлж орон нутгийн нөхөн сэргээлт хүлээж авах комисст хүлээлгэн өгөх.

ГАЗРЫН А
ГҮЙЦЭТГ (



АН УҮРГИЙГ ТҮР ОРЛОН
АНЗОРИГ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

202 дугаар байр, Гурван бүсийн өргөн чөлөө-2,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 04101
Утас: (976)70442927, 70442064

Цахим шуудан: Bayankhongor_hoa@gazarg@gmail.com

2025.04.17 № 169

танай _____ ныг № _____ -т

Г Хууль хэрэгжүүлж ажиллах тухай Г

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг "Эрдэнэ Монгол" ХХК -нд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хяналтын ерөнхий байцаагчийн 2025 оны 02 дугаар сарын 03 өдрийн 01/03 удирдамж аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24 -ний өдрийн А/155 тоот захирамжийн хүрээнд хийгдсэн төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар дараах зөрчил дутагдал илрээд байна. Үүнд:

- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээг бүрэн тусгаагүй.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан хугацаа, зардал хөрөнгийн асуудал.
- Түгээмэл гархацтай ашигт малтмалын олборлолт, нөхөн сэргээлт,
- Шатахуун түгээх станцын асуудал,
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан хугацаа тодорхогүй
- 110 кВт эрчим хүчний шугамын татсан /Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ батлагдаагүй, тухай жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, эрчим хүчний ажил 80%- гүйцэтгэлтэй хийгдсэн зэрэг нь "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн /9.6.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна./ 9.7.Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг

тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журмын /3.1 Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан багалснаар төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ /

Журмын 1.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий уламлан дөмрөг, усны аймгийг хамгаалах хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн орчин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хэтөлбөр орно. **Журмын 2.4.** Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга, энэ журмын 1.5-д заасан бүрдэл хэсгүүд, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана. **Журмын 2.8.** Уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа уурхай, дэд бүтцийг барилга байгууламж, баяжуулах боловсруулах үйлдвэр, зам, талбайг хамруулан төлөвлөх бөгөөд ус хангамж, ариутгах татуурга, химийн хортой болон аюултай бодис ашиглах, хадгалах байгууламж, туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбогдох

байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг нэгтгэн тусгаж, эрх бүхий байгууллагын баталсан уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн эхний улиралд багтаан эцэслэн баталгаажуулна. **Журмын 2.9.** Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ашигт малтмал олборлох төслийн хувьд эрх бүхий байгууллагын баталсан уулын ажлын төлөвлөгөөтэй, газрын тос, уламжлалт газрын тос, цацраг идэвхит ашигт малтмал хайх төслийн хувьд эрх бүхий байгууллагын баталсан хайгуулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна.

Журмын 2.16. Дэд бүтцийн болон уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд жилдээ хэрэглэх химийн хортой болон аюултай бодис, шатах тослох материалын хэмжээ, тээвэрлэлт, хадгалалт, устгалт саармагжуулалт, сав баглаа боодлын хадгалалт, устгалтын талаар нарийвчлан тусгана. **Журмын 2.17.** Дэд бүтцийн төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай гүээзмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах явцад үүсэх эвдрэлийг нөхөн сэргээх арга хэмжээг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгана / гэж заасан байдаг.

Иймд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нарийвчилсэн үнэлгээний тайлангын байгаль хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулан 2025 оны 05 дугаар сарын 20 -ны дотор холбогдох дээд шатны байгууллагаар батлуулж ажиглана уу



ЭН
АНЗОРИГ



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баг, Уртын гол
Хүрэн цэв, Баянхөндий кэмп - 1
Утас: +976 7711 8532
Цахим хуудас: www.erdene.mn
Цахим шуудан: info@erdene.mn

2025.05.20 № 40/25

танай 2025.04.17-ны № 169 -т

Хариу хүргүүлэх тухай

Таны ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 169 тоот албан бичгийг хүлээн авч танилцлаа.

Албан бичигт тусгагдсан зөрчил, дутагдлын үл тохирлыг засч залруулсан мэдээлтийг дараах байдлаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

1. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүрэн тусгаагүй.

Эко Трейд ХХК-ийн 2021 онд боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-021444 дугаартай тусгай зөвшөөрөлтэй алсны үндсэн ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (2021-2025)-нд тусгагдсаны дагуу 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах нийт 38 арга хэмжээг тусган орууллаа.

2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан хугацаа, зардал хөрөнгийн асуудал.

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий төслийн Байгаль хамгаалах арга хэмжээнд 2021-2024 онуудад 1,068,026,000 (Нэг тэрбум жаран найман сая хорин зургаан мянган төгрөг) зарцуулсан бөгөөд 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний барьлаа харенгө болох 150,000,000 төгрөгийг тусгай дансанд байршуулсан болно. Мөн төлөвлөгөөний орчны хяналт шилжилгээний хөтөлбөрийн хэрэгжих хугацааг нарийвчлан тодорхойллоо.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, нөхөн сэргээлт.

Манай компани ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохдоо тухай бүр холбогдох зөвшөөрлийг авч, сумтай гэрээ байгуулан төлбөрийг төлж, нөхөн сэргээлтийг гүйцэтгэсэн. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтоос үүсэх нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг багасгахаас гадна нөхөн сэргээлтийн бүлэгт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон талбайд биологийн нөхөн сэргээлт хийж эхлэх зэрэг ажлуудыг нэмэлтээр төлөвлөсөн.

4. Шатахуун түгээх станцын асуудал.

Компанийн зүгээс Газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын үйл ажиллагааг эрхэлж байгаа гэрээт компани Шунхлай трейдинг ХХК-д албан бичиг хүргүүлсний дагуу танай газарт БОНЕУ-ний дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2025 оны 04 дүгээр сард гаргасан.

5. 110 кВт эрчим хүчний шугамын ажлын БОННУ батлуулах.

Баянхөндий алтны үндсэн ордыг аниглах төслийн 2021 онд батлагдсан БОННУ-ний тайланд: Уурхайн цахилгаан хангамжийг улсын төвлөрсөн цахилгаан шугамаас хангах боломжгүй, дизель цахилгаан эх үүсвэр болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослуулан ашиглахаар төсөлд тусгасан байсан тул 110/11 кВ-ын 2*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд хуулийн нийцтэй байдлыг хангах зорилгоор гүйцэтгэгч М-Си-Эс Интернейшнл ХХК нь БОННУ-г Грийн ассессмент ХХК-иар гүйцэтгүүлэн, баталгаажуулсан байна.

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий төслийн талбайд үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын хууль, тэдгээрт нийнүүлэн гаргасан эрхзүйн актуудын нийцлийг ханган, төслийн зүгээс үзүүлэх аливаа нөлөөллийг стандартын шаардлагад нийцүүлэх, боломжит хамгийн бага түвшинд байлгахыг зорьно.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр халгах зэрэг олон хүчин зүйлүүд нхээхэн нөлөөлж, төсөл хөгжүүлэлтийн үе шатанд өөрчлөлт орсноор барилга угсралтын ажил 2023 оны 07 сард эхэлсэн.

Ордын нөөц өссөн нь БОННУ гүйцэтгэж байх үеийн төлөвлөлтөд өөрчлөлт орох үндсэн нөхцөл болсон ба дээр дурьдсан шалтгаануудын улмаас 2021 – 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-д тусгагдсан 151 арга хэмжээнээс 15 арга хэмжээг 2021 - 2024 онуудад бүрэн хэрэгжүүлж дууссан. Үлдсэн 136 арга хэмжээнээс тухайн жилд гүйцэтгэх ажилтай уялдуулан байгаль хамгаалах, өсөл эрдэлээс сэргийлэх 112 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан. Бөгөөд тухайлбал техникийн нөхөн сэргээлтийг 6.3 га талбайд гүйцэтгэхээр төлөвлөснийг 25.92 га талбайд гүйцэтгэн 4.1 цахим давуулан биелүүлсэн. Үндэслний бахархалт амьтан мазаалай баавгайг хамгаалах ажилд дэмжлэг үзүүлэн 2024, 2025 онуудад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тэжээлийн сав 1 ширхэгийг байрлуулсан. Мөн 2025 онд 1 ш мазаалай баавгайд хүзүүвч зүүх ажлыг санхүүжүүлсэн.

Бид 2025 оны Баянхөндий төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дээрх бүхий л засвар, сайжруулалтыг оруулан, тодотголыг батлуулахаар байгаль орчны үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулсан болно.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ц.БААСАНДОРЖ

Баянхөндий алтны үндсэн ордыг аниглах төслийн 2021 онд батлагдсан БОННУ-ний тайланд: Уурхайн цахилгаан хангамжийг улсын төвлөрсөн цахилгаан шугамаас хангах боломжгүй, дизель цахилгаан эх үүсвэр болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослуулан ашиглахаар төсөлд тусгасан байсан тул 110/11 кВ-ын 2*16 МВА чадалтай Баянхөндий дэд станц, 2*2750 кВА чадалтай дизель генератор, 7.7 км урттай 11 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд хуулийн нийцтэй байдлыг хангах зорилгоор гүйцэтгэгч М-Си-Эс Интернейшнл ХХК нь БОННУ-г Грийн ассессмент ХХК-иар гүйцэтгүүлэн, баталгаажуулсан байна.

Эрдэв Монгол ХХК нь Баянхөндий төслийн талбайд үйл ажиллагаа явуулахдаа Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрхзүйн актуудын нийцлийг ханган, төслийн зүгээс үзүүлэх аливаа нөлөөллийг стандартын шаардлагад нийцүүлэх, боломжит хамгийн бага түвшинд байлгахыг зорьдог.

Баянхөндий төслийн үйл ажиллагаанд коронавирусын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, хил гаалийн хүндрэл бэрхшээл, нөгөө талаас зарим төрийн бус байгууллага, иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, тэдгээрийг мэдээллээр хангах зэрэг олон хүчин зүйлүүд ихээхэн нөлөөлж, төсөл хөгжүүлэлтийн үе шатанд өөрчлөлт өрсноор барилга угсралтын ажил 2023 оны 07 сард эхэлсэн.

Ордын нөөц өссөн нь БОННУ гүйцэтгэж байх үеийн төлөвлөлтөд өөрчлөлт орох үндсэн нөхцөл болсон ба дээр дурьдсан шалтгаануудын улмаас 2021 – 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-д тусгагдсан 151 арга хэмжээнээс 15 арга хэмжээг 2021 - 2024 онуудад бүрэн хэрэгжүүлж дууссан. Үлдсэн 136 арга хэмжээнээс тухайн жилд гүйцэтгэх ажилтай уялдуулан байгаль хамгаалах, осол эрсдэлээ сэргийлэх 112 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан. Бөгөөд тухайлбал техникийн нөхөн сэргээлтийг 6.3 га талбайд гүйцэтгэхээр төлөвлөснийг 25.92 га талбайд гүйцэтгэн 4.1 дахин давуулан биелүүлсэн. Үндэсний бахархалт амьтан мазаалай бавгайг хамгаалах ажилд нэмжлэг үзүүлэн 2024, 2025 онуудад биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тэжээлийн сав 1 ширхэгийг байрлуулсан. Мөн 2025 онд 1 ш мазаалай бавгайд хүзүүвч зүүх ажлыг санхүүжүүлсэн.

Бид 2025 оны Баянхөндий төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дээрх бүхий л засвар, сайжруулалтыг оруулан, тодотголыг барлуулахаар байгаль орчны үнэлгээний мэдээллийн цахим саид байршуулсан болно.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ц.БААСАНДОРЖ

**ЗАЛААГИЙН ТЭЭВЭРЧИД ХХК-НЫ ТӨЛӨӨЛӨЛТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ**

Огноо/цаг: 2025.06.29	Байршил. Баянхөндий “Мазаалай” кемпийн хурлын өрөө		
Хуралд оролцогсад:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал
Д.Агьмаа	Захиргааны ахлах менежер	В.Цэрэндолгор	Захиргааны ажилтан
Д.Билгүүн	Хүний нөөцийн менежер	Б.Мөнхтүшиг	Захиргааны ажилтан
Ж.Мягмарцаваа	Засварын менежер	Т.Одгэрэл	Залаагийн тээвэрчид ХХК-ны захирал
Ж.Сандуй	ХАБ-ын ахлах ажилтан	Д.Цэрэнням	Залаагийн тээвэрчид ХХК-ны нягтлан
Ц.Өлзий-Ундрах	БО-ны ажилтан		
<p>Д.Агьмаа: Юуны өмнө хол газраас биднийг зорин ирж энэхүү уулзалтад хүрэлцэн ирсэнд баярлалаа. Өнөөдрийн уулзалтаар га бүгдтэй хэд хэдэн тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх, цаалид хэрхэн үйл ажиллагаагаа сайжруулах талаар хэлэлцэхээр энэхүү уулзалтыг зохион байгуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүдийг та бүгд мэдэж байгаа. Одоогоор тулгамдаад байгаа гол асуудлууд нь манай ажиллагсдын ээлж солилцоогоор яаж байгаа фургон автомашинууд хурд хэтрүүлэх зөрчил ихээр гаргаж байна. Бид ажилтнуудынхаа амь насыг та бүхэнд даатгаж байгаа. Иймээс бүх машинууддаа GPS-ээр хурдны хяналтаа хийх хэрэгтэй байна. Компанийхаа тусгай зөвшөөрлийн дагуу Авто тээврийн үндэсний төвийн үндсэн шаардлагуудыг биелүүлэе. - Дараагийн асуудал нь ээлж солилцооны фургонууд Air condition ажиллахгүй байна гэсэн гомдол санал ирсэн. Гэрээний дагуу бүх тээврийн хэрэгсэл бүрэн бүтэн байх, халшалт, хөргүүрийн систем бүрэн ажиллагаатай байх ёстой. Хол замд агааржуулагчгүй машинд явахаас халшранц ажилтнууд маань ажлаасаа гарах зэрэг асуудлууд хөндөгдөж эхэлсэн тул яаралтай хариу арга хэмжээ авах. - Танай байгууллагын ХАБ болон механик инженер нь өдөр тутмын зааварчилгаа, холын аяллын зааварчилгаагаа хэрхэн өгдөг вэ? техникийн үзлэг шалгалт яаж явагддаг вэ? Холбогдох баримтуудыг и мэйлээр илгээж байх. - Залаагийн тээвэр ХХК дээр албан ёсны тушаал гарсан, нийгмийн даатгал төлдөг жолооч нарыг тээвэрт явуулах. Холбогдох тушаалыг манайд хүргүүлэх. - Шинээр КР1 гүйцэтгэл гэрээн дээр нэмэгдсэн. Сар бүрийн 02-ны өдрүүдэд сарын тайлангийн хурал дээр гүйцэтгэлийг үнэлнэ. - Танай нэр бүхий жолооч манай ажилтнуудтай хамаагүй юм ярьдаг, компанийн дотоод мэдээллийг асуудаг, эргүүлээд энэ мэдээллээ олон нийтэд өөргөөр гуйвуулж ярьдаг гэсэн мэдээллүүд удаа дараа удирдлагуудад орж ирсэн. Хамтран ажиллах гэрээнд дурдсан Компанийн үйл ажиллагаа болон бизнесийн, ажилтнуудын нэр хүндэд халдах, олон нийтэд буруу ташаа мэдээлэл өгвөл шууд гэрээ цуцлах заалттай. Цэр бүхий жолоочийг оноодроос манайд үйлчилгээнд явуулахгүй байх. <p>Д.Билгүүн:</p> <ul style="list-style-type: none"> - Манай үндсэн ажилтнууд сард 8 удаа тээврийн хэрэгсэлээр зорчихоор байгаа. Бууж байгаа болон ирж байгаа ажилтнууд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, хэрэглэхийг завдсан зүйл дээр мөн танай байгууллагын жолооч нар хяналтыг тавьж ажиллах. - Автомашины хар хайрцагтай болчихвол зүгээр юм болов уу? гэж харж байна. - Аялалд гарч буй жолооч нартаа хэрхэн хяналт тавьдаг вэ? Өмнөх өдөр нь тээвэрт явчихаад 8 цаг унтаж амрахгүйгээр шууд аялалд явах зэрэг асуудлуудад хяналт тавьж ажиллаарай. Үүнийг үзлэгийн хуудастайгаа хамт илгээх. <p>Ж.Сандуй:</p> <ul style="list-style-type: none"> - 4 сараас хойш манайхаас 4, 5 и-мэйл явсан. Хурд хэтрүүлэлт болон салаа зам үүсгэхгүй байхад анхаарах хэрэгтэй байна. - Түүнчлэн алкохолны асуудал, техникийн бүрэн бүтэн байдал, жолооч нь кабинаа тамхи татах зэрэг зорчигчдын ах тухай байдалтай хамааралтай асуудлуудад анхаарах. - Төслийн хэмжээний замын холбогдох журмын сургалтад жолооч нараа хамруудвал манай зүгээс нээлттэй гэдгийг хэлэе. 			

П.Өлзий-Ундрах:

Жолооч нар замаас гарч шинэ салаа зам гаргах асуудалд анхаарах. Мөн Хөгжлийн удирдлага зохицуулалтын журам гэж байгаа. Үүнийг дагаж мөрдөж, хэрэгжүүлээсэй гэж хүсэж байна.

Ж.Мягмардаваа:

Омнеговьд явдаг фуртонууд бүгд жижиг нарны зайгаар ажилладаг агааржуулагч буюу Air condition суурилуулсан байдаг. Үүнийг судалж хэрэгжүүлээсэй гэж хүсэж байна. Нэмэлтээр аялалт гарахын өмнөх техникийн бүрэн бүтэн байдлыг шалгасан техникийн үзлэгийн хуудсыг бөглөөд манайх компани руу илгээж байх гэсэн хүсэлтийг хүргүүлж байна.

Т.Одгэрал:

- Манай бүх машинууд GPS-тэй байгаа. Хүсвэл тантай компани программыг нь авч үзэж болно. Air condition-ны хувьд туршилтаар авч ажиллуулахаар Орос руу захиалсан байгаа. 7 сарын сүүлээр буюу 20-ноос хойш ирнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Д.Агьмаа:


Манай байгууллагын санхүүгийн зүгээс сар бүрийн 2 тэхэл бүх тооцоогоо дуусгасан байхыг шаардаж байгаа. Тиймээс нэхэмжлэх болон бусад зүйлсээ 1-ны дотор шалтгаал, тэр өдрөө гүйцэтгэлийн үйлчлэлийн хуралд оролцоод явахаар байгаа. Хэрэв цаг зав нь байвал ирээд хуралдаа оролцож болно. Амжихгүй тохиолдолд техникийн бүрэн бүтэн байдалтайгаар онлайн хуралд оролцох. Цаашил илүү сайн гүйцэтгэлтэй ажиллахыг хүсэж байна. Өгөөдрийн уулзалтаар олон зүйлийг шийдвэлд хүрч байгаад баяртай байна. Та бүгдэдээ амжилт хүсье.

Шийдвэр:	Хариуцах эзэн	Огноо
Залаагийн тээвэрчин компани дээр албан ёсны тушаал гараад нийгмийн даатгал төлдөг жолооч нарыг үйлчилгээнд явуулах. Холболдох тулаалыг манай компанид хүргүүлэх. ХАБ болон механик инженерийг мөн хамруулах.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Сүүлийн нэг сард явсан автомашинуудын GPS-ийн хурдны мэдээллийг өгөх.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Air condition-ны асуудлыг яаралтай шийдвэрлэх.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Манай дээр явж байгаа тээврийн хэрэгслүүдийн бичиг баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, үзлэгийн хуудас зэргийг шинэчилж ирүүлэх.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Тээврийн хэрэгслүүдэд хар хайрцаг суурилуулах.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Аялалд гарахын өмнөх жолооч болон техникийн бүрэн бүтэн байдал шалгасан техникийн үзлэгийн хуудсыг бөглөх.	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард
Дээрх бүх мэдээллүүдийг arimaad@erdene.mn , myagmardavaa.j@erdene.mn , bk_admin@erdene.mn , bk_safety@erdene.mn , bk_jcc@erdene.mn	Залаагийн тээвэрчин ХХК	Ирэх сард

Хурлын протокол хөтөлсөн: Захиргааны ажилтан........../Б.Мөнхтүшиг/

Хурлын шийдвэр хянасан: Захиргааны менежер........../Д.Агьмаа/



Хурлын шийдвэр баталгаажуулсан: Төслийн удирдлага хариуцсан захирал

...../Х.Батболд/

SITE NOTICE / ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА

Төслийн нэр: Project name	Баянхөндий төсөл		
Дугаар: Number	EM-BKG-NOT-159	Огноо: Date	2024-07-20
Хэнээс: From	Э.Өнөрзаяа /Эрдэнэ Монгол ХХК/		
Хэнд: To	М-Си-Эс Проперти ХХК, П.Энхбаяр Монруд ХХК, Б.Уранбилэг М-Армор ХХК, О.Батбаяр Залаагийн тэвэрчин ХХК, Т.Одгарэл		
Хувийг: Cc	Г.Даваадорж, Х.Батболд		
Тухай: Subject	Хог хаягдлын сургалт зохион байгуулах тухай		

Тайлбар / Description
<p>Захиалагчийн зүгээс хог хаягдлыг ил заагай хаяхгүй байх талаарх мэдлэгийг ажилтнуудад талбайн ерөнхий зааварчилгаагаар дамжуулан олгохоос гадна 2024 оны 1 дүгээр сарын 23, 3 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p> <p>Бид талбай дээрх сургалтуудыг зохион байгуулж байгаа хэдий ч ажилтнууд ажилдаа ирэх, буцах замдаа хог хаягдлаа ил задгай хаях байдал засрахгүй байна.</p> <p>Иймд, ээлж солилцох бүрт бүх ажилтнууддаа "хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх" талаарх сургалтыг зохион байгуулж, сургалтын үйл явцыг баримтжуулан, сургалтанд оролцогчдоор гарын үсэг зуруулж хариуг сургалт зохион байгуулсан тухай бүрт ирүүлнэ үү.</p>





Баталгаажуулсан Confirmed by	Нэр, Албан тушаал Name, Position	Гарын үсэг Signature	Огноо Date
Эрдэнэ Монгол ХХК			
Бэлтгэсэн Prepared by	Э.Өнөрзаяа Байгаль орчны ахлах ажилтан		2024.07.20
Хянасан Reviewed by	Т.Ганболд Салбарын захиргааны албаны дарга		2024.07.20
"Хүлээн авагч байгууллага"			
Хүлээн авсан Баталгаажуулсан Received and confirmed by			



SITE NOTICE / ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА

Төслийн нэр: Project name	Баянхөндий тосол		
Дугаар: Number	EM-BKG-NOT-264	Огноо: Date	2024-11-23
Хэвлэл: From	Эрдэнэ Монгол ХХК		
Хэнд: To	Баянхөндийн төслийн гэрээг Гүйцэтгэгч компаниуд		
Хувийг: Cc	Bk_environment@erdene.mn, bk_construction@erdene.mn Ganbold.t@erdene.mn Batbold.kh@erdene.mn		
ЭТухай: Subject	Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ИТХ-ын хурлын хуралдааны 51 дүгээр тогтоолыг зөрчиж Цагаан хаалгаар ачаа тээврийн автомашин зорчиж байгаа тухай.		

Тайлбар / Description			
<p>Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн “Замын чиглэл тогтоох” тухай А/396 тоот захирамжаар Баянхонгор аймгийн төв-Шинэжинст сумын төв чиглэлийн орон нутгийн чанартай шороон замын төгсгөлөөс Цагаан хаалга- (Баруун талаар тойрох) Үзүүр худаг-Баянхөндий төслийн талбай гэсэн чиглэлээр замын чиглэлийг тогтоосон байдаг.</p> <p>“Согс цагаан болд нутгаа хамгаалах иргэний хөдөлгөөн” НҮТББ-ын төлөөлөл оролцсон 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийнх уулзалтаар Цагаан хаалганы рашааны тойрч явах тухай шаардлагыг тавьж, Гатууд хүлээн зөвшөөрсөн.</p> <p>Цагаан хаалганы рашааны замд хөдөлгөөн мэдрэгч автомат камерийг суурилуулсан ба үүнийг Шинэжинст сумын ЗДТГ хянаж байгаа бөгөөд эхний камерийн хяналтаар төслийн талбайд ирсэн, төслийн талбайгаас буцсан ачааны машинууд Цагаан хаалганы рашааны нэвтрэхийг хориглосон бүсээр нэвтэрч бүртгэгдсэн байна. Энэ зөрчил нь:</p> <ol style="list-style-type: none">Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсрэг сөрөг үр дагавар үүсэхОлон нийтийн сүлжээгээр компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхТөслийн ачаа тээврийг нутгийн иргэд зогсоох эрсдэлтэй байна. <p>Иймд:</p> <ul style="list-style-type: none">Ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг байгаа өөрийн болон туслан гүйцэтгэгч нарт замын маршрутыг чанд мөрдөхийг сануулахЖолооч нарт батлагдсан маршрутаар зорчих, цуваагаар явах, цуваагаар зогсох, шинэ зам үүсгэхгүй байхыг хатуу анхааруулахЯмарваа нэгэн зөрчлийн арга хэмжээ тооцогдох бол тухайн зөрчил гаргасан байгууллага торгууль, шийтгэлийг хариуцах ёстойг анхаарна уу.			
Баталгаажуулсан Confirmed by	Нэр, Албан тушаал Name, Position	Гарын үсэг Signature	Огноо Date
Эрдэнэ Монгол ХХК			
Бэлтгэсэн Prepared by	П.Өлзий-Ундрах Байгаль орчны ажигтан		2024.11.23
Баталгаажуулсан Confirmed by	Б.Үүрийнтуяа ХАБЭАБО менежер		2024.11.23

Баталгаажуулсан Confirmed by	Г.Баярмөнх БУА-ны менежер		2024.11.23
Баталгаажуулсан Confirmed by	Б.Азжаргал ДБА-ны менежер		2024.11.23
Баталгаажуулсан Confirmed by	Р.Оюунбат Үйлдвэрийн ерөнхий инженер		2024.11.23
Баталгаажуулсан Confirmed by	Х.Батболд Төслийн удирдлага хариуцсан захирал		
<u>"Хүлээн авагч байгууллага"</u>			
Хүлээн авсан /Баталгаажуулсан Received and confirmed by			



SITE NOTICE / ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА

Төслийн нэр: Project Name	Баянхөндий төсөл		
Дугаар: Number	EM-BKG-NOT-287	Огноо: Date	2025.01.09
Хэнээс: From	С.Үүриймаа /Эрдэнэ Монгол ХХК/		
Хэнд: To	М Си Эс Проперти ХХК-д, Заллагийн тээвэрчид ХХК-д /zalaagiinteewerchid@gmail.com/		
Хувийг: Cc	М Си Эс Проперти ХАБЭА-н албанд, Х.Батболд, Т.Ганболд, Б.Үүрийнтуяа, ХАБЭА-н хэсэг, ОНХ-ны хэсэг		
Тухайн: Subject	Хүн тээврийн гэрээт компанид "Замын ходелгооний давтан" сургалт зохион байгуулах тухай		



Тайлбар / Description
2025.01.02 өдрийн ирүүлсэн Аюулыг мэдээлэх хуудас-н дагуу: -2024.12.26 өдөр Заллагийн тээвэрчин ХХК-н ээлж сольж байгаа пургонууд стандарт бус их гэрэлтэй, гэрэлээ шилжүүлээгүй. -2025.01.02 өдрийн ээлж солилцох үед төслийн талбайд байрлах хурдны хязгаарыг (замын тэмдэг дагаагүй) мөрдөөгүй. Иймд тус тээвэрт ажиллаж байгаа нийт жолооч нарт шаардлагатай сургалтыг зохион байгуулж хялбардох мэдээлэлийг Эрдэнэ Монгол ХХК-н ХАБЭА-н хэсэгт, М Си Эс Проперти ХХК-н ХАБЭАБО-ны албанд ирүүлнэ үү.

Баталгаажуулсан Confirmed by	Нэр, Албан тушаал Name, Position	Гарын үсэг Signature	Огноо Date
Эрдэнэ Монгол ХХК			
Бэлтгэсэн Prepared by	С.Үүриймаа ХАБ-н ажилтан		2025.01.09
Хянасан Reviewed by	Т.Ганболд, СЗАлбаны дарга		2025.01.09
<u>"Хүлээн авсанч байгууллага"</u>			
Хүлээн авсан /Баталгаажуулсан Received and confirmed by			

SITE NOTICE / ТАЛБАЙН ЗААВАРЧИЛГАА

Төслийн нэр: Project name	Баянхөндий төсөл		
Дугаар: Number	EM-BKG-NOT-160	Огноо: Date	2024-07-20
Хэнээс: From	Э.Өнөрзаяа /Эрдэнэ Монгол ХХК/		
Хэнд: To	Залаагийн тээвэрчин ХХК, Т.Одгэрэл		
Хувийг: Cc	Ц.Энхтөр, Г.Даваадорж, Х.Батболд		
Тухай: Subject	Мэдэгдэл хүргүүлэх тухай		

Тайлбар / Description
<p>Баянхөндий төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор "Эрдэнэ Монгол" ХХК болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн ээлж солиоцох үеийн тээвэрлэлтийг орон нутгийн хөгжлийг дамжих зорилгоор танай компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>Ажилтнууд тээврийн хэрэгслээр зорчих үед хог хаягдлыг ил задгай хаяхаас сэргийлж тээвэр гүйцэтгэх үед машин тус бүрт хогийн уутыг тогтмол байршуулан, цугларсан хогийг төвлөрсөн хогийн цэгт хаяж, батлагдсан маршрутын дагуу олон салаа зам үүсгэхгүйгээр, хурдны хязгаарыг мөрдөн тээвэрлэлтийг гүйцэтгэхийг үүгээр мэдэгдэж байна.</p> <p>Тээвэрлэлтийн үед үүссэн хог хаягдлын хэмжээг бүртгэн, замын хуудсанд тэмдэглэл хөтлөн хянуулна уу.</p>

Баталгаажуулсан Confirmed by	Нэр, Албан тушаал Name, Position	Гарын үсэг Signature	Огноо Date
Эрдэнэ Монгол ХХК			
Бэлтгэсэн Prepared by	Э.Өнөрзаяа Байгаль орчны ахлах ажилтан		2024.07.20
Хянасан Reviewed by	Т.Ганболд Салбарын захиргааны албаны дарга		2024.07.20
"Хүлээн авагч байгууллага"			
Хүлээн авсан /Баталгаажуулсан Received and confirmed by			



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баг, Уртын гол
Хүрэн цав, Баянхөндий кэмп - 1
Утас : +976 7711 8532
Цахим хуудас : www.erdene.mn
Цахим шуудан : info@erdene.mn

24

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ

ЭОД.03.31 № 22/25

ганай _____ -ны № _____ -т

Зөвшөөрөл хүсэх тухай

Тус компани нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутаг дэвсгэрт орших MV-021444 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Хөндий алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах олборлолт, үйлдвэрлэлийг цогцоор бүтээн байгуулах "Баянхөндий төсөл" (цаашид "Төсөл" гэх)-ийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.

Эрдэнэ Монгол ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн нэг сая мод тарьж ургуулах төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, биологийн цөхөн сэргээлтэд зөвхөн нутгийн ургамлын үр, мөчрийг ашиглан байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, тарьц суулгах бэлтгэх ажлуудыг 2022-2030 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн нутгийн иргэдийг дэмжиж, хамтран тарьмал ой байгуулах ажлыг эхлүүлээд байна.

Шинэжинст сумын нутагт зарим жилүүдэд хур тунадас бага, хуурайшилт их зэргээс шалтгаалан зарим зүйлийн ургамлын үрийн нөөц бэлтгэх боломж хязгаарлагдмал байдаг учраас говийн бүсийн сумдын нутаг дэвсгэрээс шаардлагагай ургамлын үрийг түүх нөхцөл үүсдэг: Тухайлбал, цагаан модот заг /*Haloxylon Ammodendron*/, одой хайлаас /*Ulmus Pumila*/, монгол буйлс /*Amygdalus Mongolica*/, элдэв навчит улиас /*Populus diversifolia*/, үнэгэн сүүдхэй лидэр /*Sophoria Alocuroides*/, мөнгөлөг жинд /*Elaeagnus moorcroftii*/ зэрэг нутгийн ургамлын үр бэлтгэхэд зөвхөн Шинэжинст сумын нутаг дэвсгэрээр хязгаарлагдахгүй байдал үүсдэг.

Иймд, үр түүх талбайг тусгаарлан өгч, тусгаарлуулсан талбайгаас үр түүх зөвшөөрлийг олгож бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Бид нутгийн ургамлын үр түүхдээ байгаль орчинд ямар ч сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй ба Байгалийн ургамлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг чанд баримтлан ажиллах болно.

Хавсралт: 1. хуудастай.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ

Ц.БААСАНДОРЖ

Эрдэнэ Монгол ХХК-ийн Баянхонгор аймгад дахь
Салбарын 2025 оны 03 дугаар сарын 31 өдрийн
2025/03 тоот албан ёсны Холбоот

БЭЛТГЭХ ҮРИЙН ХЭМЖЭЭ, ҮР БЭЛТГЭХ ТАЛБАЙН НЭР /2025 ОН/

№	Үр, мөчрийн нэр	Үр мөчир бэлтгэх хугацаа, сар	Хэмжих нэгж	Үрийн хэмжээ
1	Шар модот хотир	VII, VIII	кг	5
2	Элдэв навчит улиас	VII	кг	3
3	Үнэгэн сүүлжэй лидэр	IX	кг	5
4	Чихэр өвс	VIII	кг	5
5	Жигд	X	кг	5
6	Цагаан модот заг	XI	кг	20
7	Одой хайлаас	V	кг	15
Нийт				58 кг
8	Сухай /мочир/	II	ш	10,000

—oOo—



ЭРДЭНЭ МОНГОЛ ХХК
Баянхонгор аймаг дахь салбар

Монгол Улс, Баянхонгор аймаг
Шинэжинст сум, 2-р баг, Уртын гол
Хүрэн цав, Баянхөндий кэмп - 1
Утас : +976 7711 8532
Цахим хуудас : www.erdene.mn
Цахим шуудан : info@erdene.mn

Г
7
Баянхонгор аймгийн
Байгаль орчны газрын дарга
Э.ГАНЗОРИГ ТАНАА

2025.07.30 N _____

танай _____-ны № _____-т

Г 7

Техникийн нөхөн сэргээлт
хүдээлгэн өгөх тухай

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Уртын гол багийн нутаг дэвсгэрт байршилтай MV-021444 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд алтны үндсэн ордыг ил аргаар ашиглах олборлолт, үйлдвэрлэлийн “Баянхөндий төсөл” /цаашид “Төсөл” гэх/-ийг 2023 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийн барилга угсралт, дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилгын суурийн буцаан дүүрэгт зэрэг ажиуудад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гур зөвшөөрлийг Баянхонгор аймгийн Засаг даргын А/527, А/727, А/430, А/230, А/231 тоот захирамжуудын хүрээнд захирамжийн хавсралтаар батлагдсан байршлаас авч ашигласан ба тус захирамжуудын хүрээнд нийт 52,633 м3 түгээмэл тархацтай ашигт малтмалыг авч ашиглан, олборлолтоос үүдэн 14.87 га талбайг эвдрэлд оруулсан байна.

Эвдрэлд орсон 14.87 га талбайд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалын хавсралт “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргаачлал”-ын шаардлагад нийцүүлэн техникийн нөхөн сэргээлтийг хийж, 1 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг тус тус гүйцэтгэсэн бөгөөд цаашид үлдсэн 13.87 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу, үе шаттайгаар гүйцэтгэх бөгөөд уурхайн хаалтын нөхөн сэргээлт хийх үед дууслахаар төлөвлөн ажиллаж байна.

Иймд, техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн 14.87 га талбай болон биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн 1 га газрыг хүлээн авах ажлын хэсгийг томилон, ажиллуулан өгч, тус талбайнуудыг нөхөн сэргээгдсэн талбайн мэдээлэлд бүртгэж өгнө үү.

Хавсралтаар нөхөн сэргээлтийн тайлан хургуулж байна.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ц.БААСАНДОРЖ

ШИНЭЖИНСТ СУМЫН 2022-2025 ОНД ТАРЬСАН МОДНЫ УРГАЛТЫГ ТОГТООСОН АКТ

2025 оны 10-р сарын 16

“Эрдэнэ монгол” ХХК -н Байгаль орчны хэсгээс томилогдсон ажлын хэсэг 2022-2025 онд хийж гүйцэтгэсэн 14.35 га талбайн модны ургалтыг тогтоох тооллогыг 2025 оны 10 дугаар сарын 5 ны өдөр Байгаль орчны ахлах Г.Батбаяр, Байгаль орчны ажилтан Н.Олзийн-Ундрах, Байгаль орчны ажилтан Э.Хүрэлбаатар нар хамтран хийж гүйцэтгэв.

-2022 онд Шинэжинст сумын Уртын гол 2 -р баг Тусгай зөвшөөрөлтэй төслийн мод үржүүлгийн талбай, түр кемпийн орчинд 0.5 га талбайд 2,300 ширхэг мод салхины нөмөрлөгч ханлагаар,

-2023 онд 0.25 га мод үржүүлгийн талбайд 1,210 ширхэг нөмөрлөгчөөр

-2024 онд нутгийн иргэдтэй хамтран таримал ой Эрдэнэшанд багийн төвд 1 га, Уртын гол 2-р багийн төвд 0.25 га, Шинэжинст сумын төв 0.3 га, Эрдэнэшанд 3-р баг Хүрэнгийн үзүүр 1 га, Эхийн гол 2 га, нийт 4.55 га талбайд 7,703 ширхэг мод

-2025 онд 3.5 га мод үржүүлгийн талбайд 7849 ширхэг, 0.5 га кемпийн орчим 4717 ширхэг номорлогчоор

2022-2025 онд иргэд болон төслийн талбайн орчинд нийт 13.85 га, талбайд 27,723 ширхэг говь цөлийн бүсийн мод бутлаг ургамлаар таримал ой болон ногоон байгууламж салхины нөмөрлөгчөөр мод тарих ажлыг гүйцэтгэжээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 96/71 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтын “Ойн зурвасын жидиг тооллого явуулах” журмыг үндэслэн 13.85 га талбайд модны ургалтыг тогтоох тооллогыг явуулахад:

№	Талбайн нэр	Жишиг талбайн хэмжээ (м ²)	Линх тарьсан модны (шир)	Ургаж байгаа модны тоо (шир)	Хорогдсон модны тоо (шир)	Үүнээс				
						Мал амьтан идсэн	технологич хангагүй	Өвчин хортон	Цаг уурын шалтгаан	Усалгаа арчилгаа
1	Мод үржүүлгийн талбай	40000	10146	10146	0					
2	Түр кемпийн орчин	7500	5927	5927	0					
3	Эрдэнэшанд багийн төв	10,000	1510	1071	439					439
4	Хүрэнгийн үзүүр	10,000	1500	1089	411					411

5	Ургын гол багийн төв	2,500	810	450	360					360
6	Шинэжинет сумын төв	3,000	1800	1530	270					270
7	Эхийн гол	20,000	5640	1380	4260					4260
Хамгаалалтын ойн зураас										
1	Мод үржүүлгийн талбай	5,000	2300							
Ойжуулагч										
2	Хүрэнгийн үзүүр	10,000	1500	1089	411					411
3	Ордэнэглэд багийн төв	10,000	1510	1071	439					439
4	Эхийн гол	20,000	5640	1380	4260					4260
Бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэн, сад, нийтийн эзлбэр газар										
5	Шинэжинет сумын тал	3,000	1800	1530	270					270
6	Тослийн талбай, түр кеннийн орчинг	2	1210	1210						1210
Албан байгууллагын хашаанд										
Өрхийн хашаанд										
7	Ургын гол 2 баг	2,500	810	450	360					360

Тооллогын хүснэгтээр амьдралт 66 хувьтай ургасан байна. Ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн тайлан, мэдээ, газар дээр нь явуулсан тооллого, судалгаанаас үндэслэн комиссоос

ТОГТООХ НЬ:

Шинэжинет сумын “Эрдэнэ монгол” ХХК-н Баянхөндий уурхай 2022-2025 онд нийт 13.85 га, талбайд 28,323 ширхэг таримал мод ургасан буюу 66 хувийн ургалттай болохыг тогтоов.

АКТ ТОГТООСОН:

Байгаль орчны ахлах ажилтан:

ир/

Байгаль орчны ажилтан.....

Байгаль орчны ажилтан.....